Хайрт Монгол орноо мандуулъя !

ХИЛ СУДЛАЛ

ДХИС-ийн Хилийн Албаны Сургууль, Монголын Хил Судлалын Үндэсний нийгэмлэгийн онол- мэдээллийн сэтгүүл

15 дахь жилдээ Улиралд нэг удаа гарна

01-02/28-29
2012 он

АГУУЛГА

ХИЛ СУДЛАЛ БА ОНОЛ ПРАКТИК

Д.Дашдаваа Оросын Холбооны Улсын хилийн аюулгүй байдал

Х.Гөлгөө Байлдааны ажиллагааны ирээдүйн робот систем

Ч.Эрдэнэ Супер нэгдлийн онол

Х. Гөлгөө Улсын хил дээр барьж байгуулах боломжтой инженерийн авсаархан шийдэл бүхий гүүрүүдийн тухай

СУРГАЛТ, АРГА ЗҮЙ:

Г.Пушкин Хил хамгаалалтын тактикийн хичээлээр бүлгийн дасгал явуулах арга зүй.

Ж.Уганчимэг: Асуудалд суурилсан сургалт, түүний ач холбогдол

ХИЛИЙН ТҮҮХ

Ш.Арвай Миний ажлын үр дүнг хамт олны бүтээлч үйл ажиллагаа, үр дүнгээс салгах аргагүй

Т.Бадамханд Хилийн тагнуулын албаны түүхэн замнал.

Ц.Ганболд “Ёстой хүний тухай” найруулал

И.Сэржхүү Улсын хил хамгаалалтад Монгол ардын хувьсгалт цэрэг (Монголын ардын арми, зэвсэгт хүчин,)-ийн анги, салбарууд дэмжлэг үзүүлж ирсэн байдал, түүнд хийх дүн шинжилгээ

ГАДААДЫН ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

Ц.Ганболд Гадаад орнуудын хил хамгаалах байгууллагын тухай.

Х.Гөлгөө Курганы Хилийн цэргийн дээд сургууль дээр явагдсан оперативийн сургалтын тухай

ХИЛЧИН БА ХУУЛЬ

Д.Чинзориг: Монгол улсад хувийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан судалгаа.

Л.Бат-Очир Хууль бусаар Монгол улсын хил нэвтрэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж

ХИЛИЙН ЗӨРЧИЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ.

Сонсогч Т.Даваадоржийн илрүүлсэн хилийн зөрчлийн тухай

ЗӨВЛӨМЖ

Д.Нямдорж Алхмаа бүү голцгооё, алхмаа харин тоолцгооё

ХИЛЭЭС ТӨРСӨН УРАН БҮТЭЭЛ

Ш.Дулмаа Торгон хилийн манаанд.
Эх орон чинь дуудаж байна

ШИНЭ НОМ

Ш.Арвай Монгол улсын тусгаар тогтнол ба улсын хил.

ХИЛ СУДЛАЛ, ОНОЛ ПРАКТИК

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Орос улс /Эртний Орос, Оросын эзэнт гүрэн, ЗХУ, ОХУ/ өөрийн эдийн засаг, улс төр , соёлын бие даасан эрхийг батлан хэрэгжүүлэхдээ улсын бодлогодоо өөрийн хил дээр улс орныхоо тусгаар байдлыг батлан хамгаалах тодорхой зорилтуудыг шийдвэрлэж иржээ. Төр улс аяндаа үүсэж бүрэлдэх үйл явц нь дэлхийн улс төрийн газар зүйн дүр зураглалын хүрээнд түүний оршин тогтнохын илэрхийлэл болох бөгөөд , харин улсын хил ба түүний бүрдэл хэсгүүд нь эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлын нийтлэг шинж чанар, хэл, соёлын төрөл угсааны тогтворшилтоороо нийгмийн хүчний улс төрийн нөлөөллийн анхдагч хараа хязгаарыг зааглагч болж, тухайн улсын тусгаар тогтнолын баталгаа болж байдаг.

Орос орон ч энэ журмаас гажаагүй. Орос орон бүрэлдэн тогтсон явдал нь улс орны эдийн засгийн салбарын аюулгүй байдлыг хянах, худалдааны гол замууд болон хүн амаа хамгаалах, хил орчмын бүс нутагт цагийн байдлыг хянах зэрэг ажлыг бодитоор хангасан. 1000 гаруй жилийн тэртээ эртний оросын өмнөд болон баруун хойд хил дээр анхны хилийн заставууд бий болжээ. Заставуудыг барьж байгуулах, холбоо барих тогтолцоотой болгох, хил орчмын ард иргэдийн дундаас сонголт хийх, хил орчмын нутагт тагнуул явуулах талаар сайтар бодож төлөвлөсөн цогц арга хэмжээ авч байсныг археологийн олдвор болон түүхийн эх сурвалжууд баталдаг. Эртний оросын хилийн аюулгүй байдлын үндэс суурийг ийнхүү тавьжээ.

Хөгжлийн урт удаан хугацаа, олон тооны өөрчлөлтийн үр дүнд 21-р зууны эхээр ОХУ-ын хилийн алба нь тус орны хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны цөм болж бүрэлдэн тогтсон. Мөн чанартаа энэ нь улсын ашиг сонирхлыг хил дээр хангах нь олон зууны туршлагын үр дүн, улс орны харилцаа болон сүүлийн жилүүдэд нийгмийн амьдралд гарсан үйл явдлуудын хөгжлийн зүй тогтолт үр дүн юм.ОХУ-ын үндэсний аюулгүй байдал гэдгийг "улсын тусгаар тогтнол, засаглалын эх сурвалжийг тээгч болохын хувьд түүний олон үндэстнээс бүрдсэн ард түмний аюулгүй байдал" гэж ойлгодог. Төрийн бодлогод нийгмийн амьдралын өргөн салбарт болон улс орны гадаад , дотоод улс төр, эдийн засаг, цэрэг, мэдээлэл, хил, экологийн болон улс орны амьдралын бусад салбарт өөрийн орны ашиг сонирхлыг идэвхтэй хамгаалах тухай яригддаг. Улс орны ашиг сонирхол хилийн салбарт нийгмийн амьдралын бүхий л салбаруудтай холбогдон хилийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиглэлд хамгийн чухал болж ирдэг. Хилийн аюулгүй байдлын түвшин улсын хил ба ОХУ-ын хил орчмын нутаг дэвсгэр, бие хүн, нийгэм, улс орны амин чухал ашиг сонирхлыг хилийн салбарт бодит гадаад, дотоод аюул заналаас хамгаалах явдал болохынхоо хувьд улсын хилийн аюулгүй байдал, хилийн цагийн байдалтай нягт холбоотой улс орны тогтвортой байдлыг илэрхийлэгч чухал индикатор юм. Мөн чанартаа хилийн аюулгүй байдлыг хангана гэдэг нь үндэсний ашиг сонирхол дээр бүрэлдэн тогтсон улсын хилийн бодлогын гол илэрхийлэл юм.

Хилийн аюулгүй байдалд учрах аюул занал

ОХУ-ын хилийн аюулгүй байдлын өнөөгийн түвшинг судалж үзэхдээ 20-р зууны сүүлээр манай оронд болон дэлхий дахинд асар том цэрэг улс

төрийн болон нийгэм эдийн засгийн өөрчлөлт явагдсан гэдгийг анхаарч үзэх нь зүйтэй. Эдгээр нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын өнөөгийн байдалд нөлөөлж амьдралд, тэр тусмаа хилийн салбарт нийцсэн аюулгүй байдлыг хангах зарчмын шинэ хандлагуудыг боловсруулан хэрэгжүүлэхийг шаардаж байна

. Хилийн салбар нь юуны өмнө улс орны ашиг сонирхлын бусад олон салбаруудын дунд асар том байр суурийг эзэлдэг. Энгийнээр хэлэхэд хилийн салбар нь аливаа орны улс төр, эдийн засгийн амьдралын гадаад, дотоод 2 том салбарын огтлолцол дээр оршдог. Аливаа орны хөгжил тодорхой түвшинд дотоод өөрчлөлт, гадаад нөхцөл нөлөөллийн диалектик үр дүнг агуулсан "хилийн" шинжтэй байдаг.

Тухайн салбар бүрт бүрэлдэн тогтсон нөхцөл байдлын тогтвортой чанар нь хугацаа, шинж байдлын хувьд тогтвортой, заримдаа аливаа орны хилийн аюулгүй байдалд учрах аюул заналын "дасал болсон" цогцыг урьдчилан тодорхойлдог.

ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын үзэл санаа, үндэсний аюулгүй байдалд учрах аюул занал, улс орон, нийгэм, бие хүний амьдралын чухал салбаруудын нэг болох хилийн салбарын үндсэн зорилтуудыг санамсаргүй байдлаар ангилж үзээгүй. Одоо оршин байгаа улсын хилийн аюулгүй байдалд учирч буй аюул занал хэдэн арван жилийн тэртээ оршин байсан аюул заналын хоорондын зарчмын ялгаа эрс өөрчлөгдөж буй улс орны дотоод нийгэм, эдийн засаг болон улс төрийн тогтворгүй байдалд суурилан бүрэлдэн тогтож байгаад оршино.

Дотоод тогтворгүй байдлын үндсэн шалтгаан нь гадаад орчны өөрчлөлтийг араасаа дагуулдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр он жилүүдэд улс орны үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хоёр үндсэн хүчин зүйл бий болсон.

Эхний бүлэгт буюу гадаад хүчин зүйлд дараах зүйлсийг хамруулж үзвэл зохино.

1. Улс төр, үзэл суртал, эрх зүй, ёс суртахуун, соёлын болон бусад үнэт зүйлсийн тогтолцоо уналтанд орох

2. Сүүлийн 10 жилд улс орны хөгжлийн үндэс болсон санхүүгийн өөрчлөлт юуны өмнө эдийн засгийн тэнцвэртэй бус, сайтар бодож төлөвлөөгүй хуваарилалт

3. Ихэнхи бүгд найрамдах улсууд, зарим үндэсний тойрог болон бүс нутаг нийгмийн хөгжилдөө төвөөс зугтсан, харилцан холбоогүй нийгмийн хөгжлийг эрмэлзсэн шинжтэй байх г.м.

Дараах хүчин зүйлүүд 2-р бүлгийг бүрдүүлнэ.

1. Орос улс уламжлалт холбоотнуудаа алдаж улс орны геополтикийн байдал эрс муудаж нэг туйлт дэлхийн тогтолцоо бий болох

2. Орос орон нийгэм эдийн засгийн харилцааны дэлхий нийтийн тогтолцоонд түүхий эд экологи, газар нутгийн нөөц, хямд ажиллах хүчин, шинжлэх ухаан оюуны бүтээл, мөнгөний урсгалыг нийлүүлэгчийн үүргээр оролцох. Мөн түүнчлэн гадаад бараа таваарыг хэрэглэгч, экологийн хувьд аюултай бүтээгдэхүүн хаягдлыг үйлдвэрлэгч, бий болгогчийн үүргээр оролцох.

3. "Чөлөөт" болон "дарангуйлагч" соёл иргэншлийн хооронд "баруун болон дорныг сөргөлдүүлэх" бүс болгон ОХУ-ын евроазийн байршлыг ашиглах г.м.

Орос улсын үндэсний аюулгүй байдалд бүхэлд нь нөлөөлдөг эдгээр хүчин зүйлүүд хилийн аюулгүй байдалд учрах аюул заналд бодитойгоор илэрдэг. Эдгээрээс: - Түүхий эд бараа бүтээгдэхүүн, эрчим хүч, тээвэр, хүн ам болон бусад нөөцөөр баялаг болон цэрэг стратегийн чухал

ач холбогдол бүхий зарим бүс нутагт нөлөөлөх хүрээ

- НАТО дорно зүг рүү хүрээгээ тэлж, Орос Улс Хойд Атлантын эвслийн гишүүн орнууд болон НАТО -д элсэх боломжтой орнуудтай шууд хил залган оршдог.
- Хөрш зэргэлдээ зарим орнуудтай нутаг дэвсгэрийн хувьд хязгаарлалт хийж дуусаагүй, ОХУ-ын улсын хилийн зарим хэсгийг олон улсын эрх зүйн хувьд бүрэлдүүлж дуусаагүй.
- Зарим орнуудын зүгээс ОХУ-ын эсрэг газар нутгийн маргаан үүсгэх
- Холбооны зарим орнуудад гадны нөлөө үзүүлэх, түүний зарим оролцогчдыг тусгаар улсуудын холбооны орнуудын хувьд нийтлэг зорилтуудыг бий болгож шийдвэрлэх тогтолцооноос хасах
- Тус орныг баруунаас тусгаарласан " ариуслын хилийн бүс"-ийг байгуулах
- ОХУ-ын зүүн болон өмнөд хилийн зарим хэсэг бүрэн нээлттэй эсвэл хагас хаалттай байх
- Гадаадын орнуудын тусгай албадын зүгээс ОХУ-ын эсрэг тагнах турших үйл ажиллагааг явуулах, мэдээллийн нөлөөлөл (тэр дундаа соёлын болон шашны нөлөөлөл)
- Эдийн засгийн асуудлуудад суурилсан нийгэм задрах ерөнхий нийтлэг байдал үүсэж, улсын хил дээр хуулийн эсрэг үйл ажиллагаа явуулахад татан оролцуулж болох хүмүүсийн тоо нэмэгдэх
- Гадны алан хядах байгууллага, урсгалуудын үйл ажиллагаа идэвхжих, тэд улс орон, бүс нутгийн зарим хэсэгт орон нутгийн салан тусгаарлагч үзэлтнүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулах
- Угсаатан, шашин болон бусад зөрчлийн үндэс болдог "халуун цэг" оросын хил орчимд болон хөрш орнуудын нутаг дэвсгэрт байх
- Оросын болон хөрш орнуудын хилээр хууль бусаар зэвсэг нийлүүлэх явдал нэмэгдэх
- Гадаадын иргэд болон иргэншилгүй хүмүүсийн хууль бус цагаачлалын урсгал Оросын улсын хилээр дамжин гарах явдал нэмэгдэх
- ОХУ-ын хилээр мансууруулах бодисыг хууль бусаар нэвтрүүлэх
- Оросын эдийн засаг санхүү зээлийн тогтолцоонд бодитой хохирол учруулахуйц түүхий эдийн нөөц, бараа, бэлэн мөнгийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх
- Улс орны мэдээлэл болон оюуны чадамжийг бүрдүүлж байдаг шинжлэх ухаан архив, соёлын үнэт зүйлсийг хяналтгүйгээр хилээр гаргах
- Улс орны ургамлын болон амьтны генийн санд хохирол учруулах
- Амьтан, ургамлын аймгийн ховор болон устаж буй төрөл зүйлийг хэт их ашиг олох зорилгоор олборлон, байгалийн нөөцийг устгах
- Улсын хилийн орон зайд далай тэнгисийн био нөөцийг хяналтгүйгээр олборлох, дамлан худалдаалах, хил орчимд хориотой хулгайн ан хийх
- Оросын болон хөрш орны хил орчмын зарим хэсэгт хүн амын нийгмийн асуудлын үр дагавар нь болж гэмт хэргийн байдал хурцдах
- Шинээр хил бүрэлдэн бий болох, нийгмийн харилцааны бүлэглэлүүд задарсны улмаас орон нутгийн хүн ам болон улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны анхдагч нэгжүүдийн хоорондын уламжлалт харилцаа холбоо тасрах
- Оросын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүх түвшинд засаглалын бүрэн эрхт байдал төвлөрөхгүй байх
- Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны хэтийн хөгжлийн байр суурийг бодитоор боловсруулж дуусаагүй байх
- Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүтцийн зарим элементүүдийн хооронд цаг хугацааны

шаардлагад тохирохгүй мэдээллийн холбоо байх

- Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны зарим элементүүдийн ажиллагаа улс орны эдийн засгийн асуудлын үр дагавараас шалтгаалан олон жилийн туршид хангалтгүй санхүүжилттэй, техник хэрэгсэлтэй байх
- Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны боловсон хүчний чадамжийн үндэс нь болсон хилийн албаны офицер алба хаагчдын нийгмийн бодит баталгаа үгүй болох нийтээр дутуу дулимаг амьдрах
- Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны зарим бүтцийн нэгж элементүүдэд мэргэжилтэй боловсон хүчин хангалтгүй байх
- Зарим бүс нутагт аюул заналын шинж байдлын өөрчлөлтийн эрчимжилтээс хамаарч улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог сайжруулах ажил хоцрогдох
- Шийдвэрлэгдээгүй асуудал хуримтлагдсны үр дүн болж хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд дотоодын нийгэм эдийн засгийн хүндрэл өсөн нэмэгдэх
- Улс орны хилийн аюулгүй байдал хурцадсан талаар нийгэм бүрэн бус эсвэл буруу гажуу мэдээлэлтэй байх зэрэг нь үндсэн хүчин зүйлүүд юм.

Дээр дурьдсан улс орны хилийн аюулгүй байдалд учирч болох аюул заналууд цаашид нэмэгдэх нь дамжиггүй. Эдгээр нь улс орны амьдралын глобал гадаад улс төрийн болон эдийн засгийн салбараас эхлээд бүс нутгийн экологийн асуудал, хил орчмын нутаг дэвсгэрт гарч буй гэмт хэргийн өсөлттэй холбоотой олон асуудлыг багтааж байдгийг хялбар ажиглаж болж байна.

Хилийн аюулгүй байдлын зарим аюул заналын хувьд нягт хоорондын харилцаа хамаарал байдгийг хэлэх нь зүйтэй.

Жишээнь: хүнамнийгэмшихгүй байх, оршин суугчид гэмт хэрэгт олноор холбогдох, мансууруулах бодис, зэвсэг түгэн дэлгэрэх, нийгмийн зөрчил, бэрхшээл нэмэгдэх, тэрсүү үзэл, алан хядлага, салан тусгаарлах үзэл, нутаг дэвсгэрийн халдашгүй байдалд аюул занал учрах зэрэг нь нэг гинжний хэлхээсүүд юм. Нөгөө гинжний хэлхээсүүд нь нийгмийн зүгээс хилд төдийлөн анхаарал хандуулахгүй байх, офицерийн бүрэлдэхүүний асуудалд тоомсоргүй хандах, санхүүжилт хүрэлцэхгүй байх, боловсон хүчний хүрэлцээгүй байдал зэрэг юм.

Улсын хилийн аюулгүй байдалд учрах аюул заналын зарим дэд бүлгүүдийг түүхэн туршлагын үүднээс цогцоор гарган авч, үзэж болно.

Зарим гадаад, дотоод аюул занал гүнзгийрэх нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны дотор ноцтой хямрал гарахад хүргэж болох юм. Энэхүү дотоод тогтолцооны хямрал нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны хөгжил, улсын хилийн аюулгүй байдалд учирч болох аюул заналын өсөлтийн эрчимжилтээс хоцрох байдлаар илэрч нэмэлт аюул занал болдог.

Дээр дурьдсан улс орны хилийн аюулгүй байдалд учирч болох аюул заналууд цаашид нэмэгдэх нь дамжиггүй. Эдгээр нь улс орны амьдралын глобал гадаад улс төрийн болон эдийн засгийн салбараас эхлээд бүс нутгийн экологийн асуудал, хил орчмын нутаг дэвсгэрт гарч буй гэмт хэргийн өсөлттэй холбоотой олон асуудлыг багтааж байдгийг хялбар ажиглаж болж байна.

Хилийн аюулгүй байдлын зарим аюул заналын хувьд нягт хоорондын харилцаа хамаарал байдгийг хэлэх нь зүйтэй.

Жишээнь: хүнамнийгэмшихгүй байх, оршин суугчид гэмт хэрэгт

олноор холбогдох, мансууруулах бодис, зэвсэг түгэн дэлгэрэх, нийгмийн зөрчил, бэрхшээл нэмэгдэх, тэрсүү үзэл, алан хядлага, салан тусгаарлах үзэл, нутаг дэвсгэрийн халдашгүй байдалд аюул занал учрах зэрэг нь нэг гинжний хэлхээсүүд юм. Нөгөө гинжний хэлхээсүүд нь нийгмийн зүгээс хилд төдийлөн анхаарал хандуулахгүй байх, офицерийн бүрэлдэхүүний асуудалд тоомсоргүй хандах, санхүүжилт хүрэлцэхгүй байх, боловсон хүчний хүрэлцээгүй байдал зэрэг юм.

Улсын хилийн аюулгүй байдалд учрах аюул заналын зарим дэд бүлгүүдийг түүхэн туршлагын үүднээс цогцоор гарган авч, үзэж болно.

Зарим гадаад, дотоод аюул занал гүнзгийрэх нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны дотор ноцтой хямрал гарахад хүргэж болох юм. Энэхүү дотоод тогтолцооны хямрал нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны хөгжил, улсын хилийн аюулгүй байдалд учирч болох аюул заналын өсөлтийн эрчимжилтээс хоцрох байдлаар илэрч нэмэлт аюул занал болдог.

Улсын хилийн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх арга замууд

Дээр дурдсан болон шинээр бүрэлдэн бий болж буй аюул заналын хамрах хүрээ, хэмжээнд нийцүүлэн улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох асуудал манай орны хилийн аюулгүй байдлын тулгамдсан асуудал болоод байна.

Хилийн аюулгүй байдалд учирч болох цогц аюул заналыг саармагжуулах нь улс орны амьдралын гадаад улс төр, эдийн засаг, эрх зүй, нийгмийн бүх салбарт байдлыг хэвийн болгох зайлшгүй шаардлагыг хөндсөн олон чиглэлт үйл явц юм.

Хилийн аюулгүй байдлын үндсэн асуудлыг шийдвэрлэх нь бага боловч үйл ажиллагааны үндсэн 3 шугамтай байдаг. Үүнд:

1. Хилийн салбарт улс хоорондын харилцааны тогтолцоог тогтворжуулан бэхжүүлэх /улс орны хилийн аюулгүй байдалд нөлөөлдөг гадаад хүчин зүйлд хариу үйлдэл үзүүлэх/

2. Улс орны хөгжлийн ашиг сонирхлын эдийн засгийн чиглэлийг хилийн салбарт тэргүүн зэрэгт авч үзэх /улс орны хилийн аюулгүй байдлыг тодорхойлогч дотоод гол хүчин зүйлд хариу үйлдэл үзүүлэх/

3. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог хөгжүүлэн сайжруулах/тогтолцооны дотор хямрал гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд/

Улсын хилийн аюулгүй байдалд учирч болох аюул заналд нийцүүлэн улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох нь тухайн чиглэлийн хүрээнд өргөн хүрээтэй тодорхой үйл ажиллагаа явуулах нөхцөл болдог. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд өнөөгийн байдлаар хамгийн тулгамдаад байгаа практик арга замуудыг авч үзье:

- Улсын хил болон хилийн орон зайн цагийн байдалд мэдээллийн шинэ технологийг ашиглан үнэлгээ өгөх ажлыг сайжруулах, зайлшгүй мэдээллийг цуглуулж, нэгтгэн, системчлэх, дүн шинжилгээ хийх ажлыг идэвхжүүлэх, хавсарга болон онолын шинжтэй эдгээрээс үүдэн гарсанн чухал зөвлөмжүүдийг боловсруулах ажлын шуурхай чанарыг дээшлүүлэх

- Балтийн тэнгисийн орнуудын зөвлөл, ТУХН-ийн орнуудын Хилийн цэргийн командлагчдын зөвлөл, Беларус, Оросын Хилийн хорооны хүрээнд сонирхогч талуудын улс хоорондын хүчин чармайлтыг нэгтгэсний үндсэн дээр , Беларустай хамтран ажиллахад онцгойлон анхаарч, ТУХН-ийн орнуудын гадаад хил дээрхи аюулгүй байдлыг хамтран хангах тогтолцоог бүрэлдүүлэхэд оролцох, хилийн салбарын зорилтуудыг шийдвэрлэхэд Евразийн эдийн засгийн нийгэмлэгийн гишүүн орнуудтай

хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, сонирхогч талуудын хилийн аюулгүй байдлыг хангах харилцан ажиллагааг явуулах үүднээс Хар далайн болон Ази, Номхон далайн бүс нутагт хамтын ажиллагааг хөгжүүлэх

- Хөрш орнуудтай нутаг дэвсгэрийн асуудлаа шийдвэрлэж дуусгах, зарим газар зүйн обьектын эрх зүйн статустай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, хилийн төлөөлөгчдийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг үргэлжлүүлэн бий болгох, хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, Оросын ХХА-ны тусгай төлөөлөгчдийн хөрш болон бусад оронд ажиллах тогтолцоог хөгжүүлэх зэрэгт оролцох

- Бусад орны сонирхогч хилийн байгууллагуудад хил хамгаалалтын техник хэрэгслийг сурталчлан, дэлгэрүүлэхэд зөвлөх болон бусад байдлаар оролцох, гадаад орнуудын хил хамгаалалтын техник хангалт, хилийн байгууллагуудын мэргэжилтэнг бэлтгэх салбарт хамтран ажиллах

- Үр ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаа, , оросын эдийн засгийг олон улсын эдийн засагтай холбох таатай нөхцөлийг бий болгоход нөлөөлөхүйц хилийн аюулгүй байдлыг хангах орчин үеийн тогтолцоог хил дээр бий болгох, тухайлбал улс орны эдийн засгийн хөгжлийн үүднээс авч үзвэл хилийн хяналтын үр ашгийг нэмэгдүүлэхээр ажиллаж буй шалган нэвтрүүлэх боомтын цаашдын хөгжлийг хангах

- Улсын хилээр ачаа, бараа тээвэрлэх ажил хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг идэвхжүүлэх, хулгайн ан, далай, тэнгисийн био нөөцийг ашиглах, шамшигдуулахаас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, загас агнуурын обьект болон загас агнуурын бүтээгдэхүүнтэй холбоотой гадаад худалдааны ажиллагааг хянах, био нөөцийг зүй зохистой ашиглах, био нөөцийн хамгаалалтын тогтолцоог сайжруулахад оролцох

- Зэвсэг, мансууруулах бодис, архи согтууруулах бүтээгдэхүүний хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, стратегийн чухал түүхий эд, нөөцийг их хэмжээгээр хууль бусаар хилээр тээвэрлэх зэрэг үйл ажиллагааны эсрэг авч явуулах арга хэмжээг чангатгах

- Улсын хилийн ойролцоо гарсан бүс нутгийн шинжтэй зэвсэгт мөргөлдөөнийг намжаахад оролцох, гадаадын террорист байгууллагуудын эсрэг үйл ажиллагаа явуулж, хил орчмын бүс нутагт зэвсэг болон зэвсэгт тэмцэл хэрэглэгдэх бусад хэрэгслийг хуримтлуулах, дэлгэрүүлэхтэй тэмцэх

- ОХУ- ын Хилийн алба, гүйцэтгэх засаглалын бүх түвшний байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, ОХУ- ын Ерөнхийлөгчийн холбооны тойргууд дахь бүрэн эрхт төлөөлөгчдийн харилцан хамтын ажиллагааг зохион байгуулах

- ОХУ- ын Хилийн албаны үйл ажиллагааг ОХУ- ын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд үүрэг гүйцэтгэдэг бусад яамд, газар, албадтай холбох механизмыг сайжруулах

- 2000 оны 11.29-ний "Улсын хил дээр ОХУ- ын ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээний тухай", 11. 9-ний Аюулгүй байдлын зөвлөлийн цэргийн байгуулалтын талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтэд үндэслэн хилийн аюулгүй байдлын түвшинг сайжруулах, Улсын хил ба далай тэнгисийн био нөөцийг хамгаалах шинэ үзэл баримтлалыг боловсруулах, Улсын хилийг тохинуулах холбооны зорилтот хөтөлбөрийг боловсруулах

- Хилийн албыг чанарын шинэ түвшинд хүргэх замаар ОХУ- ын хилийн аюулгүй байдлын түвшинг сайжруулах, Хилийн албыг төрийн тусгай цэргийн байгууллага болгон үе шаттайгаар төлөвшүүлэх, Хилийн

албаны цэрэг, байгууллагуудыг цаашид шинэчлэн зохион байгуулсны үр дүн болж байгаа хүч, хэрэгслээ зүй зохистой , үр ашигтай ашиглах

- Хилийнаюулгүйбайдлыгхангах тогтолцоооны бүх бүрдлүүд, санхүү, ар тал, материал техникийн хувьд үйл ажиллагааг нь бүрэн хангах, цэргийн албаны үйл ажиллагааг боловсон хүчнээр хангах, боловсон хүчнийг сонгох, томилох, офицеруудын орон байр ахуй, нийгмийн хамгаалалтай холбоотой асуудлуудыг чанартай шийдвэрлэх, ХА-ны офицер, цэрэг, ажилтнуудад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь бий болгох замаар офицер бүрэлдэхүүнээ хадгалж үлдэх

- Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны цөм нь болсон Хилийн албаны улс төр, эдийн засаг, хууль сахиулах, нийгэм соёлын ач холбогдол, улс орны амьдралд хилийн салбарын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хилийн аюулгүй байдлын асуудал хурцадсан талаар олон нийтийг мэдээллээр хангах тогтолцоог сайжруулах, орон нутгийн хүн ам, казахын холбоо, хил хамгаалахад туслах хүчин, залуучууд, хүүхдийн боловсрол, спортын байгууллага, хил орчмын клуб, байгууллагуудтай хамтран ажиллах, мөн түүнчлэн хилч - эх оронч үзлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зэрэг болно.

Тус орны хилийн аюулгүй байдлыг хангах хамгийн тулгамдсан асуудлуудыг бид авч үзлээ. Гэхдээ энэ нь хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх үндсэн арга замын бүрэн жагсаалт биш юм.

Тус орны хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог сайжруулах бүхий л ажлын үндэс болсон эрх зүйн хэм хэмжээт үйл ажиллагаа нь хилийн салбарт явагдаж буй үйл явцыг засаж залруулах чиглэл юм. ОХУ- ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хилийн салбарт зайлшгүй шаардлагатай эрх зүйн хэм хэмжээний бааз суурийг бий болгох нь төрийн анхдагч зорилт юм хэмээн тодорхойлсон нь тохиолдлын зүйл биш юм.

Хурандаа Д.Дашдаваа /ДХИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал бөгөөд хүрээлэнгийн захирал/

БАЙЛДААНЫ АЖИЛЛАГААНЫ ИРЭЭДҮЙН РОБОТ СИСТЕМ



АНУ-ын Зэвсэгт хүчний хөгжлийн хэтийн хөтөлбөрт онцгойлон анхаарч байгаа нэг чиглэл нь байлдааны ажиллагааны ирээдүйн систем (Future Combat System - FCS), зайнаас удирдлагатай газрын байрлалтай машин Unmanned Ground Vehicles - UGV) голлох байрыг эзлэж байна.

21-р зуун бүхэлдээ оюунлаг роботтехникийн системийн зуун гэдэгтээ хэн ч маргахгүй нь мэдээж. Жишээ болгон машины үйлдвэрийг харахад бүхэл бүтэн роботуудаас бүрдсэн угсралтын цех байх бөгөөд хүн зөвхөн үйлдвэрлэлийн ажиллагааны явцыг л хянаж байх болжээ. Робот техник нь нийгмийн амьдралд бүрэн хэмжээгээр нэвтрээд зогсохгүй цэргийн салбарт ч өргөн хүрээтэй нэвтрэх боллоо.

Цэрэг-эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд өөрийн армийн зэвсэглэлдээ төрөл бүрийн роботуудыг өргөнөөр нэвтрүүлж байгаа тэдийгүй үндэсний хөгжлийн эрхтэйгээр авч үзээд маш их ач холбогдол өгч байна. Ийм төрлийн роботуудын зөвхөн төрөл нь хэдийн 800 гаруй болж тооны хувьд хэдэн мянгаар тоологдох болсон нь дээрхи ач холбогдлыг батлаж байна.

Өнөө үед Афганистан, Ирак зэрэг улс оронд явагдаж байгаа байлдааны ажиллагаанд 6000 гаруй төрөл бүрийн зориулалт бүхий робот техникүүдийг ашиглаж байна. АНУ-ын Зэвсэгт хүчний хуурай замын хүчний робот болон нисэгчгүй нисэх хэрэгслийн системийг зохицуулах асуудал эрхлэсэн департаментын удирдагч хурандаа Джона Баркийн мэдэгдсэнээр энэ тоо улам бүр нэмэгдэх болно гэжээ.


Тухайлбал дээрх хоёр оронд ашиглаж байгаа роботуудын тоо 2004 онд 162 харин 2007-2010 онд 5000 хүрч нэмэгдсэн байна. АНУ-ын зүгээс байлдааны нисэх хэрэгслийн тооны 1/3 хүртэл хувийг нисэгчгүй нисэх онгоц байлгахаар зорьж байгаа бөгөөд ялангуяа дайсны гүнд цохилт өгөх хэрэгслийн тоог улам бүр нэмэхээр төлөвлөж 2015 он гэхэд газрын зориулалттай байлдааны машинуудын 1/3 –ийг роботжуулах бодлого барьж байгаа.

Газрын байрлалтай робот машинуудын нилээдгүй хувийг урьд нь ашиглаж байсан бөгөөд тухайлбал тагнуулын ажиллагаа явуулах, тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох



зорилгоор түгээмэл ашиглаж байсан.

Одоогоор нилээд тооны зайнаас удирдлагатай газрын байрлал бүхий машинуудын хувилбарыг боловсруулан дуусгаад байгаагийн хамтаар цаашдаа робот машинуудаар зэвсэглэсэн бүрэлдэхүүнийг бий



болгохоор зорьж байна. Ингэснээр бие бүрэлдэхүүний хохиролыг багасгах, байлдааны ажиллагааны зарим төрлүүдэд ялангуяа хотын нөхцөлд байлдааны ажиллагаа явуулах, үр дүнд хүрэх хамгийн ашигтай хэрэгсэл болон хөгжих хандлагатай байна.

2030 он хүртэл "байлдааны ажиллагааны ирээдүйн систем" (Future Combat System — FCS) төслийн хүрээнд газрын байрлал бүхий хэд хэдэн систем тэр дотроо зайнаас удирдлагатай машинуудыг (Unmanned Ground Vehicles) бүтээх бөгөөд үгчлэн орчуулбал "экипажгүй газрын байрлалтай машин" гэсэн үг юм.

Энэ төслийн хүрээнд:

- Зэвсэглэсэн робот (Armed Robotic Vehicle (ARV) –тагнуулын, дайрагч машинууд

- Олон талын ажиллагаатай дэмжих зориулалтын машинууд (Multifunctional Utility Logistics and Equipment platform) (MULE) тагнуулын, саперын, тээврийн гэх мэт

- Бага оврын нисэгчгүй машинууд Small Unmanned Ground Vehicle (SUGV).

- Хүнд зэвсгийн робот машинууд ARV

Хүнд зэвсгийн төрлийн роботууд нь ихэвчлэн 5-6 тн жинтэй, 6 хөтлөгч дугуй бүхий тавцангууд байх бөгөөд тагнуул, галын дэмжлэгийн, цэргийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бүтээгджээ.


Анхлан боловсруулахдаа дайрагч хувилбарын ARV-Assault загваруудаа 30 мм-ийн эргэх цамхаг бүхий их буугаар зэвсэглэхээр тооцсон бөгөөд гол зорилго нь хуягласан техникүүдийг ашиглахад аюултай. эрсдэл ихтэй чиглэлүүдэд байлдааны ажиллагааны тэргүүн эгнээнд ажиллаж явган цэргийг галаар дэмжих явдал юм.

Дараагийн хувилбар нь тагнуулын зориулалттай (ARV-RSTA) бөгөөд цамхагийн оронд нь телекамерийн хяналтын дуран, төрөл бүрийн мэдрэгчүүд байрлуулж улмаар салбаруудын хооронд мэдээлэл дамжуулах, дахин дамжуулалт хийх, тагнуул хийх зорилготой юм.

Эдгээр төслүүд нь өөрийн үнэ. өртөг өндөртэй байснаас шалтгаалан FCS хөтөлбөрийн үндсэндээ хаасан боловч цэргийн төрөл бүрийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр цаашид үргэлжлүүлэн сайжруулах арга хэмжээ одоо ч явагдсаар байгаа юм байна. Хүнд зэвсгийн системийн робот машины нэг төрөл нь «Spinner» юм.

Робот машин Spinner (бяц дарагч)

2001 оноос эхлэн жолоочгүй газрын хэрэгслийг бүтээх хөтөлбөр UGCV (Unmanned Ground Combat Vehicle) хэрэгжиж эхлэсэн бөгөөд энэ хөтөлбөрт цэргийн мэргэжилтнүүдийн зүгээс гурван үндсэн шаардлага тавьжээ



Үүнд:

- Урт хугацааны туршид ашиглах (ажиллуулах/ боломжтой байх. Тухайлбал 14 хоногоос доошгүй хугацаатайгаар ажиллах, нэмэлт цэнэггүйгээр 450 км-ээс багагүй зай туулах)

- Янз бүрийн саадыг туулах чадвар (350 хэмийн налууд явах, 2м гүн, 1 м өндөр саадыг төвөггүй туулах)

- Даац сайтай байх (Өөрийн жингийн 25 хувиас илүү ачаа ачих боломжтой байх)

Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд АНУ-ын Үндэсний робот техникийн инженерийн төв, Карнеги Меллоны их сургууль, Бойнг пүүс, NREC төвтэй дүүжин болон хэт жижиг удирдлагын тоноглолын пүүсүүд оролцжээ.

Хоёр жилийн туршид тасралтгүй эрчимтэй ажилласаны үр дүнд Spinner –ыг бүтээж чадсан бөгөөд газар орны янз бүрийн нөхцөлд , байлдааны ажиллагааны ямар ч үед , цаг агаарын тохиромжгүй нөхцлүүдийг үл харгалзан тавигдсан үүргийг бүрэн биелүүлэх боломжтой болохоо харуулжээ.


2001 оноос UGCV хөтөлбөртэй зэрэгцэн PerceptOR (Perception for Off-Road Robotics) - замгүй газарт ажиллах роботын хүлээн авах боломж буюу электрон тархины сэрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ хөтөлбөр нь жолоочгүй машин замгүй газруудад ажиллах үедээ өөрийгөө автоматаар баримжаалах болон электрон тархины системийг хэрхэн ашиглахтай холбогдсон нарийн төвөгтэй ажиллагаанд сургах өөрөөр хэлбэл тархинд нь ой санамж өгөх асуудал юм.

Ингээд 2002 оноос эхлэн маш хүндрүүлсэн нөхцөлд урьдаас сонгоогүй замналын дагууд туршилт хийж эхлэсэн ба энэ туршилтыг маш амжилттай туулж янз бүрийн аюул, саадыг илрүүлэх урьдчилан сэргийлэх талаар бүрэн чадвахитай болохоо харуулжээ.

2004 оноос шинэ хөтөлбөр DPI — UGCV Perceptor Integration –ийг хэрэгжүүлэх болсноор илүү өндөр бүтээмж бүхий шинэ загварын машин Crusher-ийг бүтээж эхлэсэн байна.

РОБОТ CRUSHER (эвдлэгч, няц дарагч).

Энэ машин нь маш хөдөлгөөнлөг, удирдахад уян хатан бөгөөд ашиглахад найдвартай



төдийгүй жингийн хувьд 29 хувиар хөнгөн болсноороо өмнөх загвараасаа ялгарна.

Crusher нь CTC Technologies ашигласан их биетэй, бүхээг нь 5,1х2, 6х1,52м хэмжээтэй, маш бат бөх хөнгөн цагаан хоолойнууд, титанаар хийсэн зангилаануудаас бүрдэнэ.

Зөөлөвчүүд нь маш сайн чанарын гангаар хийгдсэн нь цохилт доргилтоос хамгаалагдсан байдгаараа онцлог юм. Машины газраас дээших зайг 0-0,76 м хүртэл өөрчлөх боломжтой бөгөөд 1,22 м өндөртэй саад, 2 м өргөн шуудуу, 400 –ийн налууг саадгүй туулна.

Хөдөлгүүр нь бага оврын цахилгаан дизель бөгөөд бараг дуу чимээгүй ажиллана. Хөдөлгүүрийн чадал нь 72 морины хүчтэй, тасралтгүй ажиллагааг хангах 58 кВт хүчтэй генераторoор зай хураагуурыг цэнэглэх бөгөөд дунд зэргийн бартаа саадтай газар орон дээр 6,5 тн жинтэй их биеэ 42 км/цаг хурдлах боломжоор хангана.

Тээвэрлэх ачааны дээд хэмжээ нь 3600 кг. Энэхүү машиныг оператор тусгай бүхээгнээс алсын зайнаас удирдах бөгөөд компьютерийн дэлгэц

дээр жирийн машин жолоодохын нэг адил жолоог эргүүлэх, газын гишгүүр гишгэх зэргээр удирдана.

Робот машин APD.

Crusherийн дараагийн загвар нь жолоочгүй робот машин (Autonomous Platform Demonstrator — APD) бөгөөд жин, хөдөлгөөнлөг байдал,



ажлын бүтээмж, оврын хэмжээний хувьд тавьсан шаардлагыг бүрэн хангахуйцаар бүтээгдсэн дараагийн үеийн роботын бүхий л шинж төрхийг хадгалж чаджээ.

Бодит жин нь 9,5 тн, урт нь 4,57 м, ба 1 м өндөр ханыг туулна. Өөрийн байршлыг тодорхойлох автомат систем ANS –ээр тоноглогдсон нь GPS-тэй хослон ашиглагдсанаар өгсөн чиглэлд бие даан 80 км/цагийн хурдтайгаар хөдөлгөөн үйлдэх боломжийг хангасан байна.

APD-ийн сайжруулсан загвар нь 2009 оны 8 сард бэлэн болсон бөгөөд бүхий л туршилтыг амжилттай давжээ. 2010 оны 6 сард (Aberdeen Proving Ground) Абердинийн туршилтын талбайд туршигдсан бөгөөд өнөөгийн байдлаар 3000 км-ээс дээш замыг туулсан ба зэвсэглэлд авах асуудал тодорхой бус шалтгаанаар 10 жил хүлээгдэж байгаа гэнэ.



Дунд ангилалын роботууд буюу төрөл бүрийн команд дохиог биелүүлэх, байлдааны ажиллагааг дэмжих систем (SMSS-систем).



Байлдааны талбар дээр салбар нэгжүүдийг дэмжих роботжуулсан систем нь операторoос роботыг



удирдах хугацааг хэмнэх, байлдааны талбар дээр бие даан шилжин байрлах нөхцлийг хангах боломжийг олгодог.

Энэ машин робот нь 1814 кг жинтэй, дунд зэргийн бартаа саадтай газар орон дээр 40 км/цаг хурдлах ба 450 кг хүртэл ачааг зөөвөрлөх болмжтой. Нөөц явалт нь 160 км.

Удирдлагын 4 горимтой. Тухайлбал Машины бүхээгнээс гараар удирдах, телехяналтын удирдлага, автоматаар хөдөлгөөн үйлдэх ба ажиллагааг автоматаар хянах үйлдэл юм.

Бүхээгийн зураг авах ладар мэдрэгч нь өмнөө байгаа газар орны гурван хэмжээст байрлалын зураг авах ба ладараас авсан мэдээг боловсруулалт хийх, шийдвэр гаргах эсвэл операторoос тусламж хүсэх ажиллагааг бие даан гүйцэтгэнэ.

Байлдааны талбараас шархдсан хоёр хүртэл цэргийн албан хаагчийг нүүлгэн шилжүүлэх ба телехяналтын төхөөрөмж суурилуулснаар газар орны туршуул хийх, гудамж замын байдал, барилга байгууламжийн дотор талыг ч харах боломжтой болно.

Энэхүү робот нь Мк-19 загварын гранат шидэгч танк эсэргүүцэх Javelin пуужингаар зэвсэглэсэн. Логкид Мартин пүүс нь цаашдаа бүрэн автомат ажиллагаа бүхий байлдааны, тагнуулын , эргүүлийн машинуудыг бүтээхээр зорьж байгаа бөгөөд эдгээр машинууд нь зайнаас удирдах системгүйгээр давшиж байгаа цэргийн араас хоцрохгүйгээр хөдөлгөөн үйлдэж тэдгээрийн ажиллагааг дэмжих ёстой юм байна.

Барууны хэвлэлүүдэд бичиж байгаагаар Америкийн цэргийнхэн MULE ба SMSS загварын байлдааны роботуудыг байлдааны ажиллагааны нөхцөлд, газар орон дээр туршихаар ойрын үед Афганистан руу илгээхээр төлөвлөж байгаа болно.

Робот машин Gladiator.
/ Гладиатор/

АНУ-ын Тэнгисийн цэргийн хүчний судалгаа шинжилгээний удирдах газар, Батлан хамгаалах зориулалтын толгойн нийгэмлэгээс хамтран TUGV (Tactical Unmanned Ground Vehicle — тактическая наземная беспилотная машина) тактикийн зориулалт бүхий газрын жолоочгүй машин бүтээх хөтөлбөр боловсруулсаны үр дүнд Гладиатор маягийн роботыг бүтээжээ.

Гладиатор нь зайнаас удирдлагатай тагнуулын зориулалт бүхий робот бөгөөд хими-радиацийн аюултай




газар орон дээр болон буудалцаан болж байгаа аюултай бүсэнд эрэл-тагнуулын ажиллагаа явуулах, туулж өнгөрсөн замналаа санах, заасан газарт хүрэлцэн очих, өмнөх замналдаа гаргасан алдаануудаа оруулахгүйгээр эргэн санах чадвартай, хуягласан обьект юм.



Роботуудын давуу чанар нь хөдөлгөөнлөг, үнэ өртөг хямдтай, устгагдах магадлал багатай, урт хугацааны туршид амьдрах чадвар сайтай зэрэг үзүүлэлтээр хэмжигдэх бөгөөд зарим тохиолдолд хаягдал материалаар ямар нэгэн хамгаалалтын хуяг халхавчгүйгээр хийж бүтээх боломжтой.

Гладиаторын анхны загвар нь 7,62 мм-ийн пулемётоор зэвсэглэсэн ба харин хоёрдох хувилбар нь оврын хувьд багасч урт нь 1,78 м, өргөн нь 1,12 м, өндөр нь 1,35 м болж жингийн хувьд нийлүүлэх төхөөрөмж







тоноглолоос хамаарч 730-1000 кг хооронд хэлбэлзэх болсон .

Энэхүү машин дээр зайнаас удирдлагтай тогтворжуулсан систем SWARM (Stabilised Weapon And Reconnaissance Mount)-ийг суулгаж өгсөн бөгөөд 5,56 7,62, 12,7 мм-ийн калибрь бүхий зэвсэглэлүүд суурьлуулсан ба өдөр шөнийн дуран харааны хэрэгслүүдээр тоногложээ.

бүрэн тоноглогдсон, ачааны хэсэгт нь утаан хөшиг тавихад зориулагдсан төхөөрөмжийг байрлуулсаны зэрэгцээ пулемет болон винтовыг суурилуулах боломжтой. Ойролцоогоор 3 тн жинтэй, цэргийн зориулалт бүхий Humvee жипээр тээвэрлэх боломжтой.

Роботын хөдөлгөөн нь зай хураагуураас тэжээгдэх цахилгаан хөдөлгүүрээр дамжин дизель-





Дээрхи тоноглолуудаас гадна дүрсийн камер, лазерийн чиглүүлэгч, дуу чимээгээр мэдрэгч, хими-бактерилогийн болон хими-радиацийн хордолтоос сэргийлэх мэдрэгчүүд, GPS-ийн багажийг нэмэлт болгон суулгажээ.

Гладиаторын 3 дахь хувилбар нь 6 дугуйтай, бүрэн хөтлөгчтэй, эргэн тойрондоо хяналт хийх боломжтой. Тагнуулын багаж хэрэгсэлээр өвч

генераторыг ажиллагаанд оруулна. Хар зам дээр 26 км/цаг, харин шороон замд 2 дахин бага хурдаар явах ба 1м өргөн нүх, 70 см гүнтэй усан саадыг туулах боломжтой.

2005 оны 2 сард Карнеги Мелоны их сургууль АНУ-ын Батлан хамгаалахын үйлдвэрүүдээс 26,4 сая долларын зардлыг гаргуулсанаар USD хөтөлбөрийн хүрээнд Гладиатор

загварын 6 ширхэг туршилтын загвар гаргажээ.

Хэрвээ туршилт амжилттай болбол АНУ-ын БХЯ 200 нэгжийг үйлдвэрлүүлэх захиалга өгөхөд бэлэн гэдгээ нотлож зарим загварыг байлдааны нөхцөлд туршин шалгах ажиллагаа нь 2009-2010 онд явагджээ.

Роботуудын тусламжтайгаар шийдвэрлэж болох тактикийн үүргүүд:

Байлдааны ажиллагааны зориулалт бүхий роботуудыг тусгай албад, цэрэг цагдаагийн хүчинд ямар хэлбэрийн операци, байлдааны ажиллагаанд ямар ч зорилгоор ашиглах бүрэн боломжтой боловч хамгийн чухал нь тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох, алан хядах зохион байгуулалттай ажиллагааны эсрэг тэмцэх болон улсын онц чухал обьектуудын хамгаалалтанд ашиглах нь илүү үр ашигтай гэж үздэг байна.

Үүний тулд байлдааны роботуудаар дараах тактикийн чанартай үүргүүдийг шийдвэрлүүлж болох юм:

Тэсэлгээний ажлын чиглэлээр

– тэсэлгээний төхөөрөмжийг эрж хайх болон дүгнэлт хийх

-Дэлбэрэх төхөөрөмжүүдийг устгах болон зөөвөрлөх

-Дэлбэрэх бодисыг аюулгүй болгох болон задлан буулгах

-Газар орон, обьектод хими-радиацийн тагнуул хийх

Алан хядах ажиллагааны эсрэг ажиллагааны үед

-Радиоэлектрон саатуулга тавих, утаан болон бусад тусгай хөшиг үүсгэх

-Зарим тусгай ажиллагааны зэвсэг, техникийг хүргэх болон тээвэрлэх

-Хамгаалж байгаа болон нууц обьектуудад нууцаар нэвтрэн орох

-Зарим нутаг дэвсгэр, обьектын байдлын талаар дүрс бичлэгийн тагнуул хийх, радиоэлектроны болон дуут ухуулга явуулах

-Зарим саад, байгууламжийг эвдлэх

-Галын цэгийг тогтоох болон анхаарал сарниулах зорилгоор буудлагын гал явуулах

Обьетыг хамгаалах үед

-Тухайн обьектуудын орчимд эргүүл хийх ба үргэлжлэсэн урт хэсгийг халхлах

-Обьектод нэвтрэн орох гэсэн үйлдлийг таслан зогсоох

-Хууль, ёсыг зөрчигчдийн үйл ажиллагааг тасалдуулах

Дээр дурьдсан олон үүргийг янз бүрийн нөхцөлд, янз бүрийн обьектуудад хийж болно. Тухайлбал:

-Нийтийн тээврийн хэрэгслийн обьектуудад / хотын болон хот хоорондын тээвэр, төмөр зам, нисэх буудал, усан болон автозамын тээврийн хэрэгслүүдэд/

-Иргэдийн болон хувь хүмүүсийн амьдарч , үйл ажиллагаагаа явуулж байгаа орчин /орон сууц, үйлдвэрийн газар, барилга байгууламж, албаны өрөө тасалгаа гэх мэт/

-Улсын болон хувийн томоохон үйлдвэрийн газрууд ялангуяа нефть-химийн үйлдвэр, эрчим хүчний төвүүд, бусад чухал газрууд

Эх булаг нь PROMT 9.0 на http://www.promt.ru сайтаас орчуулав.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАНД РОБОТЫН ОРОЛЦОО.

Өмнөт Солонгос улс Хойд Солонгостой хил залгаж байгаа хэсэгтээ хоёр төрлийн байлдааны роботыг ашигладаг. Эдгээр роботууд нь хүний дуу яриаг ялгах, таних болон гал нээх ажиллагааг гүйцэтгэх бөгөөд өмнөт Солонгосын 400 сая орчим вонын өртөгтэй.

Туршилтын үр дүн нааштай гарсан нөхцөлд нийт хилийн зурвасын дагуу тавих болно гэж цэргийн холбогдох мэргэжилтнүүд батлаж байгаа юм байна. Ажиллагааны гол зарчим нь дулааныг болон хөдөлгөөнийг мэдрэх ажиллагаа бөгөөд хүлээн авсан дохиог удирдлагын төвдөө илгээзнэ. Төв дээр байгаа удирдлагын оператор улсын хил зөрчсөн этгээдийг дуу болон дүрсийн роботын тусламжтайгаар таних боломжгүй бол 40 мм-ийн автомат гранатмёт гал нээж үг зөрчлийг таслан зогсоодог. Энэхүү машиныг Самсунг Течвин нэртэй консирциумын толгойн компанитай хамтран бүтээжээ.

АНУ-ын Зэвсэгт хүчний хөгжлийн хэтийн хөтөлбөрт онцгойлон анхаарч байгаа нэг чиглэл нь байлдааны ажиллагааны ирээдүйн систем (Future Combat System - FCS), зайнаас удирдлагатай газрын байрлалтай машин Unmanned Ground Vehicles - UGV) голлох байрыг эзлэж байна.

21-р зуун бүхэлдээ оюунлаг роботтехникийн системийн зуун гэдэгтээ хэн ч маргахгүй нь мэдээж. Жишээ болгон машины үйлдвэрийг харахад бүхэл бүтэн роботуудаас бүрдсэн угсралтын цех байх бөгөөд хүн зөвхөн үйлдвэрлэлийн ажиллагааны явцыг л хянаж байх болжээ. Робот техник нь нийгмийн амьдралд бүрэн хэмжээгээр нэвтрээд зогсохгүй цэргийн салбарт ч өргөн хүрээтэй нэвтрэх боллоо.

Цэрэг-эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд өөрийн армийн зэвсэглэлдээ төрөл бүрийн роботуудыг өргөнөөр нэвтрүүлж байгаа төдийгүй үндэсний хөгжлийн эрхтэйгээр авч үзээд маш их ач холбогдол өгч байна. Ийм төрлийн роботуудын зөвхөн төрөл нь хэдийн 800 гаруй болж тооны хувьд хэдэн мянгаар тоологдох болсон нь дээрхи ач холбогдлыг батлаж байна.

Өнөө үед Афганистан, Ирак зэрэг улс оронд явагдаж байгаа байлдааны ажиллагаанд 6000 гаруй төрөл бүрийн зориулалт бүхий робот техникүүдийг ашиглаж байна. АНУ-ын Зэвсэгт хүчний хуурай замын хүчний робот болон нисэгчгүй нисэх хэрэгслийн системийг зохицуулах асуудал эрхлэсэн департаментын удирдагч хурандаа Джона Баркийн мэдэгдсэнээр энэ тоо улам бүр нэмэгдэх болно гэжээ.

Тухайлбал дээрх хоёр оронд ашиглаж байгаа роботуудын тоо 2004 онд 162 харин 2007-2010 онд 5000 хүрч нэмэгдсэн байна. АНУ-ын зүгээс байлдааны нисэх хэрэгслийн тооны 1/3 хүртэл хувийг нисэгчгүй нисэх онгоц байлгахаар зорьж байгаа бөгөөд ялангуяа дайсны гүнд цохилт өгөх хэрэгслийн тоог улам бүр нэмэхээр төлөвлөж 2015 он гэхэд газрын зориулалттай байлдааны машинуудын 1/3 –ийг роботжуулах бодлого барьж байгаа.

Газрын байрлалтай робот машинуудын нилээдгүй хувийг урьд нь ашиглаж байсан бөгөөд тухайлбал тагнуулын ажиллагаа явуулах, тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох зорилгоор түгээмэл ашиглаж байсан.

Одоогоор нилээд тооны зайнаас удирдлагатай газрын байрлал бүхий машинуудын хувилбарыг боловсруулан дуусгаад байгаагийн хамтаар цаашдаа робот машинуудаар зэвсэглэсэн бүрэлдэхүүнийг бий болгохоор зорьж байна. Ингэснээр бие бүрэлдэхүүний хохиролыг багасгах, байлдааны ажиллагааны зарим төрлүүдэд ялангуяа хотын нөхцөлд байлдааны ажиллагаа явуулах, үр

дүнд хүрэх хамгийн ашигтай хэрэгсэл болон хөгжих хандлагатай байна.

2030 он хүртэл "байлдааны ажиллагааны ирээдүйн систем" (Future Combat System — FCS) төслийн хүрээнд газрын байрлал бүхий хэд хэдэн систем тэр дотроо зайнаас удирдлагатай машинуудыг (Unmanned Ground Vehicles) бүтээх бөгөөд үгчлэн орчуулбал "экипажгүй газрын байрлалтай машин" гэсэн үг юм.

Энэ төслийн хүрээнд:

- Зэвсэглэсэн робот (Armed Robotic Vehicle (ARV) –тагнуулын, дайрагч машинууд

- Олон талын ажиллагаатай дэмжих зориулалтын машинууд (Multifunctional Utility Logistics and Equipment platform) (MULE) тагнуулын, саперын, тээврийн гэх мэт

- Бага оврын нисэгчгүй машинууд Small Unmanned Ground Vehicle (SUGV).

- Хүнд зэвсгийн робот машинууд ARV

Хүнд зэвсгийн төрлийн роботууд нь ихэвчлэн 5-6 тн жинтэй, 6 хөтлөгч дугуй бүхий тавцангууд байх бөгөөд тагнуул, галын дэмжлэгийн, цэргийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бүтээгджээ.

Анхлан боловсруулахдаа дайрагч хувилбарын ARV-Assault загваруудаа 30 мм-ийн эргэх цамхаг бүхий их буугаар зэвсэглэхээр тооцсон бөгөөд гол зорилго нь хуягласан техникүүдийг ашиглахад аюултай. эрсдэл ихтэй чиглэлүүдэд байлдааны ажиллагааны тэргүүн эгнээнд ажиллаж явган цэргийг галаар дэмжих явдал юм.

Дараагийн хувилбар нь тагнуулын зориулалттай (ARV-RSTA) бөгөөд цамхагийн оронд нь телекамерийн хяналтын дуран, төрөл бүрийн мэдрэгчүүд байрлуулж улмаар салбаруудын хооронд мэдээлэл дамжуулах, дахин дамжуулалт хийх, тагнуул хийх зорилготой юм.

Эдгээр төслүүд нь өөрийн үнэ. өртөг өндөртэй байснаас шалтгаалан FCS хөтөлбөрийн үндсэндээ хаасан боловч цэргийн төрөл бүрийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр цаашид үргэлжлүүлэн сайжруулах арга хэмжээ одоо ч явагдсаар байгаа юм байна. Хүнд зэвсгийн системийн робот машины нэг төрөл нь «Spinner» юм.

Робот машин Spinner
(бяц дарагч)

2001 оноос эхлэн жолоочгүй газрын хэрэгслийг бүтээх хөтөлбөр UGCV (Unmanned Ground Combat Vehicle) хэрэгжиж эхлэсэн бөгөөд энэ хөтөлбөрт цэргийн мэргэжилтнүүдийн зүгээс гурван үндсэн шаардлага тавьжээ

Үүнд:

- Урт хугацааны туршид ашиглах (ажиллуулах/ боломжтой байх. Тухайлбал 14 хоногоос доошгүй хугацаатайгаар ажиллах, нэмэлт цэнэггүйгээр 450 км-ээс багагүй зай туулах)

- Янз бүрийн саадыг туулах чадвар (350 хэмийн налууд явах, 2м гүн, 1 м өндөр саадыг төвөггүй туулах)

- Даац сайтай байх (Өөрийн жингийн 25 хувиас илүү ачаа ачих боломжтой байх)

Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд АНУ-ын Үндэсний робот техникийн инженерийн төв, Карнеги Меллоны их сургууль, Бойнг пүүс, NREC төвтэй дүүжин болон хэт жижиг удирдлагын тоноглолын пүүсүүд оролцжээ.

Хоёр жилийн туршид тасралтгүй эрчимтэй ажилласаны үр дүнд Spinner –ыг бүтээж чадсан бөгөөд газар орны янз бүрийн нөхцөлд , байлдааны ажиллагааны ямар ч үед , цаг агаарын тохиромжгүй нөхцлүүдийг үл харгалзан тавигдсан үүргийг бүрэн биелүүлэх боломжтой болохоо харуулжээ.

2001 оноос UGCV хөтөлбөртэй зэрэгцэн PerceptOR (Perception for Off-Road Robotics) - замгүй газарт

ажиллах роботын хүлээн авах боломж буюу электрон тархины сэрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ хөтөлбөр нь жолоочгүй машин замгүй газруудад ажиллах үедээ өөрийгөө автоматаар баримжаалах болон электрон тархины системийг хэрхэн ашиглахтай холбогдсон нарийн төвөгтэй ажиллагаанд сургах өөрөөр хэлбэл тархинд нь ой санамж өгөх асуудал юм.

Ингээд 2002 оноос эхлэн маш хүндрүүлсэн нөхцөлд урьдаас сонгоогүй замналын дагууд туршилт хийж эхлэсэн ба энэ туршилтыг маш амжилттай туулж янз бүрийн аюул, саадыг илрүүлэх урьдчилан сэргийлэх талаар бүрэн чадвахитай болохоо харуулжээ.

2004 оноос шинэ хөтөлбөр DPI — UGCV Perceptor Integration –ийг хэрэгжүүлэх болсноор илүү өндөр бүтээмж бүхий шинэ загварын машин Crusher-ийг бүтээж эхлэсэн байна.

РОБОТ CRUSHER (эвдлэгч, няц дарагч).

Энэ машин нь маш хөдөлгөөнлөг, удирдахад уян хатан бөгөөд ашиглахад найдвартай тэдийгүй жингийн хувьд 29 хувиар хөнгөн болсноороо өмнөх загвараасаа ялгарна.

Crusher нь CTC Technologies ашигласан их биетэй, бүхээг нь 5,1х2, 6х1,52м хэмжээтэй, маш бат бөх хөнгөн цагаан хоолойнууд, титанаар хийсэн зангилаануудаас бүрдэнэ.

Зөөлөвчүүд нь маш сайн чанарын гангаар хийгдсэн нь цохилт доргилтоос хамгаалагдсан байдгаараа онцлог юм. Машины газраас дээших зайг 0-0,76 м хүртэл өөрчлөх боломжтой бөгөөд 1,22 м өндөртэй саад, 2 м өргөн шуудуу, 400 –ийн налууг саадгүй туулна.

Хөдөлгүүр нь бага оврын цахилгаан дизель бөгөөд бараг дуу чимээгүй ажиллана. Хөдөлгүүрийн чадал нь 72 морины хүчтэй, тасралтгүй ажиллагааг хангах 58 кВт хүчтэй генераторoор зай хураагуурыг цэнэглэх бөгөөд дунд зэргийн бартаа саадтай газар орон дээр 6,5 тн жинтэй их биеэ 42 км/цаг хурдлах боломжоор хангана.

Тээвэрлэх ачааны дээд хэмжээ нь 3600 кг. Энэхүү машиныг оператор тусгай бүхээгнээс алсын зайнаас удирдах бөгөөд компьютерийн дэлгэц дээр жирийн машин жолоодохын нэг адил жолоог эргүүлэх, газын гишгүүр гишгэх зэргээр удирдана.

Робот машин APD.

Crusherийн дараагийн загвар нь жолоочгүй робот машин (Autonomous Platform Demonstrator — APD) бөгөөд жин, хөдөлгөөнлөг байдал, ажлын бүтээмж, оврын хэмжээний хувьд тавьсан шаардлагыг бүрэн хангахуйцаар бүтээгдсэн дараагийн үеийн роботын бүхий л шинж төрхийг хадгалж чаджээ.

Бодит жин нь 9,5 тн, урт нь 4,57 м, ба 1 м өндөр ханыг туулна. Өөрийн байршлыг тодорхойлох автомат систем ANS –ээр тоноглогдсон нь GPS-тэй хослон ашиглагдсанаар өгсөн чиглэлд бие даан 80 км/цагийн хурдтайгаар хөдөлгөөн үйлдэх боломжийг хангасан байна.

APD-ийн сайжруулсан загвар нь 2009 оны 8 сард бэлэн болсон бөгөөд бүхий л туршилтыг амжилттай давжээ. 2010 оны 6 сард (Aberdeen Proving Ground) Абердинийн туршилтын талбайд туршигдсан бөгөөд өнөөгийн байдлаар 3000 км-ээс дээш замыг туулсан ба зэвсэглэлд авах асуудал тодорхой бус шалтгаанаар 10 жил хүлээгдэж байгаа гэнэ.

Дунд ангилалын роботууд буюу төрөл бүрийн команд дохиог биелүүлэх, байлдааны ажиллагааг дэмжих систем (SMSS-систем).

Байлдааны талбар дээр салбар нэгжүүдийг дэмжих роботжуулсан систем нь операторoос роботыг удирдах хугацааг хэмнэх, байлдааны

талбар дээр бие даан шилжин байрлах нөхцлийг хангах боломжийг олгодог.


Энэ машин робот нь 1814 кг жинтэй, дунд зэргийн бартаа саадтай газар орон дээр 40 км/цаг хурдлах ба 450 кг хүртэл ачааг зөөвөрлөх болмжтой. Нөөц явалт нь 160 км.

Удирдлагын 4 горимтой. Тухайлбал Машины бүхээгнээс гараар удирдах, телехяналтын удирдлага, автоматаар хөдөлгөөн үйлдэх ба ажиллагааг автоматаар хянах үйлдэл юм.

Бүхээгийн зураг авах ладар мэдрэгч нь өмнөө байгаа газар орны байлдааны, тагнуулын , эргүүлийн машинуудыг бүтээхээр зорьж байгаа бөгөөд эдгээр машинууд нь зайнаас удирдах системгүйгээр давшиж байгаа цэргийн араас хоцрохгүйгээр хөдөлгөөн үйлдэж тэдгээрийн ажиллагааг дэмжих ёстой юм байна.

Барууны хэвлэлүүдэд бичиж байгаагаар Америкийн цэргийнхэн MULE ба SMSS загварын байлдааны роботуудыг байлдааны ажиллагааны нөхцөлд, газар орон дээр туршихаар ойрын үед Афганистан руу илгээхээр төлөвлөж байгаа болно.

Робот машин Gladiator.



гурван хэмжээст байрлалын зураг авах ба ладараас авсан мэдээг боловсруулалт хийх, шийдвэр гаргах эсвэл оператороос тусламж хүсэх ажиллагааг бие даан гүйцэтгэнэ.

Байлдааны талбараас шархдсан хоёр хүртэл цэргийн албан хаагчийг нүүлгэн шилжүүлэх ба телехяналтын төхөөрөмж суурилуулснаар газар орны туршуул хийх, гудамж замын байдал, барилга байгууламжийн дотор талыг ч харах боломжтой болно.

Энэхүү робот нь Мк-19 загварын гранат шидэгч танк эсэргүүцэх Javelin пуужингаар зэвсэглэсэн. Логкид Мартин пүүс нь цаашдаа бүрэн автомат ажиллагаа бүхий

/ Гладиатор/

АНУ-ын Тэнгисийн цэргийн хүчний судалгаа шинжилгээний удирдах газар, Батлан хамгаалах зориулалтын толгойн нийгэмлэгээс хамтран TUGV (Tactical Unmanned Ground Vehicle — тактическая наземная беспилотная машина) тактикийн зориулалт бүхий газрын жолоочгүй машин бүтээх хөтөлбөр боловсруулсаны үр дүнд Гладиатор маягийн роботыг бүтээжээ.

Гладиатор нь зайнаас удирдлагатай тагнуулын зориулалт бүхий робот бөгөөд хими-радиацийн аюултай газар орон дээр болон буудалцаан болж байгаа аюултай бүсэнд эрэл-тагнуулын ажиллагаа явуулах, туулж өнгөрсөн замналаа санах, заасан газарт хүрэлцэн

очих, өмнөх замналдаа гаргасан алдаануудаа оруулахгүйгээр эргэн санах чадвартай, хуягласан обьект юм.

Роботуудын давуу чанар нь хөдөлгөөнлөг, үнэ өртөг хямдтай, устгагдах магадлал багатай, урт хугацааны туршид амьдрах чадвар сайтай зэрэг үзүүлэлтээр хэмжигдэх бөгөөд зарим тохиолдолд хаягдал материалаар ямар нэгэн хамгаалалтын хуяг халхавчгүйгээр хийж бүтээх боломжтой.

Гладиаторын анхны загвар нь 7,62 мм-ийн пулемётоор зэвсэглэсэн ба харин хоёрдох хувилбар нь оврын хувьд багасч урт нь 1,78 м, өргөн нь 1,12 м, өндөр нь 1,35 м болж жингийн хувьд нийлүүлэх төхөөрөмж тоноглолоос хамаарч 730-1000 кг хооронд хэлбэлзэх болсон .

Энэхүү машин дээр зайнаас удирдлагтай тогтворжуулсан систем SWARM (Stabilised Weapon And Reconnaissance Mount)-ийг суулгаж өгсөн бөгөөд 5,56 7,62, 12,7 мм-ийн калибрь бүхий зэвсэглэлүүд суурьлуулсан ба өдөр шөнийн дуран харааны хэрэгслүүдээр тоногложээ.

Дээрхи тоноглолуудаас гадна дүрсийн камер, лазерийн чиглүүлэгч, дуу чимээгээр мэдрэгч, хими-бактерилогийн болон хими-радиацийн хордолтоос сэргийлэх мэдрэгчүүд, GPS-ийн багажийг нэмэлт болгон суулгажээ.

Гладиаторын 3 дахь хувилбар нь 6 дугуйтай, бүрэн хөтлөгчтэй, эргэн тойрондоо хяналт хийх боломжтой. Тагнуулын багаж хэрэгсэлээр өвч бүрэн тоноглогдсон, ачааны хэсэгт нь утаан хөшиг тавихад зориулагдсан төхөөрөмжийг байрлуулсаны зэрэгцээ пулемет болон винтовыг суурилуулах боломжтой. Ойролцоогоор 3 тн жинтэй, цэргийн зориулалт бүхий Humvee жипээр тээвэрлэх боломжтой.

Роботын хөдөлгөөн нь зай хураагуураас тэжээгдэх цахилгаан хөдөлгүүрээр дамжин дизель-генераторыг ажиллагаанд оруулна. Хар зам дээр 26 км/цаг, харин шороон замд 2 дахин бага хурдаар явах ба 1м өргөн нүх, 70 см гүнтэй усан саадыг туулах боломжтой.

2005 оны 2 сард Карнеги Мелоны их сургууль АНУ-ын Батлан хамгаалахын үйлдвэрүүдээс 26,4 сая долларын зардлыг гаргуулсанаар USD хөтөлбөрийн хүрээнд Гладиатор загварын 6 ширхэг туршилтын загвар гаргажээ.

Хэрвээ туршилт амжилттай болбол АНУ-ын БХЯ 200 нэгжийг үйлдвэрлүүлэх захиалга өгөхөд бэлэн гэдгээ нотлож зарим загварыг байлдааны нөхцөлд туршин шалгах ажиллагаа нь 2009-2010 онд явагджээ.

Роботуудын тусламжтайгаар шийдвэрлэж болох тактикийн үүргүүд:

Байлдааны ажиллагааны зориулалт бүхий роботуудыг тусгай албад, цэрэг цагдаагийн хүчинд ямар хэлбэрийн операци, байлдааны ажиллагаанд ямар ч зорилгоор ашиглах бүрэн боломжтой боловч хамгийн чухал нь тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох, алан хядах зохион байгуулалттай ажиллагааны эсрэг тэмцэх болон улсын онц чухал обьектуудын хамгаалалтанд ашиглах нь илүү үр ашигтай гэж үздэг байна.

Үүний тулд байлдааны роботуудаар дараах тактикийн чанартай үүргүүдийг шийдвэрлүүлж болох юм:

Тэсэлгээний ажлын чиглэлээр

– тэсэлгээний төхөөрөмжийг эрж хайх болон дүгнэлт хийх

- Дэлбэрэх төхөөрөмжүүдийг устгах болон зөөвөрлөх

- Дэлбэрэх бодисыг аюулгүй болгох болон задлан буулгах

- Газар орон, обьектод хими-радиацийн тагнуул хийх

Алан хядах ажиллагааны эсрэг ажиллагааны үед

- Радиоэлектрон саатуулга тавих, утаан болон бусад тусгай хөшиг үүсгэх

- Зарим тусгай ажиллагааны зэвсэг, техникийг хүргэх болон тээвэрлэх

- Хамгаалж байгаа болон нууц обьектуудад нууцаар нэвтрэн орох

- Зарим нутаг дэвсгэр, обьектын байдлын талаар дүрс бичлэгийн тагнуул хийх, радиоэлектроны болон дуут ухуулга явуулах

- Зарим саад, байгууламжийг эвдлэх

- Галын цэгийг тогтоох болон анхаарал сарниулах зорилгоор буудлагын гал явуулах

Обьетыг хамгаалах үед

- Тухайн обьектуудын орчимд эргүүл хийх ба үргэлжлэсэн урт хэсгийг халхлах

- Обьектод нэвтрэн орох гэсэн үйлдлийг таслан зогсоох

- Хууль, ёсыг зөрчигчдийн үйл ажиллагааг тасалдуулах

Дээр дурьдсан олон үүргийг янз бүрийн нөхцөлд, янз бүрийн обьектуудад хийж болно. Тухайлбал:

- Нийтийн тээврийн хэрэгслийн обьектуудад / хотын болон хот хоорондын тээвэр, төмөр зам, нисэх буудал, усан болон автозамын тээврийн хэрэгслүүдэд/

- Иргэдийн болон хувь хүмүүсийн амьдарч , үйл ажиллагаагаа явуулж байгаа орчин /орон сууц, үйлдвэрийн газар, барилга байгууламж, албаны өрөө тасалгаа гэх мэт/

- Улсын болон хувийн томоохон үйлдвэрийн газрууд ялангуяа нефть-химийн үйлдвэр, эрчим хүчний төвүүд, бусад чухал газрууд

Эх булаг нь PROMT 9.0 на http://www.promt.ru сайтаас орчуулав.

Одоо өмнөд Солонгост байлдааны талбар дээр амьд цэргийг орлох боломжтой илүү нарийн ажиллагаатай роботыг бүтээх ажиллагааг явагдаж байгаа нь хүний нөөцийн хомсдол /төрөлт эрс багассан/ , ялангуяа цэргийн албанд дайчилгаагаар татах нөөц бага байгаатай холбоотой Өмнөт Солонгосын байнгын цэргийн бүрэлдэхүүн нь 655 мянган хүнтэй байхад Хойт хөршийн цэргийн тоо нь 1,1 сая орчим цэргийн албан хаагчид байдаг. Түүнчлэн тус улсад байгаа АНУ-ын 28,0 мянган цэргийг нэмээд ч өөрийн болзошгүй дайснаасаа хоёр дахин бага хүчтэй байгаа нь робот бүтээх бас нэг шалтгаан байгаа ажээ.

Байлдааны болон цэрэг-иргэний зориулалт бүхий янз бүрийн үүргүүдийг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай иймэрхүү роботуудыг бүтээх ажиллагаа дэлхийн олон улс оронд идэвхтэй явагдаж байгаагаас зөвхөн улсын хил хамгаалалттай холбоотой зарим төрлийн роботын системийг таницуулая. Белорусс улсын "Дисплей" зохион бүтээх товчоо анх удаа зайнаас удирдлагатай автоматжуулсан хяналт ажиглалтын ба галын систем /АДУНОК/- ийг 2009 онд аюулгүй байдлыг хангах хэрэгслийн олон улсын үзэсгэлэн/"Интерполитех-2009"/-д тавьж харуулсан бөгөөд бүхэлд нь авч үзвэл холбоо мэдээлэл, хяналт ажиглалтын хэрэгсэл бүхий автомат суурь /тавцан/ бөгөөд буудлагын зэвсгээр нь ПКТ, НСВТ, Корд болон автомат грантомёт ашиглагдана.

Дүрсийн камер, лазер алс хэмжигч, бусад нэмэлт төхөөрөмжийн хамтаар 2000 м хүртэл алсын зайд 10 хүртэл тооны бай / дүрс, биет/-г илрүүлэн санах ба операторын өгсөн захирамжаар өндөр магадлалтайгаар устгах чадвартай. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Молдав, Украйн улсын хилийн зарим отрядуудад өндөр технологийн хамгийн сүүлийн үеийн хяналтын цахилгаан -дурангийн системийг нэвтрүүлснээр 95 км хүртэл үргэлжилсэн урт хэсгийг бүрэн хянах

боломжтой болжээ. Энэ тухай 2010 оны 7 сарын 14 ны өдөр Оросын төв телевизээр албан ёсоор мэдэгдсэн байдаг. Энэ зорилгоо эхний ээлжинд цахилгаан-дурангийн цогцолборыг бүтээхэд 510 мянган доллар, харин дээрх техникийг худалдан авахад 6 сая доллар шаардлагатай гэсэн тооцоо гарчээ.

Канадын болон Мексикийн хилчид олныг шуугиулж байгаа орчин цагийн зарим электрон хэрэгслийг хэдийн эзэмшиж эхлээд байгаа бөгөөд иймэрхүү машин нь хүний иргэний хувийн болон жолооны үнэмлэхний доторхи бүхий л мэдээллийг унших чадвартай аж. Аюулгүй байдлын төрийн Департаментын албаны мэдэгдснээр ийм төрлийн техник хэрэгслийг ашиглах нь улсын хил нэвтрэх ажиллагааг хэд дахин хөнгөвчлөхийн хамтаар илүү нарийвчилсан шалгалтуудыг хийх боломжтой гэжээ.

Гэхдээ өмгөөлөгчдийн зүгээс хүний хувийн эрхийг зөрчиж байгаагийн хамтаар алан хядагчид болон гэмт хэрэгтэн этгээдүүд баримт бичгийн мэдээллийн санд ямар ч байдлаар хуурмаглал хийж чадна гэж үзэж эсэргүүцэж байна. Ийм төрлийн автоматууд АНУ-ын хилийн шалган нэвтрүүлэх боомтууд тухайлбал Вашингтон мужийн Блэйн, Аризон мужийн Буффало, Дейтройт, Ногалис, Калифорни мужийн Сан-Исандро хотод байрлаж байгаа ШНБ-уудад хэдийнээ ашиглаж байна.

Израйль улс газын секторт Палестин улстай хил залгаж байгаа хэсэгт шинэ загварын радарын системийг нэвтрүүлсэн бөгөөд уг радарын тусламжтайгаар хээрийн тагнуулын тусгай корпусын бүрэлдэхүүнээс мэдээлэл цуглуулах, хөрш зэргэлдээх Ливаны нутаг дэвсгэр дээрх алан хядагчдын хөдөлгөөнийг тасралтгүй хянаж байна. Ийм маягийн радарын систем нь 300м-ээс 40км хүртэл тойрог доторхи бүхий л хөдөлгөөнийг тасралтгүй хянаж чаддаг байна. Ойрын үед Израйлийн хуурай замын цэргийн хүчин 100 гаруй ийм төхөөрөмжийг худалдан авч ашиглах бөгөөд энэ системийг анхлан бүтээгч агаар-сансрын хүчний корпорацийн охин үйлдвэр болох Elta Systems компани илүү бүтээмжтэй Granite буюу монголчилвол "улсын хил" нэртэй цоо шинэ радарыг зэвсэглэлд авахаар бүтээж байгаа юм. Эх сурвалж нь: - IDF unveils upgrades to Gaza fence - The Jerusalem Post, 03.02.2010

- Israel Aerospace Industries


Судлаачийн дүгнэлт: Монгол хүний сэтгэн бодох, урлан бүтээх авьяас чадварыг хичнээн хосгүй болохыг хүн бүхэн мэдэх төдийгүй манай олон залуу зохион бүтээгч, төрөл мэргэжлийн инженерүүд техникийн өндөр хөгжил бүхий улс орнуудад электроник, компьютер, техникийн загвар зохион бүтээх чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж байгаа билээ.

Монгол хүн орчин үеийн ийм ухаалаг ухаалаг роботуудыг бүтээж чадвал зөвхөн цэргийн салбарт төдийгүй улсын хил хамгаалах, байгалийн гэнэтийн гамшиг ослын үед тавигдсан үүргийг бүрэн гүйцэтгэх боломжтой төдийгүй хөгжлийн маш том ирээдүйтэй юм. Учир иймээс манай эрдэмтэд, судлаачид, шинийг эрэлхийлж бүтээж, туурьвидаг хэн бүхэн, ШУ-ны үйлдвэр- туршилтын төвүүд алсыг харсан нягт хамтын ажиллагааг явуулж чадвал дээрхи роботуудтай ижил төсөөтэй хийцүүдийг богино хугацаанд бүтээж чадна гэдэг нь тодорхой.

Хилийн албаны сургуулийн багш Х.Гөлгөө

СУПЕР НЭГДЛИЙН ОНОЛ

Энэ удаагийн буландаа " Супер нэгдлийн онолын математик зарчмууд" хэмээх нэртэй бүтээлийг туурвисан физикч Ч. Эрдэнийн судалгааны материалаас **Үнэн, Дэлхийн мэдээ, Өдрийн сонин** зэрэг манай төв хэвлэлүүдэд нийтлэгдсэн материалуудаас түүвэрлэн авч тавьж байна.



Эрдэмтэн Ч.Эрдэнэ нь Монголоос хамгийн түрүүнд Нобелийн шагнал хүртэх боломжтой, магадлалтай нэгэн агаад түүний бичсэн **" Супер нэгдлийн онолын математик зарчмууд"** ном нь дуудлага худалдааны эхний үнэ нь 500,000 төгрөг хүрч байсан ба номын нийт жин нь 4 кг, нийт 100 ш хэвлэгдснээс Монгол улсад ердөө 3ш байдаг гэнэ.

Үнэмлэхүй геометрийн суурь тогтмолууд болон квант операторууд тэрчлэн физик тогтмолуудыг шинээр нарийвчлан тодорхойлж, математик геометрийн бүхий л нээлтүүдийг шинэчлэн баталсан хүн бол эрдэмтэн Ч. Эрдэнэ юм.

Эртний сонгодог Грекийн их одон оронч Фалесийн үеэс тоолбол Шинжлэх ухаан гэдэг тогтсон нэг нэртэй нэгэн зүйл үзэгдэл 2500 жилийн түүхтэй бөгөөд 20-р зуунд ШУ-нд гарамгай амжилтуудыг олсон нь эн тэргүүнд онолын ба туршилтын физик, биологийн ухаанд хамаарах юм. Ертөнц материйг дагнан судалдагийн хувьд фикик нь хамгийн тулгуур ухаан юм.

"...Хүн төрөлхтөний туйлын зорилт бол орчлон ертөнцийн бүрэн төгс онолыг нээх явдал" юм гэж Кембрижийн их сургуулийн профессор нэрт физикч Стивин Хокинг хэлсэн байдаг бөгөөд түүний бүрэн төгс онолыг супер нэгдлийн онолын физикт урьдчилан нэрлэдэг юм.

Онолын ухаанд ганцхан асуудал шийдэгдээгүй үлдсэн нь өнөөгийн тархай бутархай, саланги, тусгаар мэдлэгүүдийг нэгтгэн нэг учир шалтгаанаар зангидан нэгтгэж үндэслэх асуудал юм.

Өөрөөр хэлбэл ердөө л Ертөнцийн оршихуйн учир шалтгааныг тайлж, оршихуйн бүрэн төгс суурь онолыг боловсруулах асуудал болно. Чухамхүү энэ асуудлыг ШУ-нд супер нэгдлийн онолын асуудал гэж нэрлэдэг. Хялбаршуулсан утга зохиолд / Эцсийн онол/, /буй бүхний онол/ гэж хэлэлцэх бөгөөд үүнээс цааш онол байж логикийн хувьд таарахгүй.

Байгалийн шинжлэлийн суурь шинжлэх ухаан нь физик бөгөөд өнөөгийн соёл иргэншлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь физикийн ухаан гэж 20-р зууны тэргүүлэх физикч Ричард Фейнман хэлсэн байдаг.

Энэхүү физикийн ухааны төгсөх үе нь 1940-өөд он бөгөөд төгсгөхийн тулд цорын ганц суурь асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болсон. Энэ асуудлыг **орны нэгдсэн онол** гэнэ.

Ертөнц ба материйг цорын ганц учир шалтгаанаар тайлбарлан нотлох учиртай тийм физик онолыг супер нэгдлийн онол гэх юм. Энэ нь 50-60-аад оноос хэрэглэж ирсэн албан ёсны нэр томьёо юм.

Баталгаа нь миний саяхан хэвлүүлсэн "Principia Mathematica" ном юм. Шүүгч нь ШУ тэр чигээрээ бөгөөд

шүүлгэхийн тулд ном хэвлэдэг ганц аргатай.

Монголын аюул нь юу вэ гэхээр ШУ-ны эцсийн онолыг ярих нь бүү хэл шинжлэх ухааны сэтгэл зүй, аяс хандлагын А, Б ч байхгүй тогтож төлөвшөөгүй нийгэм юм. Наад зах нь ШУ гэдэг нийтлэг үзэгдэл байна.

Тэр шинжлэх ухаанд асуудлууд нь цагийн аясаар өөрөө урган гарч ирдэгийг яв цав ойлгох нь чухал. Асуудал нь шинжлэх ухаан мөн бол хаа нэг газраас аль нэг судлаач шийдэж таардаг. Супернэгдлийн онолыг олох гэж олон арван жил зарцуулж байна. Туйлын зорилт болсон тэр онолыг олох эсэхтэй хүн төрөлхтөн , түүний соёл, иргэншлийн цаашдын хувь заяа шууд холбоотой.

Суурь онол нь байгаль ертөнцийн үндсэн хуулиудын асуудал юм. Тиймээс суурь онол нь дуту хагас, алдаа дутагдалтай байж болно. Харин худал байж болдоггүй логиктэй. Онолын физикийн өөр нэг арга нь математик юм. Математик судлал нь өөрөө өөрийгөө шалгаад баталж юм уу эсвэл няцааж болдог цорын ганц найдвартай ухаан юм.

Нэгдсэн онолын асуудлыг орчин цагийн утгаар нь А. Эйнштейн 1923 онд анх дэвшүүлсэн бөгөөд өөрийнхөө амьдралын сүүлийн 30 гаруй жилийг энэ асуудалд дагнан зориулсан боловч амжилт олоогүй юм.

1960-аад оноос физикчид дэлхийн нийтээрээ хүчлэн оролдож эхэлсэн бөгөөд бүгд л энэ нэгдсэн онолд тэмүүлж байна. Манай улсад академич Х. Намсрайн локал бус квант орны онол бий

Ер нь ШУ-ны хөгжлийн бас нэг зарчмын онцлогийг дурьдах хэрэгтэй. Юу гэвэл ШУ-нд хүний ухаан бус харин зөв үзэл баримтлал шийдвэрлэх ач холбогдолтой.

Шинжлэх ухааны их хүмүүсийн нилээд нийтлэг хэлсэн хэдэн зүйл бий.

" Над лугаа бодоод байх ахул хэн бугай ч математикч байж чадна." гэж суут Гаусс хэлсэн нь оргүй биш юм. " Бодох нь хамгийн ярвигтай үйл" гэж Паскаль хэлсэн байдаг. Хүмүүс хар ярвигтай үйлээс байнга зугтааж байдаг. Энэ нь бараг байгалийн хууль учраас буруу биш юм.

Гэтэл зарим хүмүүс төрөлхийн сониуч зан төрхтэй байдаг. Оюуны сонирхол давамгайлсан хүмүүс аливаа хэрэгтэй , хэрэггүйн учир начрыг олох гэж бодоод байдаг. Тухайн нийгэмд материаллаг ба ба оюуны сонирхлын тэнцвэрийг хадгалах нь их чухал. Өнөөдөр капиталист анхны хуримтлалын үе шатанд байгаа болохоор материаллаг ашиг сонирхол хэт давамгайлж байна.

Супер нэгдлийн онол маань цэвэр математик үзэгдэл бөгөөд энэ онолыг нээж боловсруулсаны цаана хүссэн хүссээгүй ямар нэг үзэл суртал нуугдаж байх бөгөөд энэ нь үндэсний үзэл юм. Математик дэхь миний намч чанар гэвэл " үндэсний үзлийн нам" –ын намч чанар юм.

Үндэсний үзэл бол хамгийн хүчтэй хөшүүрэг, тулгуур багана, хөрс дэвсгэр нь гэж боддог. Супер нэгдлийн онолыг олсон нь үүний баталгаа юм. Энэ судалгааны угийн угт үндэсний үзэл байгаа юм.

Ерөөсөө хүн төрөлхтөн оршин тогтнохын үндэс нь үндэстнүүдийн ондоошил гэж системийн шинжлэл гэдэг ухааны үүднээс хэлж болно гэж үздэг. Бид үндэсний үзэлгүй байж болно. Гэтэл бусад үндэстнүүд үндэсний үзэлтэй. АНУ гэдэг халуун тогоо холион бантан хүртэл үндэсний үзэлтэй.

Энэ нөхцөлд үндэсний үзэлгүй үндэстэн нь дархлаа устдаг ДОХ-той этгээд гэсэн үг. Тиймээс үндэсний үзэл нь ердөө л амьдарч үлдэх арга хэрэгсэл. Үүнээс айж бэргэх, үргэж , бусгах нь илүүц юм. Дан ганц биш гэхдээ гол хүчин зүйл нь энэ. Үндэснүүд өрсөлддөг. Энэ нь байгалийн хууль. Өрсөлдөөний гол талбар нь оюуны салбар юм.

Оюуны салбартаа өрсөлдөөний гол салбар нь шинжлэх ухаан юм. Энд

олсон үндэсний нэр хүнд, рейтинг нь мөнхийн байна. Биеийн баатар болбоос нэгэн үеийн баатар харин билгийн баатар болбоос мянган үеийн баатар гэдгийн учир нь энэ.

Шинжлэх ухаан технологийн томоохон нээлтүүд үндэстнүүдийн өрсөлдөөн, үндэсний үзэлтэй шууд холбоотой нь угтаа нууцлаг боловч нийтлэг үзэгдэл. Ерөөсөө давуу тал нь оюуны салбарт л байна. Чингисийн монголчууд гэж зэрлэг бүдүүлэг хүмүүсүүд байсан гэж урьдын түүхчид бичдэг байсан ч зэрлэг бүдүүлэг дээр дэлхийн түүхнээ хамгийн аугаа гүрэн байгуулж болох уу гэдэгт байлаа .

Харин өнөөгийн түүхчид энэ асуултын хариуг олж эхэлж байна . Юу гэвэл Чингисийн монголчууд оюун сэтгэлгээний давуу талыг эзэмшсэн байсанд нууц нь байжээ гэж дүгнэж байна. Энэ нь нарийн төвөгтэй асуудал. Чингисийн монголчууд бусдаас сурч мэдсэн онол , номнол гэж юу байхав харин тэдэнд мянга мянган жилээр энэ газар орноо боловсорсон төрөлх метафизик сургаал байсан. Өнөөгийн хэлээр хэлбэл энэхүү метафизик сургаал нь тенгризм юм.

Өөрөөр хэлбэл байгаль лугаа сэтгэж үйлдэх аяс, хандлага, арга ухаан юм. Энэ нь дэлхийг даяарчилсан ялалтыг хангах оюун санааны давуу тал болж байжээ. Юмс үзэгдэл ямагт хоёр талтай. Язгуур нүүдлийн аж ахуй оршихуйн нөгөө тал нь түүний зарим давуу талууд.

Байгальд хамгийн ойр дөт нь нүүдэлчид. Би нүүдэлчний ахуй орчинд төрж өссөн. Энэ миний давуу тал байхыг үгүйсгэхгүй. Багадаа энгэр газар судгийн ногоо дагуулан хонио хариулж хаврын наранд ээж суухдаа энэ орчлонгийн хамгийн гайхамшигтай зохиролыг анх ажиглаж гайхаж байснаа мартдаггүй юм. Манхэттанд төрж өссөн нэгэн хүүхэд хот орноо сайшааж, шүүмжилж чадна. Харин орчлонг олж харахгүй. Ялгаа зөрөө нь энд л байгаа юм.

Коперникийн дараах нээлт ололт нь Иоханн Келлерийн "Harmonicae Mundi" ном юм. Ертөнцийн зохицол гэсэн үг. Энд гариг ертөнцийн хөдөлгөөний хуулиуд байх ба энэ үндсэн дээр их Ньютоны онол, номнол бий болсон түүхтэй. Ерөөсөө танин мэдэхүйн шинжлэх ухааны туйлын зорилго нь ертөнцийн зохицолын системийг нээж олох явдал бөгөөд олбол супернэгдлийн онолыг байгууллаа гэсэн үг юм. Их Ньютоны дараах номоор онолын физикийн ухаан бий болсон.

ШУ-ны сүүлчийн онолыг нээж олж байгуулах асуудал ба туйлын зорилт хүн төрөлхтний өмнө байна гэж өмнө хэлж яриснаас эрхбиш ойлгогдож байгаа байх. Шинжлэх ухааны асуудал шийдтэй байх номтой.

Хэн, хаана, хэзээ шийдэх нь тохиолдлын хэрэг, магадлалын асуудал. Тохиолдол болон магадлалын дотор Монгол улс ба монгол үндэстэн цохиж л яваа. Ямар нэг магадлал, тохиолдолд хэрэгжиж эхлэхэд айж цочирдон шоконд орж балмагдах хэрэггүй. Нөгөөтэйгээр шинжлэх ухааны шинэ суурь онол хаанаас гарна, тэндээс соёл иргэншил хөтлөгдөж, тийшээ түүхэн үйл явц шилжин төвлөрдөг жамтай.

ШУ-ны сүүлчийн онолын хувьд ийм даяар нөлөө тусгал, үнэмлэхүй шинж чанартай байх ёстой. Өөрөөр хэлбэл Монгол улс хүссэн хүсээгүй олон улсын тавцан дээр рейтинг, чансаагаар тэргүүн эгнээнд тавигдана. Эндээс их юм хүлээгдэнэ.

Харин хүлээлтийг бид хэрэгжүүлж чадах уу , үгүй юу. Өнөөгийн дэлхий гэж яахаа мэдэхээ байсан сул иргэд тэр аяараа аврал хүлээж байна. Аврал нь зарчмын хувьд ганцхан.

Энэ нь эцсийн буюу супернэгдлийн онол. **" Санааг нь авбаас бие нь хаа хол очиж хамраараа хатгаж ойчих"** гэж Чингис хаан сургажээ. Ардчиллын туг, далбаа, лозун нь болсон Уинстон Черчилль хэлэхдээ " **Ирээдүйн эзэнт гүрнүүд нь оюун санааны эзэнт гүрнүүд байх юм**." гэжээ.


УЛСЫН ХИЛ ДЭЭР БАРЬЖ БАЙГУУЛАХ БОЛОМЖТОЙ, ИНЖЕНЕРИЙН АВСААРХАН ШИЙДЭЛ БҮХИЙ ГҮҮРҮҮДИЙН ТУХАЙ.

МУ-ын хилийг хамгаалж байгаа хилчдэд өдөр тутамд тохиолдож байдаг нэг бэрхшээлтэй зүйл нь байгалийн саадууд /тухайлбал гуу, жалга, эрэг, намаг, хад чулуу бусад / болон усан саадыг туулах явдал бөгөөд хилийн районд замын сүлжээ төдийлөн хөгжөөгүй, хилийн анги, салбаруудад инженерийн мэргэжлийн хүч хэрэгсэлгүй байгаагаас хилийн манааны бүрэлдэхүүн заасан газарт очихын тулд дээрх саадуудыг тойроход цаг их зарцуулдаг хугацаа алддаг, материал хэрэгслийн үргүй зардал их гардаг зэрэг сөрөг үр дагавруудыг дагуулж байдаг.

Сүүлийн үед усан саадуудыг туулах, хилийн манааг дээрхи саадуудаар гаргах талаар ХХБ-аас зохион байгуулалттай арга хэмжээ авч байгаа боловч ганцхан инженерийн ангийн хүчээр хийнэ гэвэл шаардлагыг тэр бүр хангахгүй нь мэдээж. Харин хилийн анги салбарууд өөртөө байгаа нөөц боломжоо ашиглан гарын уртай, сэтгэн бодох авьяастнуудыг ашиглавал энэ хүндрэлээс богино хугацаанд салж чадах төдийгүй хил хамгаалалтын чанарт мэдэгдэхүйц ахиц гарах бололцоотой.


Энэ зорилгоор эрт дээр үед Орос болон Герман улсуудад хийж ашиглаж байсан зарим хөнгөн маягийн авсаархан гүүрүүдийн талаар интернетэд тавигдсан зарим материалыг сонгон авч хилчдийнхээ мэргэн ухаанд толилуулж байна. Энэ материалаас санаа авч орчин цагийн арга ухаанаар хослуулан оролдвол тодорхой үр дүнд хүрнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

<u>Зүсмэл материалаар хийсэн гүүр (ОХУ 19-р зууны үед)</u>



Зүсмэл материалаар хийсэн энэ гүүр нь маш энгийн хийцтэй бөгөөд 3-5 м хүртэл өргөнтэй усан саадыг туулахад зориулагдсан ба 3 тн хүртэл даацтай, 2,6 м өргөнтэй явах хэсэгтэй байна.

Энэ гүүр нь явган болон морьт цэрэг, бага калибрийн хөнгөн их бууг гол гаргах боломжтой. Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд ХЦ-ийн анги салбарууд өөрсдийн хүчээр барьж байгуулж болох хамгийн энгийн хийцтэй инженерийн байгууламж юм.Гүүрэнд ашиглах гуалингийн голч нь 17-22 см байна.




Гүүрийн гол үндсийг хооронд нь 3м зайтай байгуулсан хөл дээр тавьсан хос дам нуруу бүрдүүлнэ. Хөндлөн нурууны дээд төгсгөлийг явах ангиас 2-3м өндөрт хооронд нь боолтон холбоосоор бэхлэх ба доод хэсгийг нь тулгуур банз /7,6 см зузаантай 25-30 см өргөнтэй / -нд тулган голын эрэг дээр холбон бэхэлж өгнө.

Усны эрэг дээр гүүрийн явах ангийн төвшингөөс доор 17-22 см-т 25-30 см-ийн голч бүхий хөндлөн хэвтээ

дэр гуалинг суулгаж хоёр талаар нь 30-40 см тутамд модон гадсаар бэхлэнэ.

Энэхүү хөндлөн дэрэн дээр 5 гуалинг дам нуруу болгон тавих ба төгсгөлийг нь жийлтийн хөндлөвчөөр хамгаална. Харин завсрын хөндлөн



нуруунууд дээр дам нуруу нь тулахгүйгээр хөндий байж болно. Дам нуруунууд дээр банзан самбар хадна.

Зураг хар.

Эргийн хөрсийг малын болон техникийн хөдөлгөөнөөс улбаалан эвдрэхээс хамгаалж гүүрийн явах хэсгийн өргөнтэй тэнцүү өөрөөр хэлбэл 2-2,5 м өргөнтэй банзан шалавч хийж өгнө.

Германийн цэргийн туршлагаас (1871-1918)


Морин цэргийн хэрэгцээнд зориулсан гүүрийн иж бүрдэл.

Ийм гүүрийн иж бүрдэл нь явган хүний гүүр, хөвдөг тулгуур бүхий гатлалтууд зохион байгуулахад ашиглагдаж байжээ. Өөрөөр хэлбэл явган цэрэг, агт уналга, морьтой хүмүүс, их буу, зэвсэглэлийн бусад зүйлийг голоор гаргах боломжийг хангаж байсан байна.

Шаардлагатай үед гүүрийн иж бүрдлүүдийг нэгтгэн сааадыг туулах боломжийг нь нэмэгдүүлдэг байсан ба хамгийн урт нь 6 иж бүрдлээр явган хүний гүүр 192 м урт , харин хүчитгэсэн гүүрийг 90м хүртэл урттай хийж болдог байжээ.

Морин цэргийн зориулалттай гүүрийн нэг иж бүрдэлд байх нь:

1. 4 ш жижиг завь
2. 6ш тулгуур балок
3. 8ш банзан бамбай
4. 4 ш татуурга
5. 6ш аргамжаа татуурга
6. 2ш зангуу
7. 12ш эргийн аргамжааны гадас (6ш богино, 6ш урт).
8. 12ш дүүжин.
9. Двенадцать уключин.
10. 8ш хатгуур мод.
11. 4ш зангууны ган татлага (тус бүр нь 45 м урттай 17мм-ийн диаметртэй.).
12. 16ш татуурга аргамжаа (тус бүр нь 10 м урттай10 мм-ийн диаметртэй.).
13. 8ш хүлэг уяа (тус бүр нь 8 м урттай 8 мм голчтой/
14. Нэмэлт эд хогшил (4 ш сүх, 2 ш жоотуу, 4 ш хүрз, 2 ш гар хөрөө)




Гүүрийн банзан бамбай (Brueckentafel)

Гүүрэнд 8 ш банзан бамбай байна

Эдгээр бамбайнууд нь гүүрийн алсгалын байгууламж болон хөвөгч хэрэгслийн тавцан болно.

Бамбай тус бүр нь 3ш уртааш дам нуруу, 12 см-ээс ихгүй зузаантай банзан шалнаас бүрдэнэ. Эдгээр бамбайг нарс модоор хийх ба төгсгөл хэсэгт нь төмрөөр хатуулаг хийж өгнө.

Захын балокнуудад дэгээ хийх ба гол балкуудад эсвэл завины ирмэгт бэхлэнэ. Захын балокийг маш хатуу модоор хийх ба тусгайлан гаргасан хоёр нүхээр нь хөвөгч тавцантай бэхлэнэ. Бамбайн урт нь 4 м, өргөн нь 1 м, банзны зузаан нь 2 см. Нэг бүрэн бамбайны жин нь 92 кг байна.



Татуурга. (Unterzug)

Иж бүрдэл нь 4 татуургатай байна. Ийм татуургыг зөвхөн хүчитгэсэн гүүрэнд ашиглана. Зориулалт нь хэд хэдэн бамбайг нэгтгэн нэг алсгалын байгууламж болгох явдал юм.


Түүнээс гадна татуургууд нь алсгалын байгууламжинд ачааллыг жигд хуваарилах зориулалттай нэг татуургыг гүүрийн дам нурууны доогуур хийнэ. Нэг иж бүрдлээр :

1. **Явган хүний гүүр (kurzer Brieckengebsteg).** нь морин цэрэг болон явган хүмүүсийг гаргахад зориулагдсан байна. Морьдыг урсгалын доод хэсгээр хөлөөр нь гаргана. Хөвдөг гатлалтыг хийхийн тулд 4ш завийг ашиглах ба уг завинууд дээр банзан бамбайнуудыг дэвсэж өгнө. Явган гүүрийн өргөн нь 1 м , урт нь 20м хүртэл байж болно. Гатлах усан саадны урсгалын дундаж хурд нь 1 м/сек-ээс ихгүй байвал зохино

2.**Хөвүүр гүүр (Laufbruecke).**

Энэ гүүр нь морьтой хүмүүс болон хөтөлгөө морьтой хүмүүсийг усаар гаргахад зориулагдсан байх ба тулгуурт нь 2 ш жижиг, нэг том завийг ашиглана. Тулгуур дээр 1-2 эгнээ банзан дэвсгэр хийх ба татуургаар бэхлэсэн байна. Гүүрийн урт нь 16 м, өргөн нь 2 м байна.

Зураг дээр харуулсан уг гүүрийн бүдүүвчийг хар.





3.Хүчитгэсэн хөвүүр гүүр. (verstaerkte Laufbruecke). Уг гүүрээр морьтой цэрэг, их буу хүнд пулемет, сум галт хэрэгслийг нуруунд ачсан агт морьд, хоёрын цуваагаар яваа цэрэг дайчдыг гаргахад зориулагдсан байна. Хүнд зэвсгүүдийн суурь, бусад эд ангийг тусад нь гаргана. Хөвөгч тулгуурт нь 2 ш том, 4 ш жижиг завийг ашиглана. Гүүрийн явах хэсэг нь 2-3 эгнээ модон шал ашиглах ба өргөн нь барагцаалбал 3 м байна.

Ямаан тулгуур бүхий явган хүний гүүр (Beselerschnellsteg)

Германийн цэргийн номолд энэ гүүрийг ямаан тулгуур дээрхи гүүр буюу **Beselerschnellsteg** эсвэл өөрөөр **Bockschnellsteg ямаан гүүр** гэж нэрлэдэг

байна.





Ийм ямаан тулгуур бүхий гүүр нь усан саадын дээгүүр эсвэл байгалийн бусад саадуудын дээгүүр байнгын гүүрэн гарц төхөөрөмжлөхөд зориулагдсан байна. Даац нь 300 кг

Зарим хязгаарлалт:

- Усан саадын өндөр нь эргийн хамгийн дээд хэсэг ороод 2,5 м байна

- Урсгалын хурд нь 1м/сек-ээс ихгүй байна. Гүүрийг барьж байгуулахад 4 хүн шаардагдах ба нэг алсгалын байгууламжийг 40 минутад гүйцэтгэнэ.

Ямаан гүүр нь хэд хэдэн алсгалыг нэгтгэн байгуулсан хийц юм. Нэг алсгалын урт нь 4 м байна. Хооронд нь бэхлэж уясан тулгуурууд болон тулаас бэхэлгээнүүд /А/, явган хүний зам /В/-ээс бүрдэнэ

А. Ямаан тулгуур нь хэд хэдэн холбоос бүхий шургаагууд байх ба хамгийн нарийндаа 8 см байна Тэр нь босоо тулгуур /1/, хоёр хөндлөвч /2/, нэг доод хөндлөвч (ул хөндөл) /3/, ташуу тулаас /4/, дагуу тулаас /5/, -аас бүрдэх ба хооронд нь боож тогтооно.

Элементүүдийн хэмжээ нь хэмжээ нь дээд хөндлийн урт нь 1,5 м, доод хөндлөвчийн урт нь -1,5+0,125 гэсэн тулгуурын өндөр нь харьцаагаар тогтоогдоно.

В. Явган хүний зам нь 4 м урттай, 25 см өргөнтэй3,5 см зузаантай хоёр банзнаас бүрдэнэ.

Нэг алсгалд дараах модон материал орно.


1. Гүүрийн тулгуурт 8 см голчтой 7ш шургааг
2. Ямаан тулгуурын өндрөөс хамааралтай 8 см голч бүхий 2 ташуу тулаас
3. 8 см голч бүхий 1,5 м урттай 2 хөндлөвч
4. Мөн хэмжээний 0,7 м урт 2 хөндлөвч
5. 4м урттай 25х3,5 см-ийн 2 банз
6. Эхний алсгалын төгсгөлийн тулаас багана 2ш


Бэхэлгээниий материал болон багаж хэрэгслийн түүвэр:


1. 45 м урт олс эсвэл төмөр утас
2. 6 см урттай 24ш хадаас
3. Хөрөө
4. Сүх
5. Лантуу
6. Төмөр жийргэвч
7. Шаантаг


Тоот 4 хүн


Гүүрийг барьж байгуулахын тулд эрэг дээр баганууды газраас дээш 20 см өндөртэй босгоно. Баганууды хооронд 1 м зайтай байна. 2, 3-р











тоотууд нь эхний алсгалын байгууламжийг зөөж авчирна. Багануудыг хийж дуусмагч 2, 3 –р тоотууд нэг үзүүрээр нь багананд тулган алсгалыг босгоно.

Тоотын ахлагч нь алсгалыг олсны тусламжтайгаар барьж байх ба алгуурхан босгож улмаар саадын ероол хүртэл зугуухан буулгана. Эхний алсгал бэлэн боллоо.

Хоёр болон дараагийн алсгалуудыг эхний нэгэн адилаар хийнэ. Шинээр тавьж байгаа алсгалын байгууламжийн хөндлөвчүүд нь босоо тулгуурын дээрх хөндлөвч дээр тулж байх ёстой. Ээлжит алсгалыг буулгаад өмнөх алсгалтай холбон баглаж өгнө. Сүүлийн алсгал нь тулгуургүй байх бөгөөд учир нь нэг сул үзүүрээрээ нөгөө эрэгт тулж байх ёстой.

Тактикийн зориулалт бүхий ямаан тулгуурт гүүрийн зарим үзүүлэлт (Beselerschnellsteg):

Гүүрийн маяг загвар	Ямаан тулгуур бүхий гүехэн усны хатуу тулгуурт гүүр
Даац	300 кг. хүртэл
Явган хүний замын өргөн	50 см.
Алсгалын байгууламжийн урт	4 метр
Алсгалын тоо	Саадын байдлаас хамаарна.
Гүүрийн урт нь	Нарийвчлан тогтоохгүй боловч 50 м
Нэг алсгалын жин .	60-80 кг.
Нэг алсгалыг байгуулахад	40 минут.
Гүүрийг угсрах хүний тоо	4 хүн
Саадын хамгийн гүн нь	2.5 метрээс ихгүй
Саадын хамгийн бага гүн	хамааралгүй
Усны урсгалын дээд хурд	1 м/сек.
Эрэг болон ёроолын хөрсний шинж төлөв.	Шаварлаг, хайргархаг, хатуурсан элстэй
Гүүрийн ашиглалтын хугацаа	Урин дулаан цагт, мөс хөлдөхөөс гэсэх хүртэл

Хийлдэг завин дээрх 2тн хүртэл даацтай бярвааз (Flosssackfaehre 2 t)
Ийм хэлбэрийн гатлага бярвааз нь хийлдэг том завь ашиглан хийж болох ба

Дэлхийн 2-р дайн үед Вермахтын цэргийн гатлалтын орон тооны хэрэгсэл болж байсан түүхтэй аж. Ийм гүүрийг барихын тулд модон материалыг урьдчилан бэлтгэсэн байх шаардлагатай.

Голын өргөн нь 100 м хүртэл , бат бэх найдвартай ган татлага бэлэн байгаа нөхцөлд бярвааз маягийн салыг тусгай хөдөлгүүр ашиглахгүйгээр байгуулж болно. Ажиллагааны гол арга нь голын дээгүүр ган татлагыг хөндлөн татах ба түүндээ салаа холбож 2 ш гулгагч татлагын тусламжаар хөвөлтийг хийдэг. Энэ гулгагч татлагын урт болон таталтын өнцгийг урсгалын хурдаас хамааруулан тогтоох бөгөөд хөвөлтийг хурдан эсвэл удаан болгож болдог.

2тн хүртэл даацтай бярваазны зарим өгөгдөхүүн:

Хөвөгч тавцангийн хэмжээ 6,25х2,66 м

Өндөр нь завины ёроолоос хашлагын дээд ирмэг хүртэл 2,1 м

Хөвөлтийн дээд хурд 5 км/ цаг хүртэл

Зөвшөөргөдөх урсгалын хурд 1,5 м/сек

Усан саадын хамгийн бага гүний хэмжээ 0,5 м

Тоотын бүрэлдэхүүнээс салыг угсрах хугацаа 35-40 минут


Тоотын бүрэлдэхүүн 12 хүн

Нийт жин тоотгүйгээр 1750 кг

Судлаачийн дүгнэлт:


Гүүрийг сааданд байгуулахын өмнө тухайн саадын талаар маш сайн туршуул хийсэн байх шаардлагатай. Учир нь нэгэнт хийсэн тулгуурын өндрийг өөрчлөх аргагүй болдог.

Мэдээж гүүрийн дээд тавцан нь усны мандалтай маш жигд тэгшхэн байна гэж ойлгох хэрэггүй. Гэхдээ 20




см-ээс илүүтэй байж болохгүй. Эс бөгөөс тогтвортой байдлаа алдах ба гүүр хөдөлгөөнтэй болж ганхах, нурах аюултай. Мөн түүнчлэн элсэрхэг хөрс нь хурдан идэгдэж тулгуурыудад суулт өгдөг болохыг анхаар.

Сүүлийн үед иймэрхүү төрлийн салыг манай инженерийн ангийн бүрэлдэхүүн ашиглалтаас гарч байгаа ПМП загварын гүүрийн бие ангийг ашиглан хийж байгаа бөгөөд энэ нь нэг талаар сайн хэрэг боловч нөгөө талаар илүү их зардал гаргаж уг бэлэн хийцийн техникийн өгөгдөхүүнийг алдагдуулж байгаа юм.



Учир нь ПМП гүүрийн нэг бэлэн хэсэг нь 40 тн хүртэл даацтай бөгөөд үйлдвэрээс гаргахдаа сал маягаар ашиглах, хөдөлгүүр суулган хөвөлтийг бие даан гүйцэтгэх зэрэг олон хувилбарыг тусгасан байдгийг мэдэхэд илүүдэхгүй биз ээ.

Хэрлэн, Онон болон Халхын голууд дээр хөвдөг гүүрийг анхлан ашиглаж байсан туршлагаас үзвэл голын эргүүд дээр ган татлагын найдвартай бэхлэсэн нөхцөлд дээрх ПМП гүүрийн бие ангийг ашиглан ХЦ-ийн онцлогийг харгалзан 20 тн хүртэл даацтай 40-



60 орчим гатлага салыг хийж болох бүрэн боломжтой бөгөөд гараар болон моторт хөдөлгүүр ашиглан хөвөлтийг зохицуулах боломжтой. Харин манай нөхцөлд гүүрийн бие ангийг задлан ашиглах нь тэдийлэн сайн шийдэл биш гэдгийг мэргэжил нэгт нөхдүүд маань ойлгох биз ээ.

Хэрвээ 40-60 орчим найдвартай гатлага сал хийж чадвал зүүн талын болон хойд хилийн ангиудын усан саадыг туулах шаардлагыг бүрэн хангах нөөц бэлэн байна гэсэн үг юм.

Улсын хил дээр өндөр даацтай гатлага тэдийлэн шаардлагагүй бөгөөд барагцаалбал 5 тн хүртэл ачааг өнгөрүүлэх даац байхад л бүрэн хангалттай байдаг. Даацыг нэмэгдүүлэх нь материал болон хөдөлмөр зарцуулалтын хэмжээг ашиггүй нэмэгдүүлдэг гэдгийг анхаарах нь зүйтэй.

Инженер хурандаа Х. Гөлгөө

Эх сурвалжууд

1.H.Dv.316 Pionierdienst aller Waffen (All. Pi.D.).Ernst Siegfried Mittler und Sohn Buchdruckerei G.m.b.h. Berlin SW 68. 1935
2.TM-E 30-451 Handbook on German Military Forces. War Departament. Washigton 25. DC. 15 March 1945
3.Учебный кинофильм "Pioniere voran". Hergefftellt unter Mitarbeit der Pioniereabteilung des OKH. 1943.
4.К.Шишкин. Вооруженные Силы Германии 1939-1945 годы. Справочник. Санкт-Петербург.2003г.
5.Руководство по войсковым фортификационным сооружениям. Военное издательство МО СССР. Москва. 1962г.
6.Kriegsstarkenachweisung 714 (freie Gliederung) von 1.6.1944 (K.St. N. 714 (fG) v.1.6.1944) Pionierkompanie (gepanzert) (Freie Gliederung).
7.Kriegsstarkenachweisung 703 von 1.10.1937 (KStN 703 v.1.10.1937). Stab Pionierbataillon (mot).
8.Kriegsstarkenachweisung 714 von 1.10.1938 KStN 714 v.1.10.1938. leichte Pionierkompanie (mot).

СУРГАЛТ, АРГА ЗҮЙ

ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТАКТИКИЙН ХИЧЭЭЛЭЭР БҮЛГИЙН ДАСГАЛ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ.

ДХИС-ийн Хилийн албаны сургууль цэргийн ухааны магистр, хурандаа Г.Пушкин

Бүлгийн дасгал нь газар орон болон зураг, газар орны дүрслэл, хил хамгаалалтын байгууламж бүхий макет дээр суралцагчдыг хил хамгаалах арга, ажиллагаанд сургадаг сургалтын хэлбэр юм. Энэ нь улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах асуудлаар суралцагчдыг хилийн манаа, харуул, застав, отрядын түвшинд тодорхой албан тушаалд тоглуулж мэдлэг дадлага, чадвар олгох замаар цагийн байдлыг үнэлэж дүгнэх, шийдвэр гаргах ба сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлэх үндсэн зорилготой.

Бүлгийн дасгалын онцлог нь суралцагчдад хил хамгаалалтыг удирдах зохион байгуулах асуудлар мэдлэг, дадлага олгох болон хилийн цагийн байдалд үндэслэн онолын асуудлыг гүнзгий ойлгох бололцоо олгохын зэрэгцээ танхимын хичээл хээрийн дадлагын хичээлийн завсрын үе мэт байдагт оршино.

Бүлгийн дасгалыг суралцагчидтай явуулахын өмнө төлөвлөгөөт лекц ,сесминарын хичээлээс гадна холбогдох ном гарын авлага, материалуудыг судлуулан ,тодорхой хилийн цагийн байдал үүсгэж, манаанаы ахлагч, харуулын дарга, заставын дарга, отрядын дарга , бусад албан тушаалтнуудын дүрд ажиллахад бэлтгүүлнэ. Хичээл эхэлмэгц багшийн уирдлагын дор бодит цагийн байдал дээр томилогдсон албан тушаалын хүрээнд цэргийн удирдлагын асуудлуудыг боловсруулна. Бүлгийн дасгалыг явуулах арга, хэлбэр, сургалтын хэрэглэгдэхүүнээс шалтгаалж хичээлийн танхимд ,газар орон дээр КШС-ийн элементтэй болон элементгүй холбооны хэрэгсэлтэй ба хэрэгсэлгүй эсрэг талын ажиллагааг тэмдэглэн үзүүлэх ажиллагаа, дууриалган үзүүлэх хэрэгсэлийг ашиглан явуулна.

КШС-ийн элементтэй бүлгийн дасгал нь гадаад ,дотоодоос улсын хил зөрчсөн, хилийн хариуцсан хэсэгт зэвсэгт тулгаралт, зохион байгуулалттай гэмт этгээдүүдийн үйл ажиллагааг таслан зогсоох, хорон сүйтгэх бүлэгтэй тэмцэх зэрэг цагийн байдалд ойртуулсан нөхцөлд суралцагчдыг сургах ажиллагаа юм. Энэ хичээл дээр суралцагчдаас хилийн харуул, хилийн застав, хилийн отрядын удирдлагын байр, түр байр байгуулж аль нэгийг нь захирагчаар бусад нь удирдлагын үлдсэн албан тушаал дээр томилогдон ажиллана. Хичээлийн явцад ихэвчлэн 1-2 сургуулийн асуудал боовсруулсаны дараа суралцагсадын албан тушаалуудыг хооронд нь сольж ажиллуулна. Энэ хичээлийн онцлог нь дүрд тоглож байгаа суралцагч дээр тулгуурлан явагдах бусад суралцагсад түүний удирдлагад ажилладаг.

КШС-ийн элементгүй бүлгийн дасгал нь газар орон дээр, тэнхимд холбооны хэрэгсэлтэй, хэрэгсэлгүйгээр явагдана. Аль болохоор бодит цагийн байдалд хичээлийг ойртуулан явуулахыг эрмэлзэх хэрэгтэй ба үүний тулд хичээлд төрөл бүрийн макет дуу чимээний хэрэгсэл, сургуулийн гранат, сум утаат шашки, гэрэлтүүлэгч хэрэгсэл зэргийг өргөн ашиглан явуулна.

Хилийн харуул заставын

бүрэлдэхүүнд байгаа захирагч, дарга нарыг орлон сургахдаа тоглуулж бүлгийн дасгалыг салбаруудын үйл ажиллагаатай уялдуулан бодит цагийн байдалд ойртуулсан нөхцөлд явуулах ба аажмаар биеээр гүйцэтгэх ажиллагаанд сургахад чиглүүлж явуулна. Энэ үед сургалтын үндсэн арга нь дасгал дадлагууд байна.

Бүлгийн дасгалын сэдэв нь журам мэт улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах, тодорхой хэсэгт хилийн эрэл явуулах ажиллагааг багтаах ба хэд хэдэн хичээлийн туршид боловсруулагдана. Бүлгийн дасгалын үргэжлэх хугацаа нь 4-7 цаг байх ба нэг хичээлээр хамгийн түвэгтэй 2-3 нь асуудал боловсоруулах нь зүйтэй.

Хээрийн хичээлээр байр зүйн болон тактикийн баримжаалал хийх, эрэл хайгуулын бүлэг ажиллуулах, зэвсэгт халдлагын таслан зогсоох, эрэл явуулах, хил хамгаалалтыг зохион байгуулах зэрэг чухал сэдвүүдийг боловсруулана. Танхимд явагдах хичээлээр газар орон дээр боловсруулах шаардлаггүй асуудлууд хээрийн хичээл дээр бүрэн боловсруулаагүй асуудлуудыг гол төлөв авч үзнэ.

Холбооны хэрэгсэл ашиглан явуулдаг хичээл нь цагийн байдлын тухай мэдээ хүлээн авах дамжуулах, холбооны хэрэгсэлийг ашиглан зшийдвэр гаргах, бий болсон цагийн байдлыг үнэлж үүрэг тавих, цэргийн далдуур удирдлагын шаардлагыг хангах зэрэгт суралцуулна.

Дуурайлган үзүүлэх хэрэгсэл, тэмдэглэн үзүүлэх ажиллагааг ашиглан явуулж байгаа бүлгийн дасгал нь газар орныг хянах, тухайн цагийн байдлыг зураг дээр оруулах газар орон дээр бодитоор цагийн байдлыг үнэлэх, богино хугацаанд шийдвэр гаргах үүрэг тавих асуудлуудыг боловсруулахад таатай нөхцлийг бүрдүүлж өгдөг.

Бүлгийн дасгалын бэлтэлийг хэрхэн хангах вэ? Бүлгийн дасгал нь ихэвчлэн судлах сэдвүүдийг онолын түвшинд бүрэн судалж, семинар дадлага явуулсны дараа хээрийн хичээлийн өмнө явагдана

Бүлгийн дасгалыг зохион байгуулах бэлтгэл нь даалгаврыг боловсруулах, удирдагч ба түүний туслахуудыг бэлтгэх, суралцагчдыг болон сургуулийн материаллаг баазыг бэлтгэх зэрэг ажлууд хамаарна. Эдгээр ажлууд дотроос хамгийн түрүүнд нь бүлгийн дасгалын даалгавар, явуулах төлөвлөгөөг боловсруулах явдал юм. Дасгалын үед боловсруулах даалгаврууд нь агуулгын хувьд хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах ,хил зөрчигчийг эрэх, саатуулах, баривчлах, хүч нэмэгдүүлсэн хамгаалалт, онцгой байдлын үеийн хамгаалалтын тактик үйл ажиллагааг тусгасан байхын зэрэгцээ суралцагчдын сургалт бэлтгэлийн түвшинд зохицсон байна. Дасгалын даалгаврууд дараах дэс дараалалтай боловсруулна.Үүнд: Юуны өмнө дасгалын сэдвийг судлан, зорилго, боловсруулах асуудлыг тодорхойлон зарцуулах цагийн тооцоог гаргана.

Дасгалын зорилго нь Штабы дадлага болон хээрийн хичээлийн үед илэрсэн дутагдлыг арилгахад оршиж болно. Үүний дараа холбогдох ном, дүрмийг сонгон авч судлаад бүлгийн дасгалын тактикийн бодлогыг боловсруулна. Тактикийн бодлогын үндэс нь хичээлийн явц, үр дүн, дадлага сургуультай уялдсан байхын зэрэгцээ хилийн анги салбаруудад хил хамгаалалтын тактикийн чиглэлээр явагдсан дасгал сургуулийн ололттой талуудыг тусгасан байвал зохино.

Дасгал явуулах газар орон, байр танхимаа сонгон авч сургал алба , арга зүйч нарт дасгалын зорилго , зорилтууд, боловсруулах асуудлыг танилцуулна. Бүлгийн дасгал гүйцэтгэх цагийн 90 орчин хувийг суралцагчдын дасгал боловсруулахад, 10 орчим хувьд нь удирдагч чиглүүлэхээр төлөвлөх нь зүйтэй.

Бүлгийн дасгалын бэлтгэлийн агуулга.

Хилийн манаа, харуул , заставын өгөгдөхүүнийг тодорхойлох тодотгох
Цагийн байдал
Хичээл явуулах төлөвлөгөө
Багш, суралцагчдын бэлтгэл
Бүлгийн дасгал явуулах газар орон анги танхимын бэлтгэл
Сургалтын хэрэглэгдэхүүний бэлтгэл
Газар орны туршуул
Тухайн газар орны байршлын зураг / 1:50000, 1:100000/
Хил хамгаалах төлөвлөгөө
Хил хамгаалах шийдвэр

Бүлгийн дасгалын бэлтгэл ажил нь анхны өгөгдөхүүнийг тодорохойлох,тодотгох

Анхны өгөгдөхүүнд:

Сэдэв
Сургуулийн зорилго
Боловсрулах асуудал
Суралцах бүрэлдэхүүн
Дотоод , гадаад цагийн байдал
Хугацаа
Цэргийн байр зүйн зураг
Явуулах газар орон, байр танхим
Шаардлагтай материал хэрэгсэл

Бүлгийн дасгалын удирдагчийн туслахын тоо зэргийг заана.

Сэдэв, үргэжлэх хугацаа, боловсруулах асуудал , сургалт явуулах газар орныг сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт заасны дагуу ахлах даргын тушаалаар тодорхойно. Энэ үед нь бусад хичээлийн уялдаа холбоог сайтар харгалзах нь зүйтэй.

Хэрэв бүлгийн дасгалын сэдвийг хэд хэдэн хичээл дээр боловсруулах шаардлагтай бол хичээлийн удирдагч боловсруулах асуудлуудын дарааллыг тогтоож өгнө.

Анхны өгөгдөхүүнгийг тодорхойлсны дараа бүлгийн дасгалын удирдагч хичээл явуулах төлөвлөгөө, шаардлагатай бусад баримт бичгийг боловсруулах ажилд орно.

Бүлгийн дасгал явуулах төлөвлөгөө нь үндсэн баримт бичиг бөгөөд энэ нь дасгал боловсруулах явцад ямар үед нь нэмэгдэл цагийн байдал өгч үнэлэлүүлэх, дүгнэлт хийлгэх, шийдвэр гаргах ажиллагааны бодлогыг агуулдаг. Энэ төлөвлөгөө нь ихэвчлэн газрын зураг дээр боовсруулагдах ба дараах зүйлүүдээс бүрдэнэ.Үүнд:

1 Анхны өгөгдөхүүн / сэдэв, бүлгийн дасгалын зорилго, боловсруулах асуудлууд, суралцах бүрэлдэхүүн, хичээл явуулах байр,материал хэрэгслийн хангалт /

2. Хил хамгаалалтын тактикийн болон оператив-тактикийн ажллагааны бодомж / Хилийн анги салбаруудын гүйцэтгэх үүрэг, хил хамгаалах тушаал шийдвэр, байрлал, эсрэг талын хил хамгаалалтын байдал тэдгээрийн тактик үйл ажиллагаа, дотоод, гадаадаас хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлүүд, хичээлийн боловсруулах асуудал бүрийн дараа үүсгэх цагийн байдал /

3. Бүлгийн дасгалын явцад удирдагчаас авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд орно.

Бүлгийн дасгалыг явуулах

Бүлгийн дасгал явуулах жаиллагаа нь хичээлийн бэлтгэлийг шалгах, төлөвлөсөн сургуулийн асуудлыг боовсруулах, дүн гаргах гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

Эдгээр ажлын хэмжээ нь хичээл явуулах байр, арга, хичээлийн хэрэглэгдэхүүнээс шалтгаалж тодорхойлогдоно.

Ихэвчлэн бүлгийн дасгалын удирдагч суралцагч нараас цэргийн байр зүйн зургийг ажилд бэлтгэж шаардлагатай өгөгдөхүүн, тайлбар бичглэл, зургийн толгой , хөл , нэмэгдэл цагийн байдлыг зөв оруулсан эсэх, холбогдох тооцоонууд, өөрийн болон эсрэг

талын цэрэг, цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, зэвсэглэлийг мэдэж байгаа байдал, хичээлд шаардлагатай материал, техник хэрэгслүүдийг шалгана. Энэ хэсэгт 5-10 минут зарцуулж болно.

Хичээлд бэлэн эсэхийг шалгаж дууссаны дараа бүлгийн дасгалаар боловсруулах сэдэв, асуудлуудыг суралцагчдад зарлаж бүлгийн дасгалыг эхлүүлэнэ. Бүлгийн дасгал боловсруулах сургуулийн асуудал бүрийн өмнө удирдагч багш суралцагчдад хийсвэр цаг, ямар албан тушаал дээр хэн суралцах, тухайн албан тушаал дээр ямар асуудал хэдий хугацаанд боловсруулах зэргийг заана. Суралцагч бүрийн илтгэлийг сонсох замаар хичээлийг явуулах ба илтгэлүүдийг сонссоны дараагаар суралцагч нэг бүрийн ололт дутагдлыг тэмдэглэж тайлбар өгнө.

Суралцагчид цагийн байдлыг хэрхэн үнэлэж, дүгнэх, шийвэр гаргах талаар багш өөрөө үлгэрлэн үзүүлнэ. Бүлгийн дасгалын явцад шийдвэр гаргах , ахлах дарга, түүний штаб, хөршүүд, бусад албан тушаалтнуудын үйл ажиллагааг гол төлөв багш өөрөө болон эсвэл дээрх албан тушаалын дүрд тоглохоор бэлтгэгдсэн суралцагч хийж үзүүлнэ.

Бүлгийн дасгалын болосвруулах нэг асуудал нөгөөд шилжих үед цагийн байдлыг тодотгож, амаар болон бичгээр захирамжийн хэлбэрээр өгч хэрэгжүүлэх ба суралцагчдыг өөр өөр албан тушаалд сэлгүүлэн үүрэг гүйцэтгүүлнэ.

Бүлгийн дасгал нь газар орон дээр буюу танхимд холбооны хэрэгсэлтэй хэрэгсэлгүй явагдана.Бодит цагийн байдалд ойртуулан явуулахын тулд хил зөрчигчийг илрүүлэх, мөрдөн хөөх, баривчлах, хугялан хүргэх ажиллагааг орлон тоглогч , дурилган үзүүлэх хэрэгсэл ашиглан харуулна. Энэ хичээл дээр төрөл бүрийн макет, дуу чимээний хэрэгсэл, сургуулийн гранат, сум, гэрэлтүүлэгч , дохионы хэрэгсийг ашиглана. Бүлгийн дасгалын хичээлийн сургалтын үндсэн арга нь дасгал дадлагууд байдаг.Багшийн удирдлагын дор шийдвэр гаргах, илтгэх, үүрэг тавих, зурмал болон ббичмэл баримт бичиг боловсруулах зэрэг үйл ажиллагаанд сургах дасгал, дадлагыг боловсруулахдаа үзүүлэх , тайлбарлах зэрэг аргуудыг өргөн хэрэглэдэг.Хичээлийн төгсгөлд дүн гаргахдаа:

Багш хичээлийн сэдэв, зорилго, боловсруулсан асуудал_ оператив-тактикийн ажиллагааны бодлогыг зарлаж танилцуулна.

Суралцагчдын гаргасан шийдвэрийн ашигтай хувилбаруудыг тодруулж хэлнэ.

Хичээлийн явцад боловсруулсан асуудлын талаар суралцагч нар хэрхэн ойлголттой болсныг дүгнэнэ.

Суралцагчдыг хүн нэг бүрээр үнэлнэ

Цаашид юунд анхаарах, судлах талаар суралцагчдад чиглэл өгнө.

АСУУДАЛД СУУРИЛСАН СУРГАЛТ ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Ж.Уганчимэг ДХИС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш

Хурдацтай техник, технологи өөрчлөгдөн буй өнөөгийн нийгэмд өчигдрийн олж авсан мэдлэг маш хурдан хуучирч байна. Иймээс багш нарын заах аргад өөрчлөлт орж дэлхийн боловсролд " Асуудалд суурилсан сургалтыг " хэрэглэж, үр дүнд хүрээд байна. Хуучнаар суралцагсдадаа " Идэх талхыг өдөг байсан бол талх барих аргад сургах " арга зүй рүү шилжлээ.

Дэлхий дахинд мэдээлэлийн урсгал хүчтэй орж ирж буй байдал, техник технологийн дэвшингүй хөгжил нь багш нарт заах арга зүйгээ өөрчлөх хэрэгцээ, шаардлага бий болсныг илэрхийлж байна.

Багш бид хичээл заах явцдаа дараахь алдааг гаргадаг байна.

бүгдийг заахыг эрмэлздэг

зөвхөн онолын өндөр мэдлэг өгөхийг хүсдэг

аливаа зүйлийг заахдаа энгийн зүйлийг орхигдуулдаг

энгийн зүйл нь амьдралд ямар чухлыг анзаардаггүй

суралцагч бүр заасан хичээлийг ижилхэн ойлгож чаддаггүйг анхаарч үздэггүй

тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх аргыг шууд заадаг

ямар нэгэн асуудалтай тулгарвал хэрхэн шийдэх талаар суралцагчдаар ажиллуулдаггүй

өмнө олж авсан мэдлэгт суурилан хичээлээ явуулдгаас нийгэмд ямар их хурдацтай өөрчлөлт болж буйг олж хардаггүй г.м

Эдгээр бидний гаргадаг алдааг тодорхой хэмжээнд багасгах арга замын нэг нь **Асуудалд суурилсан сургалтын хэлбэр юм.**

Асуудалд суурилсан сургалт нь суралцах арга / Learning method / бөгөөд суралцагч нь ямар нэгэн асуудалтай / бэрхшээл/тулгарахад хэрхэн түүнийг олж илрүүлэх, эмх цэгцтэйгээр шийдэхэд суралцахыг явдал юм.

PBL – ийн сургалтын онцлогоос:

Багшид тусдаа ширээ, сандал байдаггүй


Бүлэгт " 1 tutor" болон бүлэг бүрт нэг, нэг " Facilitator"ажилладаг

Tutor болон Facilitator нь оюутанд туслах, дэмжих, үнэлэх, туслах, дэм өгөх, өдөөх үүрэгтэй

Teacher: Багш нь оюутныг ямар нэгэн хичээл дээр " юм " сурахад нь туслах, чиглүүлэх, зааварчлах, заах

Facilitator: Чиглүүлэгч багш / Аливаа зүйлийг илүү хялбараар хийхэд туслах

Tutor: " Дэмжих" багш / Бүлгээр ажиллахад чиглүүлэх, оюутан бүрт туслах, зөвлөх, манлайлах, удирдах../



гэсэн хэлбэрүүдээр зохион байгуулж явуулдаг байна.

Тохиолдол бол асуудалд суурилсан сургалтын гол хэрэглэхүүн юм.Тухайн тохиолдол нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой.

Тухайн хичээлийн сэдэвтэй холбоотой нийгмийн хэрэгцээнд үндэслэсэн
Практикт тохиолддог үйл явдлыг дууриасан
Жинхэнэ болон, стандарт үйлчлүүлэгч, цаасан дээр болон видео бичлэгээр авсан үйлчлүүлэгчийн жишээг ашигласан
Зайлшгүй мэдэх хэрэгцээнд үндэслэсэн, ойлгомжтой үгээр бичигдсэн, тухайн мэргэжлийн баг, хамт олноор хэлэлцэгдсэн байна.

Problem based learning -ын давуу ба сул тал

Давуу тал

Идэвхитэй суралцах хүсэлтэй болдог.
Эргэцүүлэн бодох чадвар сайжирдаг
Харилцааны соёлд суралцдаг
Багаар ажиллаж сурдаг.
Асуудлыг зөв тодорхойлж шийдэх чадвартай болно.
Нийгмийн хэрэгцээнд үндэслэн суралцдаг
Багш болон оюутанд сонирхолтой
Хичээл хоорондын уялдаа сайжирдаг
Аливаа мэдлэгийг өөрийн болгож авдаг.
Алдаан дээрээ суралцдаг.
Шууд цээжлэх байдал багасдаг

Сул тал

Цаг их зарцуулдаг
Хичээлийн урьдчилан бэлтгэл их чухал / тохиолдол боловсруулах /
Багш бүр тусгай сургалтанд хамрагдах шаардлагатай.
Багшаас практикт ажилласан туршлага шаарддаг
Хүн хүч шаардагддаг
АСС-ын өрөө тохижуулсан байхыг шаарддаг. / баг бүрт зөөврийн самбар, цаас, үзэг, шохой/
Номын сан өндөр түвшинд / төрөл /
АСС-ыг зохион байгуулах үед:
Багш:
- оюутны унших ёстой номын, сэтгүүлийн жагсаалтыг гаргах,
- оюутанд зориулсан хөтөч бэлдэх,
- гарын авлага, сурах бичгийг багаар бичих
- унших материалыг эрж хайх, эх үүсвэрийг бэлтгэх гэх мэт бэлтгэлийг хангасан байхыг шаарддаг.

Оюутан :
- хичээлд заавал бэлдэж ирэх, илүү бодох, сэтгэх, ярих,
- илтгэх чадвар шаардагдах
- хичээлд маш их идэвхитэй оролцох,
- өөрийгөө тухайн бүх сэдвээр бэлтгэсэн байхыг шаарддаг байна.

Сургалтыг асуудалд суурилсан сургалтын хэлбэрээр зохион байгуулснаар дараахь үр дүнд хүрнэ хэмээн миний хувьд үзэж байна.

Сурах хүсэл эрмэлзлэлийг төрүүлдэг, суралцах хариуцлагаа ухамсарлахад тусална.

Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлнэ.

Суралцах сонирхол төрүүлэхүйц, илүү үр дүнтэй суралцах хөшүүрэг болно.

Багаар ажиллах чадварыг сайжруулдаг бөгөөд харилцааны ур чадвар эзэмшдэг

Өөрийн ажилдаа эзэн нь болж чадсанаа үнэлэхэд туслана.

Насан туршдаа суралцах, өөрийгөө хөгжүүлэх улмаар итгэлтэй болох, илүү сониуч байх аргад сургана.

Эцэст нь дүгнэж үзвэл Хууль зүйн сургалтыг чанартай явуулах, чадварлаг мэргэжилтэн бэлтгэх, чанартай боловсрол олгох арга хэрэгслийн нэг нь Асуудалд суурилсан сургалт юм.

Асуудалд суурилсан сургалт нь зөвхөн заах арга бус, хандлагад суралцах үйл явц юм. Тиймээс өнөөгийн Эрх зүйн боловсролын шинэчлэл нь Асуудалд суурилсан сургалтаас эхлэнэ.

ХИЛИЙН ТҮҮХ

МИНИЙ АЖЛЫН ҮР ДҮНГ ХАМТ ОЛНЫ БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНГЭЭС САЛГАХ АРГАГҮЙ

"Дурсамж"

Би түүх, соёл иргэншлийн давтагдашгүй өвөрмөц онцлогтой Монгол улсынхаа иргэн гэдгээр бахархдаг хүмүүсийн нэг. Энэ жил төрт улсаа мандуулж хөгжүүлсний хоёр мянга хоёр зуун хорин жилийн ойг манай улс даян дэлхийн хамтын нийгэмлэг, олон улсын байгууллага, ард түмэнтэй хамтарч нэр төртэй өргөн сайхан тэмдэглэж байна. Олон улсын болон үндэсний эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэн судлаачид Монголчуудын хорин хоёр зууны гайхамшигт түүхийг судлан шинжилж манай өвөг дээдсийн бий болгосон нээлт, ололт, туршлага, үнэт сургамжийг хүмүүн төрөлхтний, мэдээлэл шинжлэх ухааны ариун сан, эргэлтэд оруулсаар байна.

Монгол улс орших, эс оршихын дэнсэн дээр тулж очсон XIX, XX зууны зааг дээр нарийвчилбал мянга есөн зуун арван нэгэн онд Богд хаант улсаа байгуулж, улмаар 1921 оны ардын хувьсгалаар төгс баталгаажуулсан Монгол улсын өвөрмөц түүх нь Монголчуудын хувьд онцгой ач холбогдолтой нь мэдээж хэрэг. Улс нийгэм, өвөг дээдсийнхээ нандин түүхийг гүн гүнзгий, өргөн цар хүрээнд, ул үндэстэй иж бүрнээр судлан шинжилж бодит байдлыг нь танин мэдэх тутам тэр хэмжээгээр залуу үе шинэ мэдлэгээр өөрийгөө баяжуулж өв тэгш төлөвшихөд гайхамшигтай үр дүнтэй нөлөөлдгийг энэ үеийн практик нотолж байна.

"Та нар нэр төртэй сайхан амьдар. Тэгвэл нас ахиад эргэж бодохын цагт хоёр дахь удаагаа амьдарсан мэт сэтгэл ханах болно" гэсэн үг байдаг. Энэ сургаалийг Дээрхийн гэгээн арван дөрөв дүгээр Далай лам айлдсан юм. Түүхийг эргэн дурсваас бидний өвөг дээдэс энэ сургаалийг жинхэнэ ёсоор хэрэгжүүлэгчид байжээ. Бид ч энэ сургаалийн гадна хальж гишгэх эрхгүй гэдгийг уламжлал, заншил, ёс суртахуун, зөн совингоороо мэдэрч ажиллаж амьдарч иржээ гэсэн дүгнэлт хийхэд хүргэдэг. Үүнийг би эгнээнд нь олон арван жил багтаж нэг зорилго үйлсийн төлөө хамт амьдарч ажиллаж тэмцэж ирсэн дайчин нөхөд, баатарлаг хилчид, хамт олондоо хандан хэлж байгаа юм.

Би хилчин удмын хүн. Манайх гэдэг айл үе дамжсан хилчин удамтай байжээ гэж болохоор дүр зураг гарч ирдэг. Миний бие эхээс мэндэлсэн Дорноговь аймгийн Эрдэнэ сум нь Монгол улс Манжид дагаар орж Де-Факто буюу харьцангуй бие даасан хэлбэрээр орших болсон цаг үеэс хойш хорин найман жилийн дараа тухайн үеийн Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуутай зэрэгцэн бие даасан Зул гүн, Цогт гүний хошуу болон оршиж иржээ. Өөрөөр хэлбэл одоогийн Замын-Үүд гэж олны танил болсон "Хилийн боомт" нь одоогийн Эрдэнэ сумын газар нутаг болж байгаа юм.

1719 онд эх сууриа тавьсан энэ боомт нь тухайн үед Ази-Европыг холбосон олон улсын харилцааны "Боомт-Хошуу" болж байжээ. Энэ боомт нь эдүгээ дэлхийг сүлжилдүүлэн холбосон авто зам, ган замын олон улсын боомтын төвшинд хүрч хөгжиж байна. Энэ боомтын дээгүүр агаарын зам дайран улсын хилээр нэвтэрдэг.

Миний хувьд 1958 онд цэргийн албанд мордон Монгол улсын умард хил дээр, нарийвчилбал 1727 онд Оросын хаант гүрэн, Манж-Чин гүрний хооронд, үнэн хэрэгтээ Монгол Оросын хооронд хил тогтоох эхлэл тавигдаж гэрээ байгуулагдсан газар нутаг болох одоогийн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот дахь хилийн ангид томилогдон хоёр жил хилийн манаа, харуулын үүрэг гүйцэтгэж байлдагчаас тасгийн дарга, салааны орлогч хүртэл бага түрүүч, ахлагчийн цолтой алба хашсан юм. Тэр цагаас эдүгээ хүртэл 53 жил хилийн аюулгүй байдлыг хангах албыг хашиж явна. Үүнээс ихэнхи хугацааг хилийн манаа, харуул, анги удирдах, хэлтэс, газар, яамны удирдлагад ажиллажээ. Энэ дотроос хилийн ба дотоодын цэргийг удирдах ерөнхий газрын дарга, нийгмийг аюулаас хамгаалах яамны нэг дүгээр орлогч сайд, Батлан хамгаалах яамны орлогч сайд зэрэг албанд арван гурван жил ажиллажээ. Харин эрдэм шинжилгээ судалгааны ажлыг үндсэн ажилтай хавсарч арван гурван жил, дагнасан байдлаар хорин нэгэн жил судалгаа шинжилгээний ажил эрхэлж байна.

Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогыг хэрэжүүлж улсын хилийн баталгаажилт хамгаалалтыгудирданзохионбайгуулах албанд намайг томилохдоо мэргэжлийн өндөр боловсрол эзэмшүүлж 1960-1963 онд Москва хот дахь хилийн цэргийн тусгай дунд сургууль, 1967-1970 онд Фрунзын нэрэмжит цэргийн академи, 1982-1984 онд Зэвсэгт хүчний жанжин штабын академид сурч амжилттай төгсгөх бололцоо олгосонд баярлаж явдаг.

Миний ажлын үр дүнг хамт олны бүтээлч үйл ажиллагаа, үр дүнгээс салгах аргагүй юм. Намайг цэргийн албанд анх ирж байх тэр үед Монгол улс хөрш улсуудтайгаа улсын хилийг тогтоож амжаагүй байлаа. Монгол улсын хил дээр тус бүр нь тасгийн хэмжээний арван найман хилийн пункт, байцаан өнгөрүүлэхээс өөр хүч хэрэгсэл байсангүй.

Гэтэл бидний ажиллаж амьдарч ирсэн XX зууны сүүлийн хагаст Монгол улс хөрш БНХАУ, Зөвлөлт холбоот улс буюу одоогийн ОХУ-тай улсын хилийг тогтоон тэмдэглэсэн юм. Үүний үр дүнд манай улс 8252.6 км баталгаажсан дархан хилтэй боллоо. Эсрэг тэсрэг хоёр систем дэлхийг ноёрхсон мөн гадаадын зарим улс гүрэн Монгол улсын тусгаар тогтнол, улсын хилийн халдашгүй дархан байдалд өнгөлзсөн бодлого үйл ажиллагаа явагдаж байсан эгзэгтэй он жилүүдэд хилийн цэрэг хөгжлийнхөө шинэ шатанд гарч Монгол улсын хилийн халдашгүй дархан байдал найдвартай хангагдаж улсын хил дээр, хил орчмын орон зайд улс нийгэм, ард түмний язгуур эрх ашиг бүрэн төгс хамгаалагдсан юм. Хэрэв улсын хил манах, хамгаалах төрийн бодлого тодорхой байж хилчдийн алба хаах бололцоо, чадвар өндөр байвал улсын хилд нөмөрсөн аюул заналыг зэвсэгт будлиан, дайнд хүргэх шалтаг шалтгаан гаргахгүй байх нөхцөл бүрдүүлж болдгийг тухайн үеийн практик нотолсон юм.

Хэрэв аливаа үйлс эхлэл төгсгөлтэй, учир шалтгаантай, хэмжих үр дүнтэй байдаг гэж үзвэл эгнээнд нь миний бие багтаж байдаг хилийн цэрэг, хил хамгаалах байгууллагын бодлого, үйл ажиллагааны гол үр дүнг үүгээр дүгнэж болох байх гэж үзэж явдаг.

Сансар, мэдээлэл, даяаршлын шинэ эриний анхдагч XXI зуун нь

Монголчуудын өмнө шинэ зорилт дэвшүүлэв. Монгол улс энэ онцлогт нийцүүлэн 2002 онд НҮБ-аас тодорхойлсон гурав дахь мянганы зорилтыг хэрэгжүүлэхээр урагшилж явна. Монгол улс хөрш улсуудтай тогтоон тэмдэглэж баталгаажуулсан улсын хилийн хүрээнд багтах өөрийн эзэмшлийн газар нутаг дээр улс нийгэм, ард түмний дээд эрхийг хэрэгжүүлэх үйлст тодорхой амжилт гаргасаар байна. Гэвч даян дэлхийд энх тайван тогтвортой байдал жинхэнэ голдрилдоо орж улс ард түмэн амар амгалан амьдрах таатай нөхцөл хараахан бүрэн төгс шийдвэрлэгдэж амжаагүй байгааг хэн бүхэн мэдэж харж байна.

Энэ нөхцөлд улсын хил дээр түүний орчин буюу орон зайд үндэсний аюулгүй байдал хангагдах таатай нөхцөл бүрдүүлж, тэнд улс нийгэм, ард түмнийхээ язгуур эрх ашгийг хангаж хамгаалах зорилт хурц тавигдаж байгаа юм. Үүнийг хангаж хөтлөх үндсэн арга нь яах аргагүй шинжлэх ухаан мөн. Иймд эрдэм шинжилгээ, сургалт дэлхий даяар асар өндөр төвшинд тавигдаж байна. Энэ өнцгөөс авч үзвэл үндэсний аюулгүй байдал, улс орны батлан хамгаалах үйлсийн тэргүүн шугам болох улсын хил дээр үүрэг гүйцэтгэх онцлогтой мэргэжлийн байгууллага болох хилийн цэрэг, хил хамгаалах байгууллагын хувьд шийдвэрлэх тулгамдсан олон асуудал шил шилээ харан дэвшигдэн гарч ирэв. “Салбар шинжлэх ухааныг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлэх” –ийг төрөөс боловсрол шинжлэх ухааны талаар баримтлах бодлогод онцгойлон авч үзжээ.

Энэ шаардлагад нийцүүлэн НҮБ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн “хил шинжлэлийн ухаан”-ыг хөгжүүлэх чиглэлээр хорь гаруй жил манай эрдэмтэн судлаачид идэвхтэй ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна. Монгол улсын Үндсэн хууль, хилийн талаар төрөөс баримтлах бодлого, улсын хилийн тухай хууль зэрэг олон эрх зүйн баримт бичгийг боловсруулан албан ёсны болгоход хилчдийн эгнээнээс төрсөн төр, нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн судлаачид идэвхтэй оролцлоо. Хилчдийн эгнээнээс гуч шахам эрдэмтэд төрж, Батлан хамгаалахын их сургууль дээр цэргийн шинжлэх ухааны хэлбэрээр, хил шинжлэлийн ухааны чиглэлээр олон эрдэмтэн эрдмийн зэрэг хамгаалж хэд хэдэн докторант хамгаалах бэлтгэлийг хангаж байна. Дал гаруй жилийн түүхтэй Хилийн цэргийн дээд сургууль сургалт, эрдэм шинжилгээний шатнаас зүй тогтлынхоо дагуу шинжлэх ухааныг урьтал болгосон эрдэм шинжилгээ сургалтын шинэ тогтолцоонд шилжин орлоо.

Хилийн албаны сургуулийг эгнээндээ багтаасан, засгийн газрын бие даасан агентлаг болох Дотоод хэргийн их сургууль хоёр мянга арван нэгэн оны долоо дугаар сарын найманд байгуулагдаж эрдэм шинжилгээний хүрээлэн бий болгож хууль зүй, хил шинжлэлийн ухаанаар докторант, магистрантын сургалт явуулж эхлэв. Хил хамгаалах байгууллагын дэргэд шинжлэх ухаан, технологийн зөвлөл, хил судлалын сектор, архив, музей, сургалт эрдэм шинжилгээний түшиц газрууд, онол арга зүйн сэтгүүл, олон төрлийн номын сангуудтай болж эрдэм шинжилгээ судалгааы ажил эрчимтэй өрнөж байна.

Эрдэмтэн судлаачдын эрдмийн бүтээл, нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын авлага зэрэг судалгаа шинжилгээсурталчилгааныолонзуун бүтээлийн сан хөмрөгтэй болжээ. Хил шинжлэлийн ухааны үүсэл хөгжилд Монгол улсын оруулсан хувь нэмэр асар их болохыг судалгааны үр дүн харуулдаг. Монгол улс хоёр мянга хоёр зуун хорин жилийн өмнө өмнөд хөрштэй найрамдлын гэрээ байгуулж улсын хилийг цагаан

хэрмээр тогтоож өөрөөсөө жар дахин илүү хүчтэй Хан гүрнийг өөрийн улстай "эн зэрэгцэх гүрэн"-ий зэрэгт хүлээн зөвшөөрүүлсэн гайхамшигтай түүхтэй. Ингэснээр дэлхийд олон улсын эрх зүйгээр "Делимитаци", "Деморкаци", гэж ойлгогдож томъёологдсон улсын хилийг тодорхойлох, тогтоох тухай шинэ мэдлэгийн үндсийг тавьсан улсын нэг нь Монгол улс болсон юм.

Монголчууд алсаас тооцвол хоёр мянга гаруй жилийн тэртээгээс ойроос үзвэл найман зуун таван жилийн өмнөх Их монгол улсын үеэс улсынхаа хилийг цэргийн хүчээр аравт, зуут, мянгат, түмтийн тогтолцоонд оруулж улсын хилийн аюулгүй байдлыг хангаж байжээ. Улс оронд учрах аюулын чиглэл, нөхцөл байдлыг харгалзан улсын хилийг бүсчилэн ангилж баруун, зүүн түмтийн тогтолцоонд оруулан хамгаалж улсын хилийг үндсэн обьект болгон "халдан ирэх дайсны харайх замыг хааж, өрсөлдөн ирэх дайсны өмнөх замыг бөглөж, буцах дайсны борвийг хянгардаж явах" онол практикийг хэрэгжүүлж ирсэн тухай нууц товчоонд өгүүлсэн байдаг билээ. Энэ бүхний үр дүнд Монгол улс нь эдүгээ хил шинжлэх ухааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг болсон "хил хамгаалах стратеги", "бүсчлэн хамгаалах урлаг", "хил хамгаалах тактик"-ийн онол практикийн үндсийг бүрдүүлж цэргийн байгуулалтын эхийг тавилцсан улсын нэг болж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол улсын 8252.6 км хил, түүнийг хамгаалах дэглэмийг агуулсан олон улсын эрх зүйн баримтыг хилчид бодитойгоор хэрэгжүүлж байна. Тэгэхээр шинжлэх ухаан гэдэг нь ачир дээрээ бодит байдлын обьектив мэдлэгийн нэгдсэн системчлэл гэж үзвэл хил шинжлэлийн ухаан нь бодитой бөгөөд үүнийг дэлхийн эрдэмтэд "улсын хилийн тухай шинжлэх ухаан мөн" гэж хүлээн зөвшөөрчээ. Олон улсын практикт хил шинжлэлийн ухааны нэр томъёонд олон ургалч үзэл бодол, байр сууринаас хандаж зарим хэсэгт "Лимилоги" өөр хэсэгт "Погранологи" гэж нэрлэж байгаа боловч мөн чанар агуулга нь хил шинжлэлийн ухаан гэсэн ойлголтод багтаж байна. Иймд би Монгол улс хилээ тэгс баталгаажуулж, хамгаалж, шинжлэх ухааны байр сууринаас хөгжлийнхөө чиг хандлагыг тодорхойлж үйл ажиллагааныхаа үр дүнг үнэлж тооцоход хил шинжлэлийн ухааныг салбар шинжлэх ухааны хэмжээнд төлөвшүүлж хэрэгжүүлэхэд өөрийн зүгээс шалтгаалах бүхнийг хийж туслах нь миний хувьд мэргэжил, ёс суртахууны хэмжээнд хүлээсэн үүрэг гэж ухамсарлан зүтгэж явна.

Хил судлалын чиглэлээр мэргэжсэн эрдэмтэн П.Даш, Д.Нямдорж, А.Муратхан, Ц.Ганболд, П.Сүндэв, Д.Базарсад, П.Баттогтох, Д.Ганбаатар зэрэг олон эрдэмтэн судлаачид улсын хил хамгаалах шинжлэх ухааныг "хил шинжлэл"-ийн ухаан гэж тодорхойлон томъёолж байгаад сэтгэл ханалуун байна. Хил судлалыг улсын хилийн тухай шинжлэх ухаан гэж үздэг хил судлалын олон улсын салбарын ерөнхийлөгч В.А.Дмитриев бусад олон эрдэмтэд энэ санааг дэмжиж бидэнд тал бүрийн тусламж үзүүлж байгаа юм.

Дашрамд тэмдэглэхэд хил шинжлэлийн ухаан хэрэгжиж төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэхэд төр, нийгмийн нэрт зүтгэлтэн маршал Ю.Цэдэнбал, армийн генерал Б.Дорж, хурандаа генерал Б.Дэжид, Монгол улсын хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч, дэслэгч генерал Б.Цэдэн-Иш, Монгол улсын их хурлын гишүүн, засгийн газрын гишүүн, гавьяат хуульч, Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нар тодорхой хувь нэмэр оруулсан юм. Түүнчлэн Монгол улсын ерөнхийлөгч, ерөнхий сайд, улсын их хурлын гишүүд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн сайд, дарга, үе үеийн

хилийн цэргийн командлагчид, орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд болон эрдэмтэн судлаачид, иргэд төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд онцгой анхаарч иржээ. Монгол улсын ерөнхийлөгч, зэвсэгт хүчний командлагч Ц.Элбэгдорж Монгол улсын өмнөд хил хязгаараар явж Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцаж хилийн манаа, харуул, хилийн застав, отрядын хил хамгаалалтын бодит байдлыг биечлэн үзэж хонуут өнжүүтээр хилчдийнхээ дунд байж, бодол саналыг нь сонсож, зөвлөгөө сургамж хайрласан хэдэн жилийн өмнөх тэр үеийг дурсаж бахархаж явдаг.

Монгол улсын Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, НҮБ-д зөвлөх эрхтэй Мэдээлэлжүүлэлтийн олон улсын академийн жинхэнэ ба тэргүүлэгч гишүүн, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор, дэслэгч генерал Шавийн Арвай

ХИЛИЙН ТАГНУУЛЫН АЛБАНЫ ТҮҮХЭН ЗАМНАЛ



ХХЕГ-ын Хилийн тагнуулын алба байгуулагдсан түүхэн хөгжлийн 80 жилийн ойд

Хүн төрөлхтний түүхийг сөхөн үзэхэд өөрсдийгөө хамгаалах ухамсарт сэтгэхүй буй болсон тэр цагаас тагнуулын түүх эхэлж, төр буй болсноор түүнд үйлчлэх болжээ. Тиймээс сэтгэгч Иосиф Мелман "Тагнуул бол улс төрийн бодлогын үр хөврөл бөгөөд маш муу улс төрийн бодлого, үйл ажиллагааг ямарч сайн тагнуул аварч чадахгүй" хэмээн тагнуулын ажиллагаа нь төр, түүний бодлоготой холбоотой болохыг илэрхийлжээ.

1189-1919 онд Монгол улсын тагнуулын ажиллагааг хаан эзний шууд удирдлага захирамж дор цэрэг, захиргааны төв байгууллагууд эрхлэн гүйцэтгэж, төрийг мэдээллээр, төр иргэний аюулгүй байдал, цэрэг дайны ажиллагааг тагнуулын аргаар хангах, төрийн улс төр, цэргийн бодлого зорилгыг нууц аргаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн байна.

Монгол улсад 1922 оны 7-р сар хүртлэх хугацаанд улс төрийн тагнуулын ажил, үүргийг цэргийн тагнуул, хотын комендант, хязгаарын сайдууд, засгийн газрын төлөөний түшмэдээс тус тусын чиглэлээр эрхлэн гүйцэтгэж байжээ. 1922 онд улс төрийн тагнуулын байгууллага дотоодын хамгаалах газрыг /ДХГ/ байгуулж, түүнийг 1924 онд Засгийн газрын харъяа болгож, эрх үүргийг нь өргөтгөн бэхжүүлснээр ардчилсан төр ёст Монгол улсын тагнуулын төв байгууллага, хэлбэршлээ бүрэн олж тогтносон байна. ДХГ байгуулагдсанаас хойшхи хэдэн жилийн турш гол анхаарлаа Монгол оронд байсан гадаадын иргэд, байгууллагаас явуулж буй эдийн засгийн ноёрхол эзэгнэлийг багасгах, дайсагнасан үйл ажиллагааг илрүүлэх, хил хязгаараа хамгаалах зэрэг ажилд хандуулж байсан хэдий ч хөрш орнуудын байдал, тэдний тусгай албадаас манай орны эсрэг чиглүүлж буй үйл ажиллагааны тухай мэдээлэл олж авах явдал чухал байлаа. Энэ үндсэн дээр ДХГ-ын нууц явдлын хэлтсийн гадаадын иргэд, байгууллагын дунд сөрөх тагнуул явуулдаг тасгийг өргөтгөн тагнуул эрхлэх чиг үүрэг бүхий тагнуул, сөрөх тагнуулын "Гадаад хэлтэс"-ийг 1926 оны 6-р сард байгуулжээ. Энэ хэлтэс нь одоогийн ТЕГ-ын гадаад тагнуулын газрын эх үндэс болов. Улсын хилийг ил ба далд арга хослуулан хамгаалах нь улсын аюулгүй байдлыг хангах чадавхийг өндөршүүлэх нэгэн хөшүүрэг болохыг бүх цэргийн зөвлөл, ДХГ-аас анхаарч " баруун хязгаарыг сэргийлэх хэргийг дотоодыг хамгаалахад шилжүүлэх санал төлөвлөснийг МАХН-ын төв хорооны нарийн бичгийн дарга нар 1931 оны 12-р сард хэлэлцэж, үүнийг 1932 оны болон 1933 оны 1-р сараас

БНМАУ-ын өмнөөс баруун хязгаарын хүртлэх 6610 км нутаг \Дорнод аймгийн чиглэл ороогүй\ ДХГ хүлээн авч Ховд аймагт 2 комендатур, 8 заставтай отряд, Алтай Өмнөговьд тус бүр 6 заставтай комендатур, Дорноговьд 6 заставтай тусгай комендатур 863км Дорноговийн тусгай комендатур 352 км хил хамгаалж, заставуудын хооронд 50-200 км зайтай байжээ. Үүнтэй уялдуулан Увс, Хөвсгөл, Алтанбулаг, Хэнтий зэрэг аймаг дахь хязгаарын постыг татан буулгав. Гэвч Алтай, Өмнөговь, Дорноговийн аймгийн хойт баруун талаар тус бүр 400 км хил хамгаалалтгүй орхигджээ. 1930-аад оны дунд үеэс тус улсын гадаад байдал хурцдаснаас үүдэн хил хязгаарын хамгаалалтыг нэгэн байгууллагад төвлөрүүлэх шаардлага өсч 1937 оны 11-р сард Ардын сайд нарийн зөвлөлийн 25-р тогтоолоор Дорнод хязгаарын хамгаалалтыг ДЯЯ-нд хариуцуулжээ.

ДХГ-ын гадаад хэлтсийн дараа байгуулагдсан бас нэг чухал байгууллага бол Хязгаарын ба Дотоодын цэргийн хэрэг эрхлэх газрын тавдугаар хэлтэс байжээ. Тус хэлтэс нь ДХГ-ын даргын 1931 оны 11-р сарын 05 оны өдрийн 288 тоот тушаалаар байгуулагдсан түүхтэй. Уг хэлтэс нь хил хязгаарын хамгаалалтыг зохицуулах, контрбанд, хилийн зөрчилтэй тэмцэх, хилийн сумдын дотор сөрөх тагнуулын ажил явуулах ЗХУ, Тува хоёроос бусад зах нийлсэн улсын нутагт 100 км-ийн гүнд тагнуулын ажил эрхлэх үүрэгтэй байсан хилийн отряд комендатурт тагнуулын тасаг байгуулан түүгээрээ дамжуулан хилийн чанадад гүнзгий бус тагнуул, хил орчмын ард иргэдийн дотор сөрөх тагнуулын ажил зохион контрбандтайтэмцэх, тагнуул, туршуул, хил зөрчигдийг илрүүлэх зэрэг чухал үүрэг гүйцэтгэж байсан БНМУ-тай хил залгаа орших Өвөрмонгол, Барга шинжааны засаг захиргааны зохион байгуулалттай үйл ажиллагаа, хүн малын тоо хятад, японы бодлого, манай эсрэг явуулж байгаа үйл ажиллагааны арга хэлбэрийг судалж ажиллаж байв. Хилийн гадаад дотоод цагийн байдал хүнд үед хилийн отрядын тагнуулын тасгууд хилийн чанадад тагнуулын ажил явуулж хил орчмын байдлыг судлах, хилийн зөрчил, хилээр хууль бус зүйлсийг гаргагчдыг илрүүлэх, гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийн сүлжээ бий болгож идэвхтэй ажиллаж байсан. 1940-1950 онуудад баруун хязгаарт хилийн тагнуулын 5-р хэлтэс идэвхтэй ажиллаж байсан. Хилийн нөхцөл байдал тайван болж 1950 онд татан буулгасан. 1967 онд хилийн цэрэг шинээр дахиж байгуулагдахад удирдах газарт гүйцэтгэх хэлтэс, отрядод тасгууд бий болсон. 1980 онд 6-р сарын 15 нд НАХЯ-ны сайдын 410 тоот тушаалаар 5-р хэлтэс дахиж байгуулагдан доорхи үүргийг гүйцэтгэж байсан.

1. Хятадын нутагт болон улсын хилийн орчимд туслагч буй болгон сүлжээ зохион байгуулах

2. Манай орны нутагт зэвсэглэн халдах, бусад төрлийн өдөөн хатгалга хийж буй шинж тэмдэг, зорилго хүч хэрэгслэлийг тодорхойлох

3. Манай хилийг зөрчин явуулж буй дайсагнасан ажиллагаа, түүнийг явуулдаг байгууллага, тагнуулчид, тэдгээрийг нэвтрүүлдэг газар, орчмыг илрүүлэн боловсруулах.

4. Хятадын хил хамгаалалт, хил орчмын цэргийн бүрэлдэхүүн, орон нутгийн оршин суугчдын талаар болон улс төр, эдийн засаг, гүйцэтгэх ажлын нөхцөл байдлын тухай мэдээ олох.

5. Хил зөрчих аливаа оролдлого, хил давуулан тогтоосон тагнуулын харилцаа холбоо, манай орны эсрэг явуулж буй, болон болзошгүй хорлон сүйтгэх ажиллагаа, түүх соёлын үнэт дурсгалт зүйлсийг хил давуулан гаргах оролдлого зэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох.

6. Гүйцэтгэх ажил, хил хамгаалалтыг зохион байгуулахад шаардагдах оператив цагийн байдлын тухай мэдээ олж нэгтгэх, дүн шинжилгээ хийх.

7. Улсын хил ба хилийн дэглэм зөрчигдийг магадлан шалгах

8. Хилийн зөрчил дээр хэрэг бүртгэлт явуулах

9. Гадаад тагнуулын арга хэмжээ зохиоход дэмжлэг үзүүлэх гэж үүрэгт заажээ. Тухай үед НАХЯ-ны УАХЕГ, Хилийн ба ДЦУЕГ-т зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж байв. Хилийн тагнуулын хэлтэст А.Г Умнов, В.В. Лежнев нар зөвлөхөөр ажиллаж байв. Тэд хилийн тагнуулын ажлын талаар асар их туршлагатай хүмүүс байсан. 1984-1985 онд хятадууд хилийн төлөөлөгчдийн уулзалтаа ихэсгэж, өөрийн тусгай албадаа эмхлэн хүчээ нэгтгэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах техник хэрэгслийн нөхцлөө эрс өөрчлөн сайжруулж байв. Тэд хилийн уулзалтад оролцогчдод тусгай дамжаагаар давтан бэлтгэх, орчуулагчдаа крилл үсэгт суралцуулах, уулзалтанд монгол, казах, орос хэл мэддэг хүмүүсийг оролцуулж байлаа. Энэ бүхэн нь манай эсрэг хийх судалгаа, мэдээ олох ажлаа өргөжүүлж байгааг харуулсаар байлаа.

1988 оны 5-р сарын 16нд НАХЯ-ны Хилийн ба ДЦУЕГ-ын даргын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах ажлыг сайжруулах тухай 01 тоот албан даалгавар гарчээ. Уг албан даалгаварт отрядын дарга, тагнуулын дарга нарт дараах зүйлийг даалгасан байна. Үүнд:

-НАХЯ-ын сайдын 01 тоот тушаал, хилийн цэргийн тагнуулын дүрэм, зааврын заалтыг дахин нарийн судлаж үйл ажиллагаандаа байнга удирдлага болгож ажиллах.

-Хятадын гадаад, дотоод улс төрийн бодлого, цэрэг, хил хамгаалалтын систем, эсрэг талын хүн ба орон судалгаа, хятадын тусгай албадын үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл олохын тулд хятадын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, хилийн уулзалт, хил зөрчигч, хилээр зохиосон арга хэмжээнүүд, харилцан ажиллагаатай байгууллага зэрэг боломжтой бүх сувгуудаас мэдээ цуглуулах, дүгнэлт судалгаа хийх ажлыг боловсронгуй болгох.

-Туслагчтай ажилладаг одоогийн аргаа өөрчилж, уулзалтын нууцлалыг хатуу чанд сахин, найдвартүй этгээдүүдийн талаар авагдсан сэжигтэй дохио болон бусад чухал мэдээллийн мөрөөр шуурхай ажил зохиож Хятадын тусгай албаны суурин туршуул, тэдэнд тусалж болох баазыг зөв тогтооход ажлаа чиглүүлэн ажиллах.

-Хилийн зөрчлийн шинж тэмдгийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажилд итгэмжилсэн хүмүүс, орон нутгийн оршин суугчдын хүчийг хилийн цэрэгт туслах гишүүний

халхавчаар ашиглаж штабтай хамтран хил хамгаалалтыг зохион байгуулах.

- Хилийн цагийн байдал идэвхжсэн чиглэлүүдэд гүйцэтгэх ажилтнуудаас томилон ажиллуулж, зарим шаардлагатай цэргийн хяналтын мэдээг тагнуулын шугамаар шалгаж дүн шинжилгээ хийсний эцэст төвд үнэн зөв мэдээлэл явуулдаг журмыг хэвшил болгох.

-Гүйцэтгэх ажлын нууцлалыг чанд сахиж, улсын нууц задруулах сэжиг бүхий илрэлийн мөрөөр шуурхай арга хэмжээ авч ажиллах.

-Тасгийн тагнуулын ажил хариуцсан төлөөлөгч нарыг хилийн застав, постонд чиглүүлэн ажиллаж, хилийн манааны хяналтаар илэрсэн мэдээг шалгах, гүйцэтгэх ажилтны хяналт зохиох, хил дээр зохиох тагнуулын боломжийг урьдчилан судлах, хяналт зохиох талаар хилчдэд мэргэжлийн хичээл заах зэрэг ажлыг хийх.

-Сөрөх тагнуулын ажил хариуцсан төлөөлөгч нарыг хилийн бүсэд оршин суугчид сум, орон нутгийн байгууллага, хэсгийн төлөөлөгч, бусад гүйцэтгэх албадтай нягт харилцан ажиллагаатайгаар улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах ажилд тогтвортой чиглүүлж уналга бусад нөхцөл бололцоогоор хангаж ажиллах

-Отряд тус бүрт дотоод бололцоогоо ашиглан хил зөрчигчийг байрлуулах байрыг хууль зүйн болон нууцлалын шаардлагыг хангахуйцаар төхөөрөмжлөн байгуулах гэх мэт асуудлуудыг тусгасан байна.

Хилийн тагнуулын хэлтэс 1980-1990 он хүртэл зохион байгуулалтын хувьд бэхжиж, олон боловсон хүчинг ЗХУ-д тагнуулын дээд сургуульд явуулж, заримыг нь дотооддоо тодорхой хугацаагаар давтан бэлтгэж ажилтнууд нь мэргэшиж , ажилд нь тодорхой үр дүн гарсан он жилүүд байлаа. Монгол улсад болсон өөрчлөлт, шинэчлэлийн явцад НАХЯ тарж 1990 оны 4-р сард Хилийн цэргийн тагнуулын хэлтсийг татан буулгаж, түүний гүйцэтгэж байсан зарим үүргийг УАБХЕГ-ын цэргийн тусгай хэлтэст шилжүүлсэн явдал нь нэг талыг хэт барьсан, туйлширсан, хилийн тагнуулын онцлогийг ойлгоогүй алдаатай шийдвэр болсон юм. Монгол улс 1990 оны эхээр зэх зээлд шууд шилжин орж улс төр, эдийн засгийн нөхцөл байдал нь тогтворгүй болов. НАХЯ, Ардын хянан шалгах хороо зэрэг хүчтэй хяналтын байгууллагуудыг тараав.

Энэ үед улсын хил хамгаалалт ч гэсэн зарим талаар суларсан байна. Улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах ажил ор нэр төдий болжээ. Улсын хилийг зөрчих, эд зүйлс, тэсэрч дэлбэрэх бодис, буу зэвсэг, хууль бусаар оруулах гаргах ажиллагаа ихсэв. Спирт, ноолуур, машины хууль бус наймаа газар авсан байна. Энэ ажилд зохион байгуулалттай бүлэг хүмүүс оролцох болов. Эрүүгийн элементүүд улсын хилээр хууль бусаар нэвтэрч гадаадад оргон гарах явдал нэг бус удаа гарч байв. Хятад, Оросын хилийн тагнуулын байгууллага Монгол улсад бий болсон нөхцөл байдлыг ашиглан тагнуулын үйл ажиллагаагулам идэвхжүүлэв. Ийм нөхцөл байдлын улмаас улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах ажлыг эрс сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдсан байна. Энэ ажлыг хийх

мэргэшсэн тагнуулын байгууллагыг дахин байгуулах асуудлыг Хил Хамгаалах Ерөнхий Газрын удирдлага 2000 онд төр, засгийн удирдлагад танилцуулж шийдвэрлүүлжээ.

Монгол улсын УИХ 2001 оны 12 дугаар сарын 27-нд зарим хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан "Хил хамгаалах байгууллагын бүрэн эрх"-д хилийн зөрчил түүнтэй холбогдсон асуудлыг шуурхай шалган шийдвэрлэх, улсын хил хамгаалалтын эрх ашигт хамааралтай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил зөрчигчийг эрж олох зорилгоор гүйцэтгэх ажил явуулахзэрэгнэмэлторуулан баталжээ. 2002 онд хуулийн дээрх заалтуудыг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын тогтоол гарч, Хууль зүй дотоод хэргийн сайдын ХХЕГ-ын бүтцийг баталсан 2002 оны 11-р сарын 13 ны өдрийн 262-р тушаалаар Хилийн тагнуулын алба дахин байгуулагдав. Хилийн тагнуулын алба нь эрхэм зорилгоо тодорхойлж, улсын хил хамгаалах шинэ үзэл баримтлалын дагуу өөрийн дүрэм зааврaа батлуулан ажиллаж байна. 2007 онд хилийн тагнуулын албыг өргөтгөж газар болон дотроо чиглэл хариуцсан 3 хэлтэстэй, отряд бүрт тагнуулын тасаг ажиллаж байна. Хилийн тагнуулын газар нь доорхи 3 нийтлэг үндсэн зарчмыг баримталдаг.

1. Хилийн тагнуулын алба нь Монгол Улсын төр засгийн болон Хил хамгаалах байгууллагын дээд удирдлагыг хил орчмын нөхцөл байдлын талаарх тагнуулын мэдээллээр хангах, улсын хилийг тагнуулын аргаар хамгаалах, хилийн зөрчилтэй тагнуулын арга, хэрэгслээр тэмцэх үндсэн чиг үүрэг гүйцэтгэнэ.

2. Үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Хилийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, Хил хамгаалах ерөнхий газрын даргын тушаал, заавар, дүрмийг мөрдлөг болгоно.

3. Хилийн тагнуулын алба нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, үндэсний ашиг сонирхол , эв нэгдлийг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх , нууцлалыг чандлан сахих, шуурхай, тасралтгүй байх, нэгдмэл төвлөрсөн удирдлага, ил болон далд арга, хэрэгслийг хослуулах, байгууллага, иргэдийн туслалцаа дэмжлэгт тулгуурлах зэрэг тагнуулын үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлана. Хилийн тагнуулын газар нь үйл ажиллагаандаа доорх үндсэн чиг үүргийг гүйцэтгэнэ.

1. Хилийн тагнуулын алба нь улсын хил хамгаалалтын эрх ашигт хамааралтай мэдээ, мэдээлэл олох, судалгаа, дүн шинжилгээ хийх, улсын хилийг тагнуулын аргаар хамгаалах, хилийн зөрчилтэй тагнуулын арга, хэрэгслээр тэмцэх зорилгоор тагнуулын ажил явуулах.

2. Улсын хилийн бүс, зурваст үүсч болзошгүй зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, зэвсэгт халдлага болон бусад төрлийн өдөөн хатгалга бэлтгэж буй шинж тэмдэг, зорилго, хүч хэрэгслийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, хил хамгаалалтыг

зохион байгуулахад ач холбогдол бүхий мэдээ, мэдээллээр хил хамгаалах байгууллагын удирдлагыг хангах

3. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг тагнуулын аргаар хамгааалах зорилгоор хилийн тагнуулын албаны өмнө тавигдсан үүргийг биелүүлж чадахуйц тагнуулын мэдээллийн найдвартай эх сурвалжийн сүлжээг бий болгож, удирдах

4. Тагнуулын аргаар улсын хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, магадлан шалгах, зөрчилд холбогдогчийг олж тогтоох

5. Хөрш зэргэлдээ орноос хилийн талаар баримталж буй, бодлого, хил хамгаалалт, хил орчмын цэргийн анги салбарын байршил, тэдгээрийн зориулалт, шилжилт хөдөлгөөн, цэргийн арга хэмжээ, засаг захиргаа болон хүчний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, газар орон, оршин суугчдын талаар болон улс төр, нийгэм, эдийн засаг, тагнуулын ажлын нөхцөл байдлын тухай мэдээ мэдээлэл олж, дүн шинжилгээ хийх, энэ төрлийн мэдээ,мэдээллийг хил хамгаалах байгууллагын дээд удирдлагад танилцуулах

6. Хилийн бүс, хил орчмын сумдын нутаг дэвсгэрт хилийн эрлийг зохион байгуулахад хил хамгаалах байгууллага, түүний харъяа анги, салбарын удирдлагыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, тагнуулын ажлын хүч, хэрэгслийг зохицуулан ашиглах

7. Тагнуулын судалгааны материал бий болгох, мэдээллийн сан бүрдүүлж ашиглах

8. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу хилийн бүст гарсан гэмт хэрэгт хойшлуулшгүй ажиллагаа явуулах.

1931-1950 онуудад Хилийн 5-р хэлтсийн даргаар ажиллаж байсан хүмүүсийн нэрс:

* Баярын Жадамба /1895-1956/
* Цэрэнгийн Гиваапил / 1906-1937/
* Дэлгэрийн Данзан / 1911-1990/
* Хуягийн Цэрэндорж / 1919-1984/
* Дамбын Цэрэнбалжир /1917-2006/

1980-1990 онд хилийн 5-р хэлтсийн даргаар ажиллаж байсан дарга нарыг дурдвал

* Наранноровын Дорждэрэм /1980-1982/
* Хумбын Загдрагчаа /1982-1985/
* Батсүхий Батмөнх / 1985-1988/
* Төгөлдөрийн Бадамханд /1988-1990/

2002онд Хилийн тагнуулын алба дахин байгуулагдахад даргаар нь Төгөлдөрийн Бадамханд /2002-2009/ онд томилогдон ажиллаж байв. Одоо хурандаа Гонгорын Цогмандал ажиллаж байна. Хилийн тагнуулын албаны түүхэн үйл явдлыг тоймлон уншигч та бүхэнд хүргэхийг хичээснийг минь тунгаан болгооно уу?

Далд фронтын баатарлаг үйлстэн ахмад чекистүүд та бүхний алдар гавьяа мөнхөд оршиг.

"ЁСТОЙ ХҮНИЙ ТУХАЙ" НАЙРУУЛАЛ

(ОРЧИН ҮЕИЙН ДИПЛОМАТ АЛБА БАЙГУУЛАГДСАНЫ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН УРАН БҮТЭЭЛИЙН УРАЛДААНЫ НАЙРУУЛЛЫН ТӨРӨЛД ТЭРГҮҮН БАЙР ЭЗЭЛСЭН БҮТЭЭЛ)

Доктор профессор,хурандаа Ц.Ганболд



С.Аварзэд /1958 он/

Биднийүеийнхэн ЗХУ-ынзохиолчБорис Полевойн "Ёстой хүний тухай тууж,, зохиолыг амтархан уншиж бахархаж түүгээр хүмүүжсэн гэхэд болно. "Ёстой хүнийг" гадаадаас,гаднаас, холоос хайх биш бидний дэргэд даруухнаас даруухнаар амьдарсаар байсныг хожуу мэдэхэд нэг л гуниг төрөх юм.

Зээлдмэл нэртэй энэ найрууллын маань баатар бол Говь-Алтай аймгийн Цогтсумынунаганхүү1953-1958онуудад БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн орлогч дарга, ГЯЯ-ын сайдын өндөр албан тушаал хашиж, нэгдлийн дарга, багш, хуульч, жолооч зэрэг өргөн мэргэжлийн ажил эрхэлж байсан, Т.Галсан гуайн хошигнодог шиг "Тэмээ хариулж байсан болохооос тэмээ болоогүй", "Туг ч барьж үзсэн тугал ч хариулж үзсэн, Содномын Аварзэд агсан бөлгөө.

1960,70,80-аад онуудад тэр үеийн Говь-Алтай аймгийн Цогт сумын "Давшилт" нэгдэл гадаад, дотоодын олон дээд сургуулийг төгссөн, гадаад хэл болон мэргэжлийн өндөр боловсролтой, нам төр засгийн удирдлагад, өндөр алба хашиж байсан сум-нэгдлийн дарга нартайгаараа, (Содномын Аварзэд-Сайд нарын зөвлөлийн орлогч дарга, ГЯЯ-нь сайд асан, Батын Дашзэвэг–ЗХУ-д Комсомолын болон Коммунист намын дээд сургууль төгссөн, МХЗЭ-ийн Төв хорооны 1¬-р нарийн бичгийн дарга асан) анхны саятан дөрвөн нэгдлийн нэг байснаараа алдартайсан....

Миний эцэг М.Цагаан 1960¬¬-1980-аад онд тус нэгдэлд ерөнхий нягтлан бодогчоор тасралтгүй ажиллахдаа энэ эрхэм хүмүүс, томчуудтай гар, сэтгэл, зүтгэл нийлэн ажиллаж, хамтран төрд зүтгэж байсны хувьд ч, эр хүн, хүн ёсны хувьд ч өнө удаан жил нөхөрлөсөндөө... Бид ч гэсэн хэдэн хүүхдүүд нь хэдэн буугаар нь ээлжлэн тоглож, гэр гэрийнхээ боов боорцгийг нь багагүй хороодог байсан.

Аав минь бидэнд "Боловсролтой, мэдлэгтэй, амьдралын хат суусан хүмүүстэй хамтран ажиллахад их түшигтэй байдаг. Цогтын ард түмэн том хүмүүсээр удирдуулах амны хишигтэй улс" гээд С.Аварзэд гуай бол энэ нутгийн хүн Оросын элчин Молотовтой хил тогтоох асуудал, газар нутгийн маргаанаас болж, Б.Дашзэвэг гуай бол урд Чандмань сумын Ц.Лоохууз гэдэг хүнд хүүхдээ үрчлүүлсний улмаас эсэргүүний хамсаатан хэмээн албан тушаалаасаа бууж ирсэн юм.

"Албан тушаал мөнх биш амьдрал, нэр хүнд мөнх юм шүү.

Ийм хүмүүсийг энэ алтан нутаг руу цөлж хашраана гэж юу байх вэ?,, гэж сургадаг байж билээ. Тэр үед балчир ой ухаан минь энэ хүний талаар ийм л санамжтай байлаа.

С.Аварзэд гуайн амьдрал, алба, ажил үйлсийн талаар Г.Аким, Нинж Лхагва, Ц.Хасбаатар, Г.Донид, П.Батнайрамдал, Ц.Навагчамба, Х.Баттулга гээд л манай нэртэй сэтгүүлчид томоохон өгүүлэл найруулуудыг биччихсэн болохоор "над мэтэд юу л үлдээв гэж" өөрийгөө чамлах боловч хар багаасаа айл хөрш явж хүүхдүүдтэй нь тоглож өссөн, мөн тэр хүний маргалдан тэмцэж авч үлдсэн алтан нутаг, хил хязгаарыг хамгаалж, Монгол Улсын хилийн болон хил хамгаалалтын түүхийг өөрийн хэмжээнд судалж, үр шимээр нь амьдарч яваагийн хувьд энэ хүний талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, үгээ хэлэх нь Алтай нутгийн алтан нутгийн хүүгийн хувьд ч, аавын минь найзын хувьд ч, өндөр гавьяаг нь хүндэлдгийн хувьд ч, үүрэг, үйлс гэж үзэн өөрийгөө голж зүрхшээн байвч зориглон бичиж буй минь энэ бөлгөө.

С.Аварзэд агсны хувийн ажил, алба, амьдрал төдийгүй түүний гэр бүл, үр хүүхдүүдийнх нь хувь заяанд ихээхэн нөлөөлсөн Монгол-Зөвлөлтийн Туватай хиллэдэг хэсгийн хил тогтоох хэлэлцээр, үйл ажиллагааг тодорхой харуулахын тулд Монгол-Тува, Монгол-Зөвлөлтийн хилийн түүх, үүсэл, хөгжил, харилцааны талаар ойлголт өгөх нь зөв болов уу?

1957 оны хэлэлцээрийн өмнө өрнөж байсан түүхэн үйл явдлуудыг тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал, хил залгаа Орос улстай харьцаж байсан харилцаа, тухайлсан хэсгийн улсын хилийн үүсэл, түүх, хөгжил гээд түүхийн тодорхой орон зайд, гурван цагийн хэлхээнд авч үзэх нь тухайн найруулын гол санааг гаргах, С.Аварзэд агсны мөнхүү мөн чанарыг тодруулахад тус болох нь дамжиггүй юм.

Хилийн түүхээс хураангуйлан өгүүлэх нь: Монгол-Тува, Монгол-Зөвлөлтийн харилцааны түүхэнд хилийн болон газар нутгийн асуудал онцгой байр суурь эзэлдэг.

Тувачууд 16-р зууны үед Тагнын уулсаар нутаглаж байхыг Манжийн хаан заан тогтоож өгснөөс хойш тэнд аж төрөх болсон. Тэр үеэс хойш Монгол, Тува хоёр зэргэлдээ аж төрөн Арван баядын хүрээ хийдэд Тувагаас хүмүүс шавилан сууж лам хуврагын сургууль дүүргэж нутагтаа буцдаг төдийгүй, Баядын овоо тахилгад оролцдог байсан түүхтэй. Тэр үед Арван баядын буюу одоогийн Тэс, Зүүнговь, Малчин сумдаас Тагна уулыг давж бэлчээр хөөж нүүн Енисей мөрний хөвөө эрэг хүрч байв.

1689,1727,1864 онд Манж Чин улс-Хаант Оросын хооронд Хилийн гэрээ байгуулагдаж хилийн шугамыг газар дээр нь тогтоон тэмдэглэх үед уг ажил тухайн үеийн байдлаас үүдэн шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоогдоогүй, хоёр овооны хооронд хилийн байршил нь тодорхой бус, хилийн овоонууд нь хоорондоо 10-70 км, дунджаар 40км зайтай байсан ба газар орны хувьд зохистой оновчтой байдалд тохируулж чадаагүй, хилийн гэрээ, протоколд овоо тэмдэгт босгосон газрыг янз бүрээр нэрлэж, нэр өгч байснаас биш хилийн шугамын байршил, зүг чигийг газар дээр нь болон протоколд тодорхойлоогүй байна.

1911 онд Монгол улс Манжийн дарлалаас чөлөөлөгдөх үед Тува, Монголын хилийн заагийг нарийсган Тагна уулын бэлээр байсан хилийн хайч замыг дахин тодотгож, чулуугаар овоо босгон хуучны бичигтэй пайз хатгасан байсан нь 1940-өөд он хүртэл байжээ. Тагна уулын бэлийн орчим байх Алаг уулын араар замын Монгол талд нь Чулуун овоо дээр худам монгол бичгээр "Бадаргуулт төр хааны

нутаг" гэж бичсэн байв. Түүнээс зүүн хойш Тагна уулнаас эх авсан Арсанаг, Шивээлэг хэмээх хоёр голын дунд овоолсон чулуун дээр пайз хатгасан агаад түүн дээр "Бадаргуулт төр хааны нутаг Хүн тахын албат Монгол улс" гэсэн бичиг байжээ.

Олон зуун жил нэгэн улсын бүрэлдэхүүнд хамт байж, хүн ард нь айл хөрш аж төрөн, нүүдлийн мал аж ахуй эрхлэж байсан тус Монгол, Тувагийн хооронд хилийн тодорхой шугам, тогтсон хатуу зааг байсангүй. Хоёр орон биеэ даан тусгаар тогтнолын замд орж хил хязгаараа зааглан тогтоох үед эл байдал нилээд асуудал , бэрхшээл үүсгэсэн юм.

1926 оны 8-р сарын 16-нд БНМАУ, БНТАУ-ын хооронд Улаанбаатар хотноо байгуулсан найрамдлын гэрээ бичгийн 6-р зүйлд "Монгол, Тагна Тува хоёрын нутгийн зах, хил хязгаарын газрыг хоёр этгээдийн засгийн газраас зөвлөн хэлэлцэж тусгай комисс гарган нутгийн зураг, цэсийг баримталж шинэчлэн тогтооно" хэмээн заасны дагуу 1923 оны 10-р сард Монгол Улсын Засгийн газар, МАХН-ын Төв хорооноос БНМАУ, БНТУ-ын хил хязгаарыг шинэчлэн тогтоох, хилийн асуудлыг цэгцлэх Төв комисс томилсон байна.

Хил тогтоох асуудал нарийн төвөгтэй асуудал тул хоёр тал нэлээд бэлтгэл хийсний эцэст 1930 оноос хил тогтоох хэлэлцээ хийж эхэлсэн байна. 1930 оны 3-р сарын 16-нд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б.Элдэв-Очир, Ө.Бадрах ТАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга С.Тока нар хилийн комисс байгуулах тухай протоколд гарын үсэг зуржээ.

Уг протоколын хил тогтоох зарчмыг тодорхойлсон 3-р зүйлд "Манай хоёр орон ардын хувьсгалт намын удирдлагаар социализм байгуулж буй тул хилийн асуудлыг шашин-үндэсний заншил, хуучин манжийн хилийн зарчмаар биш, харин ард олон, тэдний аж ахуйг соёлтой хөгжүүлэх зарчим баримталбал зохистой" гэжээ. 1930 оны 3-р сарын 16-ны өдөр хоёр улсын ардын хувьсгалт намын нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөнөөр доорхи үндсэн саналуудыг тодорхойлжээ.

Үүнд: Монгол, Тува хоёр улсын комиссуудаас 1930 онд мэдэгдсэн хил хязгаарын тухай сүүлчийн саналуудыг зааг шугамыг баримталж тэмдэг бүхий дэвсгэр газрын нэгэн тэмдгээр хуваж, түүний хойт талыг Тувагийн нутаг дэвсгэрт оруулах, Тагна Тува Ард улсын давсны асуудлыг хангадаг давсны ганц газар болох Давст уулыг Тувагийн нутаг дэвсгэрт оруулах боловч Монгол Ард улсын хил хязгаарийн дэргэдэх ард олон мөнхүү уулаас давсыг үнэ төлбөргүй хэрэглэх.

1. Увс нууруас зүүн этгээдэд буй дөрвөлжин хэсэг газрыг хойд ба өмнө хоёр тийш хуваж, Ахир уулын баруун өмнө өврөөр элсийг дайруулан Нисэх уулын орой хүртэл татаж, энэхүү дөрвөлжин хэсэг газрын хойд талыг Тагна Тува Ард улсын нутаг дэвсгэрт оролцуулж, өмнө талыг Монгол Ард Улсын нутаг дэвсгэрт оруулах.

2. Аль нэг газруудын тухай хоёр улсын комиссын хэсгүүдийн хооронд зөрөлдөөн гарвал комисс мөн газарт хүрэлцэн ирж, зөрөлдөөнтэй газрын байдлыг шинэчлэн үзэн таслан шийдвэрлэх.

3. Хилийг тогтоохдоо 1930 онд БНМАУ-ын ШУХ-гээс тогтоосон хил хязгаарын дэргэдэх газруудын тухай Шагжийн зургийг баримтлан гүйцэтгэх. Хил тогтоосон тогтоол бичигт хоёр улсын хооронд тогтоосон хилийн өгүүллийг сайтар тодорхойлох.

4. Хил тогтоосон тухай тогтоолыг хоёр улсын засгийн газраас баталсны дараа хүчин төгөлдөр болно. Хил хязгаарын овоо тэмдгүүдийг мөн хилийн тухай комиссын тогтоолыг хоёр улсын засгийн газраас баталсны дараа босгож тэмдэглэх.

5. Хил хязгаарын ойролцоо оршин

суудаг ард олныг малын бэлчээр, ус, ой мод, ангаар хэрхэн хангах тухай асуудлыг хоёр улсын хооронд хилийг тогтоож дуусcаны дараа хоёр улсын хооронд тусгай хэлэлцээ байгуулж гүйцэтгэнэ гэжээ

Үүний дараа хоёр орны засгийн газраас томилогдсон хамтарсан комисс шинээр хил тогтоох асуудлаар 2 жил гаруй хэлэлцсэн боловч тохиролцоонд хүрч чадаагүй. Хэлэлцээн дээр Монголын тал хуучин хилийн шугамаар буюу Тагны нуруугаар, Тувагийн төлөөлөгчид дээр дурдсан протоколын дагуу Монголын хилийн харуул байрлаж байсан газраар шинээр хил тогтоох санал тавьсан тул хоёр тал мухардалд орсон юм. Тувагийн тал 1931 оны эцсээр Монголд суугаа элчин төлөөлөгчөөр дамжуулан хилийн хэлэлцээг үргэлжлүүлэх санал тавьжээ.

Монголын ГЯЯ-ны сайд Х.Чойбалсан 1932 оны 2-р сард Засгийн газарт ирүүлсэн албан захиандаа: "Монгол улс өнгөрсөн жил Тува улстай хил нийлэх хязгаар нутгийн бүдлиантай асуудлыг найрамдалт ёсоор тогтоох 2 улсын засгийн тусгай комиссыг уул хэргийг эрхлэх үед шийдвэрлэсэн санал, холбогдох зураг, түүхэн баримтыг гарган шийдвэрлүүлэхээр Тувагийн засгийн газрын комисст танилцуулсан боловч Тувагийн засгийн газар манай комиссын саналыг үл зөвшөөрөн татгалзсан юм. Мөн Тувагийн ГЯЯ-ны сайдад захидал илгээсэн боловч хариу өгсөнгүй. Иймд хоёр улсын ашиг тусын тулд хилийг шинэчлэн тогтоож, тасалбар болгохыг хүсэж байна. Тувагийн Засгийн газрыг дахин тогтоолгох саналыг ёсоор болгож, Тувагаас хилийн асуудлаарх хамт шийдвэрлэх тусгай заавар боловсруулан орох зардлыг хамтран тогтоож батлах нь зүйтэй" гэжээ. Үүнээс удалгүй 3-р сард Монголын Засгийн газраас Монгол, Тувагийн хилийн хэргийг цэгцлэн гүйцэтгүүлэх комисс байгуулан, түүний бүрэлдэхүүнд нөхөр Ламжав, Цэенрэгзэн, Машгарав, мөн 4 аймгийн даргыг тус тус оруулжээ.

Харин 1932 оны 7-р сарын эхээр П.Гэндэн Ерөнхий сайд болсныхоо дараа Тувагийн саналын дагуу БНМАУ, БНТАУ-ын хооронд хилийн протоколд гарын үсэг зуржээ. Ингэснээр Монгол-Тувагийн хил Тагнын нуруугаар биш, харин түүнээс 10-40 км дотогшлон, манай улс хилийн зааг нутгаа алдсан ажээ.

1932 оны хилийн протоколыг БНМАУ-ын Улсын бага хурал "ард түмний эрх ашигт үл нийцсэн" хэмээн үзэж батлаагүй. 1934 онд Монгол, Тувагийн Засгийн газрууд дахин хилийн асуудлаарх хэлэлцээгээ сэргээв. БНМАУ-аас БНТАУ-д суугаа төлөөлөгч Гомбожав, Тувагийн ерөнхий сайд Жүрмэддаш хоёр улсын засгийн газраас томилогдсон тусгай комисс харилцан ярилцаж, 3 зүйлийн гэрээ бичиг байгуулахаар тогтов хэмээн мэдэгдсэн тухай албан захидал ирүүлжээ. Үүнд:

1.Хоёр улсын хил хязгаарын орчмоор нутаглан суугаа ардуудын аж төрөх явдлыг хялбар дөхөм болгох.

2. Хил хязгаар болох Цагаан толгой хэмээх газраас эхлэн Мөнхсарьдаг хэмээх газар хүртэл хил тогтоох асуудлыг хэлэлцэж дуусгах.

3. Хил орчим ардуудын малыг санамсаргүй алдах, залт этгээд хулгайлан авсан тохиолдолд харилцан нэвтрүүлэх, хил орчмын ардуудын асуудлыг шийдвэртэй хамгаалах тухай гурван зүйлийн гэрээ бичгийг харилцан тохиролцсоноо мэдэгдсэн болно гэжээ. Гэвч энэ удаагийн хэлэлцээ дахин олигтой үр дүнд хүрээгүй бөгөөд хилийг шинэчлэн тогтоох асуудал нэлээд саад бэрхшээлтэй тулгарчээ. Тухайлбал: Тувад сууж байсан манай элчин төлөөлөгчөөс 1935 оны 06-р сард ирүүлсэн нэгэн захидалд, хил

хязгаарын овоо тэмдгийг шинэчлэн тогтоох үед Увс аймгийн Сагил, Бөхмөрөн зэрэг хэдэн сумын 800 гаруй өрх ардууд нутаг бэлчээрээр гачигдаж байгаагаас гадна ард олны санаа сэтгэл тогтворгүй болох байдал ажиглагдсан ба эдгээр ардууд гадаадын нутагт оршин суухад хүрэх тул энэ удаа хилийн овоо тэмдгийг босгох ажлыг түр азнаж, хоёр улсын ардууд эртнээс нутаглан идээшилж ирсэн газар нутгийн асуудлыг нааштайгаар хэлэлцэн хил хязгаарыг тогтоох ажлыг зүй зохистой гүйцэтгэвэл зохино гэж дурьдсан байна.

1940 оны 5-р сард Улаанбаатар хотноо БНМАУ-ын Засгийн газрын ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд маршал Х.Чойбалсан, БНТАУ-аас БНМАУ-д суугаа бүрэн эрх барих төлөөлөгч нөхөр Намсрайтай хилийн асуудлаар 4 дэх хэлэлцээ явуулах талаар дараах зүйлүүдийг хэлэлцэн тохиролцжээ.Үүнд:

1.БНМАУ ба БНТАУ хоёрын зааг нийлсэн хилийн шугамыг үнэн зөвөөр тогтоохын тулд энэ 1940 онд хоёр улсын засгийн газраас тусгай комиссыг гаргаж гүйцэтгүүлсэн.

2.Монгол Ард Улс ба Тува Ард Улсын хилийн шугамыг тодорхойлохдоо баримтлах зүйлүүд:

а/ Монгол, Тува хоёр улсын хилийн шугамын тухай хуучин түүхт материалыг гарын авлага болгон хэрэглэх.

б/ 1932 онд хоёр улсын засгийн газраас хилийг тогтоохоор томилогдсон комиссуудын материалыг яг баримтлахгүй бөгөөд тэрхүү материалыг хилийн шугамыг тодотгох ажилд ашиглах болно.

Энэ удаагийн хэлэлцээний зарчмууд нэлээд түүхэн уламжлал, бодит байдалд ойртсон байлаа. Монголын хилийн комиссын дарга Янжмаа 1940 оны 8-р сарын 11-ны өдөр хэлэлцээ явагдах Хандгайтад хүрэлцэн очиж Тувагийн Засгийн Газрын комиссын дарга Бадраатай хоёр засгийн газраас олгосон итгэмжлэх бичгийг солилцон, 12-ны өдөр анхдугаар хамтарсан хурлыг зарлан хуралдуулжээ. Энэ удаагийн хэлэлцээгээр газар орны байдлыг газар дээр нь танилцан зарим үед түүхэн материалыг тулгаж үзэн, нэлээд хэмжээний газарт санал нийлж байсан бөгөөд зарим санал зөрөлдөөнтэй газрын асуудлыг сайтар нягтлан судалсны үндсэн дээр дахин хэлэлцэхээр тохиролцжээ.

1940 оны хилийн хэлэлцээ эцсийн үр дүнд хүрч чадаагүй бөгөөд 1944 оны 10 сард Тува ЗХУ-д нэгдсэнээр хилийн асуудал Монгол-Зөвлөлтийн хоорондын асуудал болсон билээ. Энэ үед ЗХУ-ын хилийн цэрэг Автономит мужийн хэсэг дэх Монгол-Зөвлөлтийн хилийг 1932 оны Монгол-Тувагийн хилийн комиссын тодорхойлсон шугамын дагуу хамгаалалтандаа авчээ.

Монгол-Тагна Тувагийн хооронд 1926-1944 он хүртэл 18 жилийн дотор хилийн асуудлыг 4 удаа авч хэлэлцсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй юм.

1957 оны эцсээр Монгол-Зөвлөлтийн хэлэлцээр эхлэх үед МАХН-ын Улс төрийн товчооны 1957 оны 11дүгээр сарын 2-ны 387 дугаар тогтоолд " Хилийн шугамыг тодруулан тогтоох хэлэлцээг явуулахдаа түүхт материалыг голчлон үндэс болгохоос гадна ард түмний одоогийн амьдралын шаардлагыг харгалзан гүйцэтгэх" чиглэл өгчээ. Мөн оны СнЗ-ийн 458 дугаар тогтоолоор хилийн хэлэлцээ хийх Засгийн газрын төлөөлөгчдийг баталж, даргаар нь ГЯЯ-ны сайд С.Аварзэдийг томилсон.

Хэлэлцээр Монгол-Тувагийн 1932,1934 оны гэрээг түүхт материал гэж үзэх эсэхээс эхлээд маргаантай, сунжрах төлөвтэй болсон юм. Гэвч ЗХУ-аас манайд сууж байсан элчин сайд В.М.Молотов хилийн асуудлыг 1932 оны протоколын дагуу шийдэхийн тулд ЗХУКН-ын Төв Хорооны мэдэгдэх

бичгийг Монголын талд гардуулан хүчтэй шахалт үзүүлсний дараа хилийн хэлэлцээ үндсэндээ Зөвлөлтийн талын саналын дагуу явагдаж, 1932 онд тогтоосон шугамаар Монгол-Зөвлөлтийн Тувагийн хэсэг дэх хил тогтоогдсон юм.

Монгол-Зөвлөлтийн хилийг Тувагийн хэсэгт газар дээр нь тогтоож гэрээ байгуулахаар манай засгийн газар 1957 онд Зөвлөлтийн талд санал болгосны дагуу мөн оны 12-р сараас 1958 оны 01-р сарын 30-ныг хүртэл Улаанбаатар хотноо хоёр талын төлөөлөгчдийн хооронд хилийн гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ явагдаж нийт 13 удаагийн хуралдаан болжээ.

Хэлэлцээр хоёр сар гаруй хугацаанд үргэлжилсэн бөгөөд анхнаасаа л хурц тэмцэл маргаан, мэтгэлцээн дунд өрнөж, өөр өөрсдийн байр суурийг хамгаалсан байдлаар явагдсан байдаг. Хэлэлцээрийн явцад С.Аварзэд 13 удаа, В.М. Молотов 11 удаа үг хэлж үзэл бодлоо илэрхийлсэн байдаг. Хэлсэн үгийн утга санаа, агуулгаас нь харахад уг хэлэлцээр ямар хүнд нөхцөлд явагдаж байсан, хэн нь хэн бэ? гэдгийг хэн ч ойлгохоор байлаа.

Тухайлбал: В.М. Молотов "Монголын газар нутгаас баруун болон баруун хойт хилийн дагуу Асгатын оройгоос Их Соёоны нуруу хүртлэх гүнээрээ 3-30 км өргөн 300 орчим км урт газрыг ЗХУ-д таслан өгөхийг" шаардсан байдаг.

С.Аварзэд: "Энэ бол дээр үеэс уламжлагдан ирсэн түүхэн хил. Хилийг өөрчлөх шаардлага байхгүй" гэсэн хариулт өгсөн байдаг. Мөн нэг удаагийн уулзалт дээр В.М.Молотов "нөхөр Аварзэд алгын чинээ газартай юунд нь зууралдаад байгаа юм бэ? Ер нь ирээдүйд танай Монгол чинь хаана, ямар байх нь тодорхойгүй шүү" гэж хэлсэн байдаг. Тэр алга дарам газар нутагт нь Асгатын оройгоос Их Соёоны дагуух газар нутаг, Хөвсгөл орчимд Шишгэдийн хөндий голтойгоо, баруун тийшлээд Тэсийн гол багтсан нийт 7000 хавтгай дөрвөлжин км газар нутаг бөгөөд Асгат орчмын 84 хавтгай дөрвөлжин км газрыг Монголд үлдээгээд Монголын уламжлалт түүхэн хил дагуу Увсын Давст, Тэс сумын нутгаас 1247 хавтгай дөрвөлжин км газар нутгийг тасдан авч чадсан түүхтэй.

Монгол-Зөвлөлтийн хоорондох /Тувагийн хэсгийн 1305 км/ хилийн тухай гэрээнд 1958 оны 3-р сарын 26-нд Улаанбаатар хотноо БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1 дүгээр орлогч Л.Цэнд, ЗСБНХУ-аас тус улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд В.М.Молотов нар гарын үсэг зурав. Уул гэрээг БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид 1958 оны 4-р сарын 13-нд, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчид 1958 оны 5-р сарын 24-нд тус тус баталж, батламж жуух бичгүүдийг мөн оны 6-р сарын 3-нд Москва хотноо солилцжээ.

Гэрээний дагуу хоёр улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх ажил 1958-1960 онд явагдаж дууссан бөгөөд демаркацийн баримт бичгүүдийг БНМАУ-ын Сайд нарын зөвлөл 1961 оны 01-р сарын 16-нд баталжээ. Ийнхүү Монгол-Тувагийн хооронд олон жил шийдэгдээгүй явж ирсэн хилийн асуудлыг нэг тийш болгон шийдвэрлэжээ.

С.Аварзэд агсны Монгол Улс, Монголын ард түмний өмнө байгуулсан түүхэн гавьяаг ганц өгүүлэл, найруулаар илэрхийлэх нь хангалтгүй бөгөөд товчоос товчхон дүгнэвэл:

Монгол Улсын түүхэн хилийг хэвээр байлгахын төлөө, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө, мятрашгүй тэмцэж энэхүү хүч тэнцвэргүй тулаанаас харин ч хохирол багатайгаар гарч чадсанд орших бөгөөд ганц тоогоор илэрхийлэхэд Монгол улсын газрын зураг дээр цэг төдийгөөр тэмдэглэгддэг ч 84 хавтгай

дөрвөлжин км газрыг эзэлж өнөөгийн үнэлгээгээр 4.2 тэрбум ам долларын өртөгтэй 2566 тн цэвэр мөнгөний нөөцтэй бусад дагуул ашигт малтмал бүхий Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг дэвсгэрт улсын хилийн торгон зааг дээр орших Асгатын мөнгөний орд газрыг авч үлдсэн билээ. Энэ бол эдийн засгийн чанартай ганц л тоо юм.

Мөн тухайн үеийн улс төрийн эздрээтэй нөхцөл байдал, эдийн засгийн бүхий л хүрээнд " ах дүү ёсны хуваалт, хуваарилалтын зарчим "буюу" ах нь дандаа томыг авдаг" хэлбэр үйлчилдэг, гадныхан, гадаадынхан тэр тусмаа Зөвлөлтийн ах нарыг хүндэтгэн, бүхнээ л барьдаг, зориулдаг байсан тэр цаг үед эх нутаг, газар шороо, нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, түүхэн хилийг олон зууны турш өвлөгдөн ирсэн хэвээр нь хойч үедээ үлдээхийн төлөө тэмцсэн тэмцэл нь өнөөгийн бидэнд, ирээдүй хойчид ч Монгол хүн, Монгол улсын иргэн, төрийн түшээ, жинхэнэ монгол эр хүний мөн чанар, алсын хараа, голч тууштай байдлыг харуулж, эх орны эрх ашгийг бүхнээс, бүгдээс дээгүүр тавих , тавьдагийн жинхэнэ жишээ, жишиг болсонд оршино.

Бүхнээ, бүгдийг тэр байтугай амиа алдана гэдгийг мэдэж байсан ч эх орныхоо төлөө зүтгэнэ гэдгийг үг хэлээрээ бус үйл ажиллагаараа хойч үедээ нотолсон С.Аварзэд гуайн гавъяа зүтгэл өнөө ч мардагдах учиргүй.

Өнөөгийн эх орноо, нутаг дэвсгэрээ, эрдэс баялгаа гадныханд найр тавьсан хүмүүс энэ хүнээс үлгэр жишээ авдаг болоосой гэж горьдож суудгаа нуух юун.

Монгол улсын нутаг дэвсгэрийн ашигт малтмал бүхий газруудын 60 хувийг 60 жилийн хугацаатайгаар гадныханд түрээслүүлсэн гэсэн тоог эмзэглэхгүйгээр хүлээн авах боломжгүй юм.

Эх орон, эх нутагтаа халуун хайртайг биеэрээ харуулсан энэ эрхмийн алдрыг мөнхжүүлэхээр Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн 8-н жилийн дунд сургуулийг С.Аварзэд агсны нэрэмжит болгохоор олон жил хөөцөлдөж, олон газрын үүд татаж, олон албан тушаалтан, түшмэдтэй уулзаж учирсан ч, учирласан ч тодорхой алдар цол, гавъяа шагналгүй хүн байна, энэ нь нэрэмжит байх, болзол, журам зааврыг хангахгүй байна гэж хад мөргүүлнэ. Энэ хүний байгуулсан гавьяаг гавьяа гэхгүй бол ямар гавьяаг гавьяа гэх юм бэ гэж түргэн хэллэгийн хэлбэрээр асуумаар санагдана.

Хятадад Монголыг нэгтгэхийн төлөө тэмцэгч Ерөнхий сайд асан Ба Лингийн Цэрэндорж, түүхэн хилийг өөрчилснийг зөвшөөрч гарын үсэг зурж, энэ хэлэлцээрийг эздрээтэй болгох, асар их хохирол учруулах эхлэл, нөхцлийг бүрдүүлсэн Ерөнхий сайд асан П.Гэндэн ,өнөө үеийнхэн Монгол улс, Монгол үндэстний өмнө байгуулсан тодорхой гавьяагүй, тухайн зурвас үед албан тушаал хашиж байсан олон хүмүүст төдийгүй, монгол ганзагын наймаачдыг хөлжүүлсэн тарвага, монгол банхар, зугаа цэнгэлийн дээд манлай хурдан морь зэрэг амьтдад зориулсан олон сая төгрөгний өртөг бүхий хөшөө дурсгал сүндэрлэж, нэрэмжит гудамж, талбай, байгууллагын уртын урт жагсаалт хөврөвч жинхэнэ эх орончдын дүрс, нэр ч үл дурьдагддаг нийгмийг бид бүтээж байна.

Монгол Улсын тусгаар тогтнолд түүхэн гавьяа байгуулсан Богд хаандаа, эх оронч С.Аварзэд агсанд хөшөө босгоогүй байж банхар нохойд хөшөө босгосонд харамсаж буй сэтгүүлчтэй санаа нэг байна.

Асгатын мөнгөний орд ашиглалтанд орох тэр үед Аварзэд гуайд мөнгөн хөшөө босгохсон.

Улсын хил хамгаалалтад Монгол ардын хувьсгалт цэрэг (Монголын ардын арми, зэвсэгт хүчин)-ийн анги, салбарууд дэмжлэг үзүүлж ирсэн байдал, түүнд хийх дүн шинжилгээ

ДХИС-ийн ХАС-ийн ЦХТ-ийн эрхлэгч хурандаа И.Сэржхүү

1932 оноос Монгол Ардын Хувьсгалт Цэргийн(тэр үеийн нэрээр) анги, салбарууд хил хамгаалах үүргээс чөлөөлөгдөж улсын хилийг дангаар хариуцсан хамгаалах үүрэг хүлээсэн хязгаарын цэргийн ангиуд улсын баруун, өмнөд хилийн чиглэлүүдэд байгуулагдаж эхэлсэн.

БНМАУ-ын СНЗ-ийн 1933 оны 1 дүгээр сарын 20-ны гуравдугаар тогтоолоор Хязгаарын цэргийг ДХГ-ын харьяанд байгуулж, уг шийдвэрийн үндсэн дээр Цэргийн Яам Улаанбаатар хот болон орон нутгийн цэргийн ангиудаас зарим анги, салбаруудыг Хязгаарын цэрэгт шилжүүлэн өгчээ. Тухайлбал: Цэргийн зөвлөлийн гурван тоот тушаалаар МАХЦ-ийн 21,37 дугаар морьт суман, Лүнгийн 6 дугаар морьт хороо нь ДХГ-ын Хязгаарын цэрэгт бүх орон тоо, зэвсэглэл хэрэглэл, агт уналгын хамт шилжиж ирснээр хилийн анхны отряд, комендатурууд байгуулагдав. Төр, засгийн удаа дараагийн шийдвэрээр МАХЦ-ийн анги, салбаруудыг бүрэн хэмжээгээр буюу хэсэгчилсэн байдлаар хязгаарын цэрэгт шилжүүлсэн нь, хил хамгаалах мэргэжлийн цэргийн суурийг бүрдүүлсэн чухал арга хэмжээ байлаа. Энэ үед Японы түрэмгийлэгчид Монгол Улсын дорнод хилийн чиглэлд цэргийн хүчээр их, бага хэмжээний түрэмгийлэл удаа дараа үйлдэж, монгол орны аюулгүй байдал, тусгаар тогтнолд шууд халдахаар заналхийлж эхлэв. МАХЦ шинэ залуу бие даан байгуулагдсан Хязгаарын Цэрэгт үндсэн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ өөрийнхөө хүчийг зузаатган байлдааны үүрэг биелүүлэхэд бэлтгэн, дорнод хилийн чиглэлд улсын хилийг халхлан зарим нэгтгэл, ангиудаа бүлэглэн шилжүүлжээ. СнЗ-ийн 1937 оны 10 дугаар сарын 18-ны 28 тоот тогтоолоор МАХЦ-ийн дивизүүдийг улсын хилийн ойролцоо шилжүүлэх, зарим ангиуд шинээр байгуулах болон ЗХУ-аас цэргийн тусламжын хүрээнд ирүүлсэн улаан армийн томоохон бүлэглэлийг хилийн бүсэд байрлуулах арга хэмжээ авсан. ДХГ-ын Хязгаарын Цэрэг нь үндсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ хилийг халхлах, манай нутагт халдсан харийн цэргийн түрэмгийлэгчдийн довтолгоог няцаахад Монгол-Зөвлөлтийн армийн нэгтгэл, ангиудын байлдааны ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг биелүүлж байсан байна. Ингэснээр байнгын армийн зүгээс хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа оргилдоо хүртэл идэвхжиж, хил хамгаалалтын хүчирхэг хоёрдугаар зааг бий болсон байна Хил хамгаалалтад МАХЦ-ийн анги, салбаруудын үзүүлэх дэмжлэгийг Хязгаарын Цэрэгт улам ойртуулж, зарим чиглэлд хязгаарын цэргийн анги, салбаруудтай хамтран үүрэг

гүйцэтгэх тогтолцоог бий болгов. Ийм байдлаар Монгол Улсын баруун болон зүүн, зүүн өмнөд хилийн хамгаалалт Хязгаарын цэрэг, МАХЦ-ийн нэгтгэл, анги, салбаруудын хамтын хүчээр нэг зорилготой явагддаг байжээ.

Үүний тодорхой хэсэг гэвэл:

1. 1932-1937, 1940-өөд оны сүүлч хагаст баруун хязгаарт гадаадын дээрэмчидтэй явуулсан тэмцлийн үеийн хамтын ажиллагаа, үзүүлсэн дэмжлэг;

2. Дорнод хилийн цагийн байдлаас хамаарч Японы түрэмгийлэчидтэй хийж байсан зэвсэгт мөргөлдөөн, байлдаан, Халх голын дайнд Хязгаарын цэрэг, МАХЦ-ийн нэгтгэл, анги, салбаруудын хамтын ажиллагаа орно.

МАХЦ-ээс 1933-1939 онд дорнод хилийн чиглэлд авсан арга хэмжээ, Хязгаарын цэрэгт үзүүлж байсан дэмжлэг нь, МАХЦ-ийн нэгтгэл, анги, салбарууд Хязгаарын цэргийн хилийн отряд, заставуудтай хамтын ажиллагаа, харилцан ажиллагааны онцгой хэлбэр байсан байна.

Онцгой хэлбэр нь юу гэвэл, тухайн чиглэлийн хил хамгаалах үүрэг хүлээсэн Хязгаарын цэрэгт шилжүүлсэн зарим морин хороодууд нь МАХЦ-ийн нэгтгэлийнхээ бүрэлдэхүүнд байж хил халхлах үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ хилийн заставууд, харуулуудыг хүч нэмэгдүүлж байлаа, харин Хязгаарын цэргийн хилийн отряд, заставууд нь МАХЦ-ийн нэгтгэл, ангиудад шууд захирагдан байлдаан, операци явуулах нэгдсэн бодлого-төлөвлөгөөтэй үйл ажиллагаа явуулж байлаа.

Тэдгээрийн гүйцэтгэж байсан үүргийг цэргийн урлагийн байр сууринаас задлан шинжилж үзвэл:

1. Дайсны тухай тагнуулын мэдээ олзворлох;

2. Хангах зурвас, тэргүүн байр, байлдааны хамгаалалтын үүрэг гүйцэтгэх;

3. Цэргийн бүлэглэлийн хажуу үзүүр, завсрыг хангах;

4. Цэргийн командлалын даалгавраар тусгай чиглэлийг халхлах болон бусад үүргийг биелүүлж байсан нь хойшид ч сургамжтай болсон юм.

1932-1937, 1940-өөд оны сүүлч хагаст баруун хязгаарт гадаадын дээрэмчидтэй явуулсан тэмцлийн үед МАХЦ-ээс Хязгаарын цэрэгт дэмжлэг үзүүлж байсан арга хэлбэр нилээд өвөрмөц онцлогтой байлаа. Үүнд:

1. Хил хамгаалах явцад болон зэвсэгт мөргөлдөөнд МАХЦ-ийн анги салбарууд шууд хамтран оролцох;

2. Хилийн тодорхой хэсгийг МАХЦ-ийн анги, салбар дангаараа хариуцаж хамгаалах;

3. Галын хэрэгслээр Хязгаарын цэргийн анги, салбаруудын байлдааны ажиллагааг дэмжих;

1953-1960-аад оны хагас хүртэл улсын хил хамгаалалтын үндсэн арга нь хилийн төлөөлөгчийн ажил байсан ба хилийн 10 гаруй пункт үлдэж, улсын хил хамгаалж байлаа. МАА энэ үед үлэмж хэмжээгээр цомхотгогдсонтой холбоотойгоор улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх практик арга хэмжээ үндсэндээ тасалдсан байна.

1967-1990 онд тухайн үеийн цэрэг улс төрийн цагийн байдал хурцадсантай холбогдон улсын өмнөд хилийн хамгаалалтыг дахин сэргээх, батлан хамгаалах хүчийг нэмэгдүүлэх, МАА(ЗХ)-ийн зүгээс

улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага бий болжээ.

Энэ үеийн үзүүлэх дэмжлэгийн хэлбэрүүд нь:

1. Хилийн цэрэг, МАА(ЗХ)-ийн хооронд стратегийн болон тактикийн түвшинд харилцан ажиллах төлөвлөгөө хийх;

2. Хамтарсан сургууль, дадлага явуулах;

3. Хил орчмын нутаг дэвсгэр болон стратегийн ач холбогдолтой чиглэлийн судалгаа явуулах;

4. Газрын хилийн хамгаалалтыг Хилийн цэрэг, агаарын хилийн хамгаалалтыг МАА, (ЗХ) гүйцэтгэх чиг үүргийн хувиарлалт хийж хэрэгжүүлэх;

5. Зарим чиглэлд МАА-ийн нэгтгэл, ангиудыг улсын хилийн бүс рүү ойртуулан байрлуулж, хилийн хамгаалалтад дэмжлэг үзүүлэх замналыг ойртуулах;

6. Хил хамгаалалтын нэгдсэн тогтолцоо бий болгож, түүнд хүчний байгууллагууд, юуны өмнө ЗХ-ний дэмжлэг үзүүлэх арга, хэлбэрийг тодотгох зэрэг байлаа;

1990 оноос Монгол Улсад нийгмийн тогтолцоо өөрчлөгдөн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжлээ.

Улс орныхоо хилийг Хилийн Цэрэг эргэн тойрон хамгаалах шаардлага цагийн байдлаас урган гарав. ЗХ-ний анги, салбаруудаар улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлж буй өнөөгийн байдлыг авч багцлан авч үзвэл:

1. Улсын хил хамгаалалтад ЗХ-ний анги, салбаруудаар дэмжлэг үзүүлэх үндэслэл болох заалтууд боловсруулагдаж хилийн болон батлан хамгаалах, ЗХ-ний тухай хуулиуд, Хил хамгаалалтын I, Байлдааны дүрэм 2/100, БХЯ-ны сайдын болон ЗХЖШ, ХХЕГ-ын даргын хамтарсан тушаалуудад тусгагдсан.

2. ХХЕГ, ЗХЖШ-ын хооронд харилцан ажиллагааны төлөвлөгөө шинэчлэгдэн батлагдсан.

3. Увс, Завхан, Тувагийн чиглэлд хилийн хэсэгт үүссэн цагийн байдлын өрнөлтийг үндэслэн 1999 оны 3 дугаар сарын 15-наас эхлэн Монгол Улсын Засгийн Газрын 20 дугаар тогтоолын хүрээнд Ерөнхий сайдын баталсан төлөвлөгөөний дагуу Увс, Завхан аймгийн хилийн хэсэгт "Хавар-99", "Намар-99" хилийн операцийг оперативийн масштабтайгаар сар гаруй хугацаанд явуулахад ЗХ-ний ерөнхий зориулалтын цэргийн 123,186-р ангиудаас салбар, 109-р ангиас МИ-8 нисдэг тэрэгний тоот оролцсон байна. Бүхэлд нь нэгтэн дүгнэлт хийвэл 1933 оноос-өнөө хүртэл МАХЦ, МАА, ЗХ-ний анги, салбарууд улсын хамгаалалтад дэмжлэг үзүүлэх, улсын хил халхлах үүргээ тухайн үеийн цэрэг улс төрийн цагийн байдалтай уялдуулан хамтарсан хээрийн дадлага, сургууль хийж харилцан ажиллагааны төлөвлөгөөг тодотгох, удирдах бүрэлдэхүүн нь КШС, дадлагад оролцох, холбогдох эрх зүйн баримт бичиг боловсруулан гаргах хэлбэрүүдээр явуулж иржээ.

ГАДААДЫН ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

Гадаад орнуудын хил хамгаалах байгууллагуудын тухай

Дэлхийн олон улсуудад хэрэглэж байгаа хилийн байгууллагууд гэдэг нэрийн дотор Хилийн алба, хилийн цагдаа, хилийн цэрэг, хилчин –хилийн цагдаа гэсэн ойлголтууд багтаж байгаа бөгөөд улс бүрт янз бүрээр нэрлэдэг байна. Эдгээр нэр томьёоллыг тивүүдээр авч үзвэл:

Ази тивд:

- Бангладеш — Бангладешийн хилчид
- БНХАУ - Ардын зэвсэгт цагдаа, НАХЯ
- Израйльд - Израйлийн хилийн цагдаа
- Гонконгд - Хилийн район, Гонконг цагдаа
- Сингапурт - Дүрвэгсэдийн газар ба хилийн цагдаа

Европ тивд:

- Европын холбоо — Фронтекс
- Андорра — Андорын цагдаа
- Беларусь — Улсын хилийн хороо
- Болгар улсад — Дүрвэгсэдийн алба ба хилийн цагдаа
- Эстони улсад — Хилийн цагдаа
- Финлянд улсад — Финийн хилчид
- Францад Үндэсний жандарам, хөндлөнгийн татварын алба, Гаалийн ерөнхий захиргаа
- Герман улсад — Германийн Холбооны цагдаа
- Латви улсад — Хилийн засаглал
- Литва улсад — Төрийн хилийн алба
- Румынд — Румынийн хилийн цагдаа
- ОХУ-д — Холбооны хилийн алба
- Испани улсад — Иргэний гварди
- Швейцари улсад — Хилийн гвардийн корпус
- Англи улсад — Их Британи улсын хилийн агентлаг
- Нидерланд улсад — Эзэн хааны Marechausse
- Португаль улс — Хилийн шуурхай үйлчилгээ, электрон халхлалт
- Польш улс — Хилийн хамгаалагчид

Хойт Америк:

Канад улс — Канадын хилийн албаны агентлаг

АНУ — Холбооны нэгдсэн улсын хилийн эргүүл

Далайн орнууд

- Австрал улс Австралийн гаалийн албаа, иргэн ба дүрвэгсдийн асуудал эрхлэсэн департамент

- Шинэ Зеланд Шинэ Зеландийн гаалийн алба ба Шинэ Зеландын дүрвэгсэдийн газар.

Хилийн, хилчид, Хилийн цэрэг, хилийн цагдаа, тухайн улсын үндэсний аюулгүй байдлын агентлагийн хилийн цагдаа гэдэг нь хилийн шалган нэвтрүүлэх албыг эрхлэх ба өөрөөр хэлбэл үндэсний хил хязгаарын аюулгүй байдлыг хангаж байгаа бүрэлдэхүүн юм.

Хил хамгаалах олон улсын байгууллагуудын тайван цагт заавал биелүүлэхээр хүлээх үндсэн үүрэг нь:

- Хилийн албаны болон тусгай бүлэглэлүүдийн хүчээр улсын хилийн дагууд эргүүл хийх

- Хөрш орнуудтай байгуулсан олон улсын хилийг тагнуул, туршуулууд шургалан нэвтрэхээс сэргийлэн хилийн заставуудын хүчээр хамгаалах

- Найдвартүй хөрш орнуудын талаас алан хядагчид, босогчид зэвсэг галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар нэвтрүүлэхийг оролдсон оролдлогыг таслан зогсоох

- Хилийн застав, эргийн хамгаалалтын бүрэлдэхүүнээс олон улсын хилийг шалгах зорилгоор тогтмол хугацаанд эргүүл гаргах

- Нуцаар хил давж дүрвэх, хүн болон эд зүйлийг хууль бус аргаар хил нэвтрүүлэхтэй тэмцэх

- Улсын хил зөрчих гэсэн аливаа оролдлого , ул мөрийг шалган тогтоох

- Гадаадын элементүүдээс улсын хил зөрчсөн болон оролдсон шинж тэмдэг илэрсэн болох нь тогтоогдсон нөхцөлд хариуцлага хүлээлгэхээр эрэн сурвалжлах, үүний тулд ойролцоох суурин газрууд, хот, тосгонд нэвтрэн орж шалгалт явуулах

- Харилцан ажиллагаатай хууль хяналтын байгууллагууд, гаалийн болон цагдаагийн газруудад мэдэгдэх гэх маягаар тодорхойлогдож байна.

Дээр дурьдсан заавал биелүүлэх үүргийн зэрэгцээ дараах үүргүүдийг тогтмол гүйцэтгэнэ. Хилийн талаар тогтмол гүйцэтгэх үүргийг загварчилсан байдлаар харуулбал:

- Улс орны хил, хязгаарыг хамгаалах ба өдөр тутамд удирдах

- Улсын хилээр нэвтэрч байгаа иргэд, тээврийн хэрэгсэл, дамжин өнгөрөхтэй холбоотой баримт бичгүүдийг шалгах

- Улсын хилээр хууль бусаар иргэд, тээврийн хэрэгсэл, ачаа бараа бусад эд зүйлийг нэвтрүүлэхгүй байх

- Улсын хилээр хориглосон болон хязгаарласан эд зүйл / зэвсэг, галт хэрэгсэл, хортой бодис гэх мэт/ тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавих

- Гадаадын иргэдийн визийн горимд хяналт, шалгалт хийх

Гаалийн хяналтаас гадуур бараа таваар, бусад эд зүйлийг гаргах гэсэн оролдлогод хяналт тавьж цаг тухайд нь таслан зогсоох

- Улсын хил, түүний журамтай холбоотой асуудал зөрчигдсөн нөхцөлд мөрдөн шалгах ажлыг явуулах

Дайн бүхий үед заавал биелүүлэх үүрэг :

Дайн болон дайн бүхий нөхцөлд өөрийн улсын хилийн үндсэн үүргээс гарч улс орныхоо байнгын цэргийн бүрэлдэхүүнд багтах ба улмаар олон

улсын нэгдмэл хилийн бүрэлдэхүүнд багтан хөрш дайсагнагч орны өмнө нэгдмэл хилийн хүчин болно.

Дайны үед хилийн бүрэлдэхүүн нь сайтар төхөөрөмжлөсөн бэхлэлтүүд, далдлах байруудаас байнгын цэргийн бүрэлдэхүүний хамтаар улс орныхоо нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор хориглон хамгаалах байлдааныг явуулна.

Гадаад орнуудын хилчид, хил хамгаалах бүрэлдэхүүн

Бангладешийн хилчид /BGB/ нь тухайн улсын Дотоод хэргийн яамны бүрэлдэхүүнд багтсан хилийн аюулгүй байдал, дамын наймаатай тэмцэх зорилготой цэрэгжүүлсэн байгуулага юм.

Бангладешийн хилчид нь 1795 онд анхлан байгуулагдсан орон нутгийн Ramgarh батальоны үе залгамжлагч бөгөөд хөнгөн зэвсэгтэй, улсын хилийг хориглон хамгаалах үндсэн үүрэгтэйн дээр онцгой нөхцөлд Засгийн Газрын даалгавраар тусгай үүргийг гүйцэтгэнэ.

Египетийн хилчид нь Батлан хамгаалах яамны хяналтанд байх ба хөнгөн зэвсэглэсэн цэрэгжүүлсэн байгуулага бөгөөд 25000 орчим хүмүүсээс бүрдэнэ.

Хилийн шалган нэвтрүүлэх үүргийг гүйцэтгэхийн хамтаар энхийг сахиулах, хар тамхи, дамын наймаачидтай тэмцэх үүргийг биелүүлдэг.

1980-аад оны төгсгөлөөс эхлэн зайнаас мэдрэх хэрэгслүүд, шөнийн дуран харааны болон холбоо, тээврийн хэрэгсэл, орчин үеийн өндөр хурдтай хөвөгч завь онгоцуудаар зэвсэглэсэн байна.

Энэтхэгийн хилийн аюулгүй байдлын хүчин нь Энэтхэгийн Засгийн газрын хилийн эргүүлийн агентлаг бөгөөд 1965 оны 12сарын 1 нд байгуулагдсан ба Энэтхэгийн цэрэгжүүлсэн хүчний бүрэлдэхүүн хэсэг юм. Энэтхэгийн хилийн аюулгүй байдлын хүчний үндсэн үүрэг нь үндэстэн дамжсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба таслан зогсоох, тайван цагт олон улсын хилийг хамгаалах болно.

Бусад цэрэгжүүлсэн байгуулагуудын нэгэн адилаар хилийн аюулгүй байдлын хүчин нь Дотоод хэргийн яамны Захиргааны хяналтанд байна.

Италийн хилийн албаны цагдаа нь өөрийн улсынхаа армийн салбар бөгөөд Сангийн сайдын удирдлаганд ажиллана.

Гол үүрэг нь дамын наймаатай тэмцэх, хар тамхины хууль бус эргэлт, татвараас зайлсхийх болон санхүүгийн бусад гэмт хэргүүдтэй тэмцэх явдал юм.

Хилийн харуулууд нь карбинеруудаас / нэгэн төрлийн цагдаагийн хүчин/ бүтнэ. Түүнчлэн гүйцэтгэх үүрэгт нь дүрвэгсэд, хилийн цагдаагийн үүргүүд багтана.

Үндэсний аюулгүй байдлын Департментэд дүрвэгсэд ба хилийн цагдаагийн албыг байгуулж улмаар Итали улсад гадаадын иргэд нэвтрэн орохтой холбоотой журмыг сахиулах үүргийг гүйцэтгүүлж байна. Энэ үйлчилгээ нь төвийн болон орон нутгийн түвшинд агаараар, газраар болон далай, тэнгисээр орж байгаа хөдөлгөөнүүдэд хяналт тавих явдал юм.

Энэ алба нь паспортын журмыг сахиулах, түр болон байнга оршин

суух журам, иргэншил олголтонд хяналт тавих, нууц далдуур дүрвэхээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой ажлуудыг хариуцан гүйцэтгэнэ. Шенгений орнуудын хүрээнд иймэрхүү үүрэг нь байхгүй болж байгаа боловч зарим талаар хэрэгжсээр байна.

Энэ албанаас үе үе хилийн бүх хэсэгт гарч баримт бичгийг шалгах, зорчигчдын ачаа тээшинд үзлэг хийх ажлыг тусгайлсан төлөвлөгөөгөөр болон гэнэтийн байдлаар хийдэг.

ОХУ : ОХУ-ын хилийн алба нь 2003 оноос Холбооны Аюулгүй байдлын албаны агентлагт хамаарах бөгөөд ЗХУ-ын ХЦ-ийн шууд залгамжлагч гэж үздэг төдийгүй байгуулагдсан ойг нь /1918 оны 5 сарын 28/ бүх орон даяар тогтмол тэмдэглэсээр ирсэн байдаг.

Түүхийн үүднээс авч үзвэл хилийн хамгаалалтын байгуулага нь улс орныхоо нутаг дэвсгэр дээр эмх журам тогтоох, хөрш орнуудаас улсын хилээр иргэд эмх журамгүй зорчих явдлыг таслан зогсоох, улс орны болон нийт ард иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалах үндсэн үүргийг гүйцэтгэсээр ирсэн байна.

Орост хил хамгаалах үйл ажиллагаа нь бүр 14-р зуунд үүссэн ба Татарууд өмнөт болон зүүн хэсгээр нь байнга нэвтрэх болсонтой холбоотойгоор морьт хянагчид бүхий отрядуудыг томилж байжээ.

1819 оноос хилийн бүрэлдэхүүнийг Гаалийн байгууллагын бүтцэд оруулснаар төрийн зохион байгуулалтын бүтцэд багтах болсон. 1893 онд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтан бие даасан цэргийн корпус болгож улмаар хилийн тойргуудыг байгуулжээ.

ЗХУ-ын үед оросын хилийн цэрэг нь ОГПУ, НКВД-ийн бүрэлдэхүүнд багтаж байгаад хожмоо ЗХУ-ын УАХХ-ны бүрэлдэхүүнд шилжин Зэвсэгт хүчний бусад төрлүүдийн нэгэн адил өргөжин хөгжсөөр ирсэн байна.

1994 оны 1 дүгээр сарын 10-нд ОХУ-ын Ерөнхийлөгчийн баталсан "Гүйцэтгэх засаглалын холбооны байгууллагуудын бүтцийн тухай " зарлигаар Холбооны хилийн алба нэртэйгээр шинэчлэн байгуулагджээ. 2003оны 3 дугаар сарын 11- нд Холбооны хилийн албыг татан буулгаж хилийн албаны байгууллагууд болон ХЦ-ийг Холбооны Аюулгүй Байдлын Алба /ХАБА/-ны бүрэлдэхүүнд оруулсан байна.

Улсын хил нь хил хамгаалалтын нэгэн чухал обьект юм. Тухайлбал энэ тухай Оросын ХЗШУ-ны доктор К.Х. Иполитовын тэмдэглэснээр... "хил дамнасан зэвсгийн болон дамын наймаа, стратегийн ач холбогдол бүхий түүхий эд, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарлалт бүхий бараа түүхий эд, хар тамхи, мансууруулах бодис нэвтрүүлэх оролдлого, хууль бусаар дүрвэгсдийн урсгал, нутаг дэвсгэрийн маргаантай асуудлыг шийдвэрлэх зэрэг нь улсын хил, түүний хязгаарын хүрээнд гардаг иргэдийн болон улсын аюулгүй байдлыг хангах, хилийн районд нийгмийн хэв журмыг хангах арга хэмжээг тайван цагт хилийн цэрэг хил хамгаалах байгууллага гүйцэтгэж байна" гэжээ.

Улсын хил гэдэг нь тухайн улс орны нутаг дэвсгэрийн зах хязгаарыг хатуу тогтоож байгаа зааглах шугам бөгөөд хуурай газраар болон усаар түүнчлэн агаараар тогтоох бөгөөд хөрш

улс орнуудын гэрээ хэлэлцээрүүдээр баталгаажсан байдаг.

ОХУ-ын хилийг нүдэнд харагдахуйц хилийн тэмдгүүдээр газар орон дээр нь тэмдэглэсэн байх ба нутаг дэвсгэрийн нэг салшгүй хэсэг нь далай тэнгис, хилийн гол усны санг бүрдүүлж байгаа хэсгүүдэд эдийн засгийн онцгой бүсийг тогтоосон явдал юм.

1991 оны 4 дүгээр сарын 1-нд Улсын хил хамгаалах тухай хууль, 1995 оны 04 дүгээр сарын 3-нд ХАБА-ны тухай хууль, 1995 оны 10 дугаар сарын 30 –нд ОХУ-ын эх газрын болон далай тэнгисийн ус руу түрж орсон хуурай газрын тухай хууль, 1998 оны 7дугаар сарын 31-нд ОХУ-ын дотоодын ус болон далай тэнгисийн тухай хууль, 2006оны 6дугаар сарын 30-ны ОХУ-ын зарим хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг Холбооны хуулиуд, 2003оны 8 дугаар сарын 11-нд батлагдсан ХАБА-ны тухай удирдамж зэргээр ОХУ-ын хил хамгаалах байгуулгын эрх зүйн үндэс, эрх, үүргийг зохицуулж байна.

Пакистан – Пакистаны хилийн корпус нь ихэвчлэн омог, аймгуудын хүмүүсээс шилж авсан цэрэгжүүлсэн хүчин бөгөөд Пакистаны армийн офицерын удирдлагын доор ажилладаг байгуулага юм.

Хилийн корпус нь Хайбер, Белуджин мужуудад байрлах ба удирдагчаар нь байнгын армийн хошууч генералаас багагүй цолтой хүн ажиллах боловч энэхүү цэрэгжүүлсэн хүчин нь үнэн хэрэгтээ Дотоод хэргийн яаманд харьяалагдана.

Испани : Испани улсын иргэний цэрэгжүүлсэн гварди нь улсын хилийг хориглон хамгаалах асуудлыг хариуцна. Түүнээс гадна Гаалийн албаны департамент, татварын тусгай алба гэсэн мэргэжлийн байгууллагууд байх бөгөөд тэд нь хилийн албаны зарим ерөнхий үүргийг биелүүлдэг.

АНУ: АНУ-ын хилийн шалган нэвтрүүлэх алба нь Үндэсний аюулгүй байдлын Департментийн салшгүй хэсэг юм. Ийм хуульчлагдсан бүрэн эрх / дүрвэгсэд ба гаалийн хууль-мөрдөн шалгах үүрэг бүхий/ нь Гааль болон шалган нэвтрүүлэх алба, эргийн хамгаалалт /хязгаарлалтын үндсэн бүтэц/ ба дотор нь хуваагдаж байдаг.

Гаалийн болон хилийн алба нь дотроо бие даасан гурван төрлийн байгууллагаас бүрдэнэ. Хилийн албаны удирдах газар / АНУ-ын хилийн эргүүл/, Хуурай газрын болон ус, агаарын хилийн удирдах газар.

Хилийн албаны удирдах газарт томоохон боомтууд хоорондох газруудад хөлөг онгоцууд орох олон улсын хилийн хамгаалалт, хөдөлгөөнт хамгаалалтын агентлагууд багтах бөгөөд бүхэлд нь авч үзвэл АНУ-цагдаагийн тусгай хэлтсийн үүргийг гүйцэтгэнэ.

Орон нутгийн удирдах газрууд нь хүн, ачаа ,тээшийг АНУ-д хуурай газар, ус, агаараар нэвтрүүлэх эсэхийг шийдвэрлэдэг хууль хяналтын хэлтсүүд юм.

Агаарын болон усан хилийн Удирдах газар нь усан хилийн болон агаарын боомтуудын шалган нэвтрүүлэх болон гаалийн хяналтын асуудал, хуурай газрын хилийн болон эргийн хамгаалалтын зориулалт бүхий нисэх онгоц, усан онгоцнуудын үйл ажиллагааг зохицуулан удирдах үүрэгтэй.

АНУ-ын Эргийн хамгаалалт нь Зэвсэгт хүчний цэргийн бүрэлдэхүүн

хэсэг бөгөөд дотоодын болон олон улсын эзэмшлийн усанд хууль журмыг сахиулах үүрэгтэй байдаг.

Дүрвэгсэд болон Гаалийн хуулиуд нь дээр дурьдсан эргийн болон гааль, хилийн шалган нэвтрүүлэх албаны бүрэн эрхийн адил эрхтэй бөгөөд хилийн зөрчил болон АНУ-ын нутаг дэвсгэрт гарсан хэрэг зөрчлүүдийг мөрдөн шалгах эрхийг хуульчлан олгосон байдаг.

Англи- Хилийн хамгаалалтын үүргийг Их Британийн Хилийн хамгаалалтын Агентлаг хариуцах ба Англи улсад нэвтрэх цэгүүд дээр гаалийн болон паспортын журмыг сахиулах ажиллагааг хариуцана.

Түүнчлэн цагаачлалын болон гаалийн дүрмийг мөрдөж, хилийн хяналтыг гүйцэтгэхийн хамтаар орогнол хүсэх, иргэншил авах, Их Британд оршин суух, зорчихтой холбоотой өргөдлийг хүлээн авч шийдвэрлэнэ.

Афганистаны үндэсний цагдаа /АҮЦ/ Афганистаны үндэсний цагдаагийн хүчин нь өөрийн улс орныхоо хэмжээнд хууль сахиулах үүргийг биелүүлж байдаг гол байгууллага юм. Афганистан улс үүсэн байгуулагдсан 18-р зууны үеэс үүсэн бий болсон түүхтэй бөгөөд Афганистаны Дотоод хэргийн Яамны хариуцлагын хүрээнд багтан үйл ажиллагаа явуулдаг ба одоогоор шинэчлэлт өөрчлөлтийн шатандаа байгаа юм.

Афганистаны Үндэсний Цагдааг шинэчлэх сурган бэлтгэх асуудлаар АНУ-ын цэргийн хүчин, Холбооны аюулгүй байдлын алба, НАТО-гийн зарим улс орнууд тухайлбал Германийн "S Bundespolizij", Английн "Скотланд-Ярда" зэрэг байгууллагууд идэвхтэй ажиллагаа явуулж байна.

АҮЦ-ийн хүчний бүрэлдэхүүн нь өнөөгийн байдлаар 90 000 гаруй бүрэлдэхүүнтэй бөгөөд ойрын ирээдүйд 160 000 хүргэхээр зорьж байгаа ажээ.

АҮЦ-ийн хүчний гол үүрэг нь дотооддоо хууль дэг журмыг сахиулах, хариуцлага хүлээлгэх болон хяналт шалгалтыг явуулах үүргийг гүйцэтгэхийн хамт хар тамхи, дамын наймаа, алан хядах үйл ажиллагаатай тэмцэх үүргийг давхар биелүүлж байна. АҮЦ-ийн хүчин нь дотроо дэд байгууллагуудад хуваагдах ба тухайлбал:

- Афганистаны хилийн цагдаа
- Афганистаны замын цагдаа
- Эрүүгийн мөрдөн шалгах газар
- Тэнцвэржүүлэх хүчний цагдаагаас бүрдэнэ.

Афганистаны хилийн цагдаа: Афганистаны хилийн цагдаа /АХЦ/ нь улсын хилийн болон нисэх буудлуудын аюулгүй байдал, тус улсад хууль бусаар нэвтрэх, гарах , хар тамхи, дамын наймааны гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой хариуцлагыг хүлээдэг. 2011 оны 1 сарын байдлаар АНУ-ын дүрвэгсдийн болон гаалийн байгууллагын 25 албан тушаалтан афганы хилчдийг сургах, бэлтгэх ажиллагааг гүйцэтгэж байгаа гэжээ.

АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын нарийн бичгийн дарга Д. Наполитано мэдэгдэхдээ: "энэ тоог 2011 оны эцэс гэхэд 65 болгоно" гэжээ Тэрээр Пакистантай хиллэж байгаа хилийн суурин болох Торхимд айлчлах үеэрээ сургалтын арга хэмжээнд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна.

АХЦ-ийн гол үүрэг нь:

- Афганы нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын бүсийн хүрээнд /55 км өргөнтэй/ хилийн эргүүл, хяналтыг гүйцэтгэх

- Дүрвэгсэдийн ажиллагааг зохицуулах / визийн үйлчилгээ, дүрвэгсдийн журам зөрчсөн ажиллагааг мөрдөн шалгах/

- Олон улсын нисэх буудлуудыг оролцуулан хилийн шалгалтын цэгүүдийг байгуулах болон тэдгээрийн хэвийн ажиллагааг хангах

- Олон улсын чанартай нисэх буудлууд дээр зорчигчдын аюулгүй байдлыг хангах, барилга байгууламж, нисэх онгоц, буудлын хамгаалалтыг хариуцах

АХЦ-нь **5529** км үргэлжлэх хилийн шугам болон олон улсын нисэх буудлуудын аюулгүй байдлыг хариуцана. Түүнчлэн улс орныхоо хэмжээнд дүрвэгсдийн болон гаалийн байгуулагын үйл ажиллагааг хариуцахын хамтаар хилийн цагдаагийн хүчний байнгын бүрэлдэхүүнтэй хамтран 55 км-ийн зурваст эргүүлийн арга хэмжээг гүйцэтгэнэ.

АХЦ-нь Үндэсний цагдаагийн удирдлагад ажиллах ба Афганы Дотоод хэргийн яамны хяналтанд байна. АХЦ-ийн төв штаб нь нийслэл Кабулд байрлах ба өөрийн бүрэлдэхүүний 13815 цагдааг 5 секторт хуваадаг үүнд:

- Өмнөд хэсэгт байрлах Спин Болдак хотод;
- Баруун хэсгийн Герат хотод;
- Хойд хэсэгтээ Мазари-Шарифе хотод;
- Зүүн хэсэгтээ Жалилабад хотод;
- Гардезийн бүс;

Афганы хилчдийн ихэнх нь НҮБ-ийн цэргийн хүчний болон бусад хамтран ажилладаг холбооны хүчний сургалтын баазуудад болон Европын Холбооны улсуудын цагдаагийн хүчний сургалтын төвүүдэд сургалт- бэлтгэлээ хангах ба шинэ дайчид нь 8 долоо хоногийн сургалтанд хамрагдана.

Болгар: Дүрвэгсдийн ба хилийн цагдаагийн алба нь хууль бус цагаачлал, хүний наймаатай холбоотой гэмт хэргээс урьдчлан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг явуулах ба хил хамгаалалттай холбоотой асуудлуудыг Хилийн Цагдаагийн Ерөнхий Газар хариуцан гүйцэтгэнэ. Хилийн Цагдаагийн Ерөнхий Газар нь дараах үндсэн үүргийг биелүүлдэг байна. Үүнд:

- Улсын хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэрт хамгаалалтыг зохион байгуулах

- Улсын хил зөрчигч, эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүд,тэдэнд туслагчид, тэдгээрийн ашигласан тээврийн хэрэгслийг илрүүлэн зохих байгууллагуудад шилжүүлэх,

- Зөвшөөрөлгүй иргэдийг хил нэвтрүүлэхгүй байх

- Төрийн бусад байгууллагуудын оролцоотойгоор болон бие дааж гэмт хэргийн шинжтэй хэрэг, зөрчлүүдийг илрүүлэн шийдвэрлэх

- Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч , тээврийн хэрэгслүүдэд үзлэг, шалгалт хийж тэсэрч, дэлбэрэх бодис, зэвсэг, галт хэрэгсэл, бусад хориотой эд зүйлийг илрүүлэх

- Улсын хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлттэй холбоотой мэдээлэл цуглуулах , нэгдсэн сан байгуулах

- Улсын хил зөрчсөн шинж тэмдэг, нөхцөл байдлын талаар нягтлан шалгаж дүн шинжилгээ хийх

- Улсын хил тогтоох, тэмдэглэх, хилийн тэмдгүүдийн бүрэн бүтэн байдлыг хариуцах, сэргээн засварлах болон алдаж устахаас сэргийлэх арга хэмжээг авч нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах

- Улсын хил зөрчигчийг хүлээн авах ба хүлээлгэн өгөх үед олон улсын гэрээ хэлэлцээрийг бүрэн сахих

- Улсын хилээр өнгөрч байгаа Дунай мөрний өөрийн талын хэсэгт хөвөгч хэрэгслүүдийн хөдөлгөөнд хяналт тавих, журам сахиулах

- Шалган нэвтрүүлэх боомт, гарцууд дээр төрийн бусад байгууллагуудын хамтаар нийтийн хэв журмыг чандлан сахиулах, иргэдийн эрх чөлөө, эд хөрөнгийг хамгаалах

- Болгорын үндэсний армийн хамтаар улсын хил дээр гарсан зэвсэгт мөргөлдөөнийг таслан зогсоох болон шийдвэрлэхэд оролцох

- Хил орчмын болон бүс нутгийн хэмжээнд хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахтай холбоотой асуудлаар төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах

- Бусад орнуудын хил хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллах

Румынийн хилийн цагдаа: Румын улсын Дотоод хэргийн болон Засаг захиргааны Яамны бүтцийн нэг хэсэг бөгөөд улсын хилийн аюулгүй байдал, улсын хилийн боомт газруудад баримт бичгийг шалгах, улсын хил нэвтрүүлэх ажиллагаанд хяналт тавих үүргийг биелүүлдэг.

2010-2011 онд Румын улс Шенгенийн хэлэлцээрт нэгдэхээр шийдвэрлэж байгаа ба ингэсэн нөхцөлд Үндэсний цагдаатай болохоор төлөвлөж байсан хэдий ч одоогоор тодорхой шийдвэрт хүрч чадаагүй байна.

Гүржийн хилийн цагдаа: Гүржийн хилийн хамгаалалтын байгуулагын шинэчлэл нь 2005 оноос эхлэсэн бөгөөд гол зорилго нь Гүрж улсыг Европын холбоонд элсэхтэй холбоотой бөгөөд НАТО болон Европийн холбооны шинжээчдийн санал, дүгнэлтийг харгалзан боловсруулжээ.

2006 оны 12 дугаар сарын 29-нд Гүржийн парламент Гүржийн хилийн цагдаагийн тухай хуулийг хэлэлцэн тэдгээрийн нийгмийн хангамжийн асуудал болон хилийн цагдаагийн албаны дүрмийг баталж улмаар Гүржийн Дотоод явдлын яаманд харьяалуулсан ба стратегийн цогц бодлогыг нь тодорхойлжээ.

2008 оны 8 сард болсон мөргөлдөөний дараа Гүржийн хилийн цагдаагийн бүтцэд өөрчлөлт оруулж хилийн зарим анги, салбарыг нь батлан хамгаалахын зарим салбаруудтай нэгтгэсэн байна. Тухайлбал ШНБ-уудыг ДЯЯ-ны цагдаагийн газарт, шуурхай ажиллагааны салбаруудыг мөн яамны тусгай газарт, нисэхийн тусгай ангиудыг БХЯ-нд, БХЯ-ны тэнгисийн цэргийн флотыг хилийн цагдаагийн газарт тус тус нэгтгэжээ.

ДЯЯ-ны цагдаагийн академийн хилийн факультетэд хилчдийг сургах болон давтан сургахын зэрэгцээ тэнгисийн цэргийн академид эргийн хамгаалалтын бүрэлдэхүүнээ сургаж байна. Сургалтын тусгай хөтөлбөрүүд боловсруулан зааварлагч, унтер офицеруудыг бэлтгэх болсон.

Гүржийн хилийн албаны

бүрэлдэхүүнийг сургах ажиллагаанд олон улсын зарим байгууллага, нөхөрсөг харилцаатай орнууд нь идэвхтэй тусалж олон улс дамнасан хүний наймаа, хууль бус цагаачлал, зэвсэг, хар тамхины наймаатай тэмцэх, эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх арга зүй, цацраг идэвхт хорт бодисыг илрүүлэх зэрэг чухал шаардлагатай байгаа чиглэлүүдээр мэргэжлийн дадлага чадварыг олгосон байна.

Одоо Гүржийн хилийн цагдаагийн албаны өөрчлөлт, шинэчлэлтийн ажил хараахан дуусаагүй байна.

Израйль: Израйлийн хилийн цагдаагийн үндсэн үүрэг нь хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловч алан хядах ажиллагаатай тэмцэх, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар армийн бүрэлдэхүүнд туслах үүргийг гүйцэтгэнэ.

Израйлийн нийслэлийн гудамжинд эргүүл хийж байгаа бараг цэрэг бүхэн нь хилийн цагдаагийн бүрэлдэхүүн байдаг ба нийт цагдаагийн тоо 6000 гаруй байна.

Хилийн цагдаагийн албанд 18 хүрсэн эрэгтэй, эмэгтэй иргэдийг ажиллуулах бөгөөд хилийн цагдаа нар нь байлдааны бэлтгэл, алан хядах ажиллагаа болон эмх замбараагүй байдалтай тэмцэх сургалтанд хамрагдаж, арабын хот, суурин, хөдөө нутагт алба хааж, хүн ам олноор суурьшсан газруудад нийгмийн аюулгүй байдлыг хангахын төлөө ажилладаг.

Эндээс үзвэл дэлхийн аль ч орны хил хамгаалалтын байгууллагын нэн тэргүүний үүрэг нь улсын хилийн халдашгүй дархан байдал, хил хязгаарын аюулгүй байдлыг эн тэргүүнд тавьдаг болох нь харагдаж байна.


Хилийн албаны сургуулийн захирал, доктор, профессор хурандаа Ц.Ганболд

КУРГАНЫ ХИЛИЙН ЦЭРГИЙН ДЭЭД СУРГУУЛЬД ДЭЭР ЯВАГДСАН ОПЕРАТИВИЙН СУРГАЛТЫН ТУХАЙ

2011 оны 5 сарын 16-18 ны хооронд ОХУ-ын {урганы Хилийн цэргийн дээд сургууль орчин үеийн агаарын тагнуулын нисэгчгүй нисэх хэрэгслүүдийг хэрхэн ашиглах талаар үйлдвэрлэгчдийн оролцоотойгоор сургалтын болон туршилтын зорилгоор оперативийн сургалт зохион байгуулсан байна.

Нислэгт ZALA 421-09, ZALA 421-04M болон ZALA 421-21 загварын төрөл бүрийн нисэгчгүй аппаратуудыг ашигласан бөгөөд дээрхи загварууд нь одоогоор ОХУ-ын Хилийн албанд хил хамгаалалтын зориулалтаар ашиглагдаж байгаа юм.

Энэ зорилгоор янз бүрийн ашиггай ачааллыг ашиглан цаг агаарын тохиромжтой нөхцөлд дунд зэргийн бартаа саадтай газар орон дээгүүр нисэх, агаарын тагнуулыг явуулах зэргээр өдрийн цагаар нийтдээ 8 удаа нислэг хийсэн байна.



Сургуулийн явцад Курганы ХЦДС-ийн багш нар болон сонсогчидтай дараах зорилгоор сургалт явуулсан бөгөөд тухайлбал нисэгчгүй нисэх хэрэгслийн тактик техникийн үзүүлэлттэй танилцах, тэдгээрийн хийцийн онцлогийг судлах, улсын хил хамгаалалтанд хэрхэн ашиглах, ямар боломж бололцоо байгааг тогтоох зорилго тавьжээ. Тэрчлэн нисэгчгүй нисэх хэрэгслийг удирдах операторуудаас ашиглалтын явцад түгээмэл гаргаж байгаа алдаа, эвдрэл гэмтэл, ослын шалтгаануудыг мэдээлжээ.

Сургууль дадлагын зорилгоор нислэгийн явцад цагийн байдлын янз бүрийн гэнэтийн нөхцөлд операторуудын ажиллагааны онцлогийг харуулсаны дээр өөрийгөө баримжаалах систем (GPS/ГЛОНАСС) байхгүй нөхцөлд хэрхэн ашиглаж болохыг харуулжээ. гэсэн мэдээллийг интернетээс авч орчууллаа.

Дээрхи мэдээлэл дээр нэмэлт болгон нисэгчгүй аппарат хэрэгслийн талаар хилчидийнхээ мэдлэгийг нь бататгах зорилгоор товч тайлбар нэмлээ.

Нисэгчгүй нисэх хэрэгсэл гэж бүхээгтээ нисэгчгүйгээр нисэхэд зориулсан хэрэгслийг хэлэх бөгөөд ангилахдаа:

Нисэгчгүй нисэх хэрэгслийг дотор нь удирдлагагүй нисэгчгүй хэрэгсэл, автомат ажиллагаа бүхий нисэгчгүй хэрэгсэл, зайнаас удирдлага бүхий нисэгчгүй нисэх хэрэгсэл /ННА/ гэж ангилна. Түүнээс гадна харилцан нарийн уялдаа бүхий үндсэн гол үзүүлэлт болох өөрийн бодит жин, нислэгийн үргэлжлэх хугацаа, нислэгийн алслалт, нислэгийн өндөр гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан дараах байдлаар ангилж үздэг.

- **Хэт жижиг** / одоогоор тухайлан нэрлэж тогтоогүй байгаа/ 10 кг хүртэл жинтэй бөгөөд 1 км хүртэл өндөрт 1 цаг хүртэл нисэх боломжтой

- **Бага хэмжээний** 50 кг хүртэл жинтэй, 3-5 км хүртэл өндөрт хэдэн

цагийн туршид нисэх боломжтой

- **Дунд зэргийн** 1000 кг хүртэл жинтэй, 10-12 цагийн туршид 9-10 км өндөрт тогтвортой нисэх боломжтой

- **Хүнд жинтэй** 24 цаг болон түүнээс дээш хугацаагаар 20 км хүртэл өндөрт нисэх боломжтой.

Бүх нисэгчгүй нисэх хэрэгслүүд нь байршил тодорхойлохын тулд сансрын хиймэл дагуулын хүлээн авах системээр давхар тоноглогдсон байна

Иргэний зориулалтаар ашиглагдах нисэгчгүй хэрэгслүүд нь:

- Ашиглахад эдийн засгийн үүднээс хэмнэлттэй

- Нисэгчгүй нисэх хэрэгслийг хэрэглэх хүрээ маш өргөн хүрээтэй байдаг гэж үзэж байгаа бөгөөд хоёрдох нь эхний хэсгийнхээ шууд үргэлжлэл болох юм.

Хил хамгаалах байгуулагын хувьд хамгийн тохиромжтой нь бага болон дунд оврын тактикийн зориулалт бүхий нисэх хэрэгслүүд бөгөөд ойрын үед МУ-ын хил хамгаалалтын техник хэрэгслийн эгнээг нэгэн шинэ төрлийн техникээр баяжуулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Багш Х.Гөлгөө

ХИЛЧИН БА ХУУЛЬ

Монгол улсын Хувийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан судалгаа

МХБХолбооны дэд тэргүүн, докторант Д.Чинзориг

Монгол улс 1992 онд батлагдсан Үндсэн хуулиараа эх орондоо хүмүүнлэг, иргэний Ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж тодорхойлоод нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хангах, дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалахыг тунхагласан билээ[1]

МУ-ын Үндсэн хуулийн 16 зүйлд Монгол улсын иргэний амьд явах эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, халдашгүй, чөлөөтэй байх болон бусад иргэний эрхийг тунхаглан, 11 зүйлд эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалаж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн гэж заасан.

Энэ үеэс ардчилсан чөлөөт зах зээлийн эдийн засаг бүхий шинэ улс төр эдийн засгийн тогтолцоонд шилжиж хувийн өмч, хувийн хэвшлийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, хуучин социалист өмчийг хувьчилсаны үр дүнд төр, байгууллага, аж ахуй нэгж, өөрсдийн өмчтэй болсон бөгөөд цаашид хувийн болон хувийн хэвшлийн өмч хөрөнгө, обьект, өмчлөгч, эзэмшигч иргэдийг гадны аливаа дарамт шахалт, халдлагаас хамгаалах бодит шаардлага бий болсон.

Ялангуяа 1995-2000 оны хооронд гарч байсан нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд гарсан өөрчлөлт шинэчлэлт, гэмт хэргийн нөхцөл байдал ялангуяа зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйлдэл, дарамт шахалтаас зарим бизнес эрхлэгч нар нь айдас, хүчирхийлэлд автан амьдарч байсан бөгөөд гадаадын харьяат иргэдийн хувьд ч бизнесийн аюулгүй орчин, өөрийн гэр бүлийнхээ гишүүдийн аюулгүй байдалд сэтгэл зовниж, хамгаалалт авах гэсэн ахуй амьдрал, нийгмийн захиалга, хэрэгцээ улам нэмэгдсэн юм.

МУ-ын Их хурлаас 2000 оны 01-р сарын 20-ны өдөр «Гэрээт харуул, хамгаалалтын тухай» хууль, 2001 оны 06-р сарын 07-ны өдөр «Хувийн хамгаалалтын тухай» хуулийг батлан гаргаж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгө, обьект болон иргэдийн амь бие, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах болсон юм.

Дээрхи хуулиуд тухайн цаг үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж батлагдан гарснаас хойш даруй 10 гаруй жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд Монгол орны улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааны хүрээнд томоохон өөрчлөлт, шинэчлэлт өрнөж улмаар иргэдийн оюун ухаан, бодол

---

1. Монгол улсын үндсэн хууль –"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

санаа, сэтгэл зүй, соёл боловсрол, хөдөлмөрийн харилцаа эрс өөрчлөгдсөн нь бодит байдал юм.

2001.11.30-ны өдөр МУ-ын УИХ-аас Гэрээт харуул, хамгаалалтын тухай хуулийн 8 зүйлд өөрчлөлт оруулан, найруулсан боловч хуулийн зорилго, үзэл баримтлалд зарчмын шинжтэй өөрчлөлт хараахан ороогүй байна.

Өөрчлөн найруулагдсан зүйлээр нь авч үзвэл хуулийн **3. зүйл** Хуулийн нэр томьёо, (Харуул, хамгаалалт, обьект, үйлчлүүлэгч, харуул, хамгаалалтын алба хаагч, харуул, хамгаалалтын байгууллага) **5 зүйлийн 5.1.-д** (аймаг, нийслэлийн ЦГазар, хэлтэс материалыг хянан үзэж, зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг шийдвэрлэдэг байсныг, Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн Цагдаагийн газар (хэлтэс)-т бүртгүүлнэ гэж өөрчилсөн.) **5.2. зүйл** (Харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Цагдаагийн газар, хэлтэс олгоно) гэсэн заалтыг хүчингүйд тооцсон, **7.2.** (30 хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, энэ тухай хариуг бичгээр мэдэгдэх), **8.2.1.** (Цагдаагийн байгууллагын бүртгэлийн болон татварын байгууллагаас олгосон гэрчилгээний он, сар, өдрийг гэрээнд тусгах) **9.1.2.** (Харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх) гэсэн заалтыг хүчингүйд тооцсон, **22.1.1.** (Бүртгүүлэлгүйгээр харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлсэн хуулийн этгээдийг 200000 – 250000 хүртэл төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлого, техник хэрэгслийг хураах) гэсэн өөрчлөлт оруулсан, **23. зүйл** (Харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох)[1] зэрэг өөрчлөлт орсон байна.

Хуульд орсон эдгээр өөрчлөлт нь Хамгаалалтын байгууллагын зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулахыг хөнгөвчилж өгсөн, түүнтэй нийцүүлэн, зарим зүйлүүдэд өөрчлөлт оруулсан боловч гэрээт хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой үзэл баримтлал, зарчим, зорилго, зориулалт, эрх, үүргийн зохицуулалтыг бүрэн хэмжээнд боловсронгуй болгоогүй юм.

Сүүлийн 10 гаруй жилийн ажлын дадлага туршлага, үйлчлүүлэгч нараас тавьж байсан санал, хүсэлт, гэрээний үндсэн дээр хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байсан нөхцөл, судалгаа хийсэн ажлын үр дүнгээс үзэхэд хамгаалалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг төстэй мэт боловч зохицуулж байгаа харилцаа нь:

1-дүгээрт МУ-ын Гэрээт харуул хамгаалалын тухай хууль үйлчлүүлэгчийн өмч хөрөнгө, обьект, **2-дугаарт** МУ-ын Хувийн хамгаалалтын тухай хууль, үйлчлүүлэгчийн амь бие, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах гэсэн хоёр бие даасан хууль болгож гаргасан нь ажил, амьдрал, бодит ахуйд төдийлөн нийцэхгүй өрөөсгөл зохицуулалттай хууль болсон гэж үзэхэд хүргэж байна

Хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ үзүүлэх явцад түүнийг хамгаалах ажиллагааг өмч хөрөнгөөс нь салангид авч үзэх, өмч хөрөнгө, обьектыг хамгаалах хамгаалалтын үйлчилгээг тэнд ажиллаж, амьдарч байгаа хүний амь бие, эрүүл мэндийн хамгаалалтаас ангид авч үзсэн нь амьдралд нийцэхгүй байна.

Дээрхи хоёр хуулийн бүлэг, зүйлийг харьцуулан үзэхэд адил төстэй зүйл нийтлэг боловч хуулийн зорилт, харилцааны зохицуулалт, нэр томьёо, сургалт явуулах эрх бүхий субьект, хамгаалалтын үйл ажиллагаанд оролцогч субьектуудын эрх, үүрэг өөр хоорондоо ялгаатай байгаа юм. Иймээс ОХУ-ын 1992 оны 3-р сарын 11-ны өдөр батлагдсан хувийн мөрдөлт болон, хамгаалалтын тухай хуулийн жишгээр

1 Монгол улсын Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль

«Хувийн хамгаалалтын үйлчилгээ гэдэг нь *хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаалах үйл ажиллагааг хэлнэ* гэж томьёолон хамгаалалтын үйл ажиллагааг дараах чиглэлээр явуулах нь» зүйтэй санагдана. Үүнд:[2]

1. Хувь хүн, иргэдийн амь бие, эрүүл мэндийг хамгаалах;
2. Үйлчлүүлэгчийн (хувь хүн, иргэд, аж ахуй нэгж байгууллага) өмч хөрөнгийг болон өмч хөрөнгийн тээвэрлэлтийг хамгаалах;
3. Үйлчлүүлэгчийн өмчлөл, эзэмшлийн обьектыг хамгаалах;
4. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, дохиоллын хэрэгслийг төлөвлөх, угсран суурьлуулах, тохируулах, ашиглах, хамгаалах (Аюулгүй байдал, хамгаалалтын зориулалттай техник, хэрэгсэл, технологийг төлөвлөх, угсран суурилуулах, тохиргоо хийх, ашиглах, үйлчилгээ үзүүлэх, галын болон хамгаалалт, дохиоллын систем, дүрс бичлэгийн хяналтын систем, холбоо мэдээллийн техник, хэрэгсэл, илрүүлэлтийн тоног төхөөрөмж, шалган нэвтрүүлэх техник хэрэгсэл... г.м)
5. Аливаа халдлагаас аюулгүй байдлаа хамгаалах чиглэлээр байгууллага, иргэдэд зөвлөх, зааварчлах, сургах, дадлагажуулах.
6. Олон нийтийг хамарсан арга хэмжээг хамгаалах, зохицуулах.

Хуулийн нэр томьёоны хувьд оновчтой, товч, тодорхой байхаар хамгаалалтын эрх зүйн хэллэг, томьёоллыг боловсруулан хэрэглэх нь оновчтой санагдаж байна. Үүнд:

1. Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа
2. Хамгаалалтын байгууллага
3. Үйлчлүүлэгч
4. Хамгаалалтын ажилтан
5. Шадар хамгаалагч (бие хамгаалагч)
6. Амь бие, эрүүл мэнд (хувийн аюулгүй байдал)
7. Өмч хөрөнгө
8. Обьект
9. Аюулгүй байдал, хамгаалалтын техник хэрэгсэл, технологи зэрэг хамаарна.

Гэрээг үндэслэн хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байгаа чиглэлээр нь хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой хуулийн нэр томьёоллыг боловсруулах шаардлагатай байна. Үүнд:

1. Аюулгүй байдлыг хангах
2. Албан байгууллагын хамгаалалт[3] (Ведомственная охрана) – өмч хөрөнгө, обьект
3. Шадар хамгаалалт (Амь бие, эрүүл мэндийг хамгаалах)
4. Шалган нэвтрүүлэх ажиллагааны хамгаалалт (Шалган нэвтрүүлэх дэглэм) (Нэвтрүүлэх ажиллагаа – пропускной режим) Access control system
5. Обьектын дотоод журмыг (дэглэм) сахиулах (Внутри обьектовый режим) Албан байгууллага, үйлчилгээний байгууллага (дэлгүүр, ресторан, үзвэр, үйлчилгээний газар, банк, санхүүгийн байгууллага болон бусад) дотоод журмыг сахиулах, хяналт тавих.
6. Дохиолол хамгаалалт
7. Дүрс бичлэгийн хамгаалалт
8. Периметрийн хамгаалалт

2 ,О частной детективной и охранной деятельности в Российской Федераций" Закон РФ от 11 марта 1992г

3 Федеральный закон РФ "О ведомственной охране" от 14 апреля 1999г

9. Цогц аюулгүй байдал системийн хамгаалалт (Integrate system)

Гэрээний үндсэн дээр хамгаалалтын үйл ажиллагаанд (үйлчилгээнд) оролцогч субьектуудын (хамгаалалтын байгууллага, үйлчлүүлэгч, хамгаалалтын алба хаагч, бие хамгаалагч) эрх, үүрэг, хариуцлагыг улам илүү боловсронгуй, тодорхой болгох. Үүнд:

1. Хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, хариуцлага

2. Үйлчлүүлэгчийн эрх үүрэг, хариуцлага (Хувь хүн, иргэн, аж ахуй нэгж, байгууллага)

3. Хамгаалалтын ажилтны эрх, үүрэг, хариуцлага

4. Бие хамгаалагчийн эрх, үүрэг, хариуцлага зэрэг хамаарна.

МУ-ын Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10 зүйлд «харуул хамгаалалтын алба хаагчийн сургалтын агуулга, төлөвлөгөөний талаар тусгаж, харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах,[4] мэргэжлийг нь дээшлүүлэх асуудлыг Цагдаагийн төв байгууллага хариуцна» Хувийн хамгаалалтын тухай хуулийн 10 зүйлд «хувийн хамгаалалтын сургалтын агуулга, төлөвлөгөөний талаар тусгаж сургалтын үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд эрхлэн явуулж болох бөгөөд түүний үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага хяналт тавина»[5] гэж тус тус хуульчилсан.

Аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлийн ажиллагаа өөрийн гэсэн онцлогтой байж, хамгаалалтын ажилтан, бие хамгаалагч нарт мэргэжлийн суурь болон эрх зүйн мэдлэг, ажил гүйцэтгэх арга ухаан, ур чадвар, харилцааны соёл, ёс зүй, ёс суртахуун, сэтгэл зүй, ой тогтоолт, гадаад хэл, бичиг, баримтын хөтлөлт болон бусад олон төрлийн чадвар эзэмшүүлэх шаардлагатай байна. Нэг ёсондоо хамгаалалтын ажилтан цагийн байдлыг зөв үнэлж, зөв шийдвэр гаргаж, зөв ажиллах чадвартай байх ёстой.

Гадаад орнуудын хууль болон бусад чиглэлийн сургалт явуулж байгаа эрх зүйн зохицуулалтыг судлаж үзэхэд аюулгүй байдал хамгаалалтын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн сургалт явуулдаг Их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд тусгайлан сургалт зохион байгуулж байна.

Манай улсад 2009 оны 2-р сард УИХ-аас "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" хууль батлагдан, мөрдөгдөж байгаа бөгөөд хамгаалалтын ажилтан, бие хамгаалагч нарын мэргэжлийг индексжүүлэн нэгэн төрлийн мэргэжил болгон бүртгүүлж, холбогдох сургалтыг мэргэжлийн сургалтын байгуулага гардан зохион байгуулах нь зүйтэй санагдана.

Харин сургалтын цаг, сэдвийн төлөвлөгөө, чанар, арга зүй, үйл ажиллгааны үр дүнд БСШУЯ, ХЗДХЯ болон Цагдаагийн байгууллага хяналт тавьж байх нь зохимжтой.

Хууль хяналтын байгууллага, хамгаалалтын ажилтан, бие хамгаалагчидад хориглох зүйлс, хязгаарлалтын тухайд илүү ойлгомжтой, ил тод, тодорхой байхаар тусгах, шаардлага байна.

Хамгаалалтын байгууллага, хамгаалалтын ажилтан бие хамгаалагчид ажил үүргээ гүйцэтгэх үедээ хамгаалалтын үйл ажиллагааны тухайн нөхцөл байдалд үнэн зөв үнэлэлт дүгнэлт өгч, зөв шийдвэр гаргаж, хуулийн хүрээнд ажиллахад үйлчлүүлэгчийн талаархи мэдээ, мэдээлэл цуглуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагааг үйлчлүүлэгчид болон бусад иргэн, аж ахуй нэгжийн тухай мэдээ, мэдээлэл цуглуулан, зөв шийдвэр гарган ажиллах шаадлагатай байдаг.

4. МУ-ын Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль. 2000 он

5,. МУ-н Хувийн хамгаалалтын тухай хууль. 2001 он

Гэмт хэрэг зөрчил гарсан үед гэмт хэргийн газрыг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн байж болох сэжигтэн, холбогдогч болон эд зүйлсийг эрэн сурвалжлах, гэрчийг олох, хэрэгтэний талаархи аман зураг гаргах, машин, техник болон бусад гэмт хэрэг үйлдэх үед ашигласан багаж хэрэгслийг эрэн сурвалжлах, олж тогтоох, үйлчлүүлэгч байгууллагын ажилтан нарын тухай мэдээлэл цуглуулах гэх мэт олон төрлийн ажил зохион байгуулах албаны шаардлага гардаг.

Ер нь ОХУ-н хувийн мөрдөлт болон хамгаалалтын тухай хууль хувийн мөрдөлтийн ажиллагаа (2- бүлэг), хувийн хамгаалалтын ажиллагаа, (3-бүлэг) хувийн мөрдөлт, хамгаалалтын холимог үйл ажиллагаа (4-бүлэг) гэж хуульчилсан нь оновчтой зохицуулалт бүхий хууль болсон гэж бодож байна. Магадгүй, та бүхэн энэ хуулийн эрх зүйн зохицуулалтын талаар өөр саналтай байж болно. Гэвч хамгаалалтын ажил гүйцэтгэх явцад ямар ч хуулиар хараахан зохицуулагдаагүй дээрхи ажиллагаануудыг гүйцэтгэх шаардлага тулгарч болно. Иймд хувийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд хуулийг шинэчлэн боловсруулахдаа хувийн мөрдөлтийн үйл ажиллагааг бие даасан бүлэг болгож оруулах саналтай байгаа юм.

Хэрэв ийм нийгмийн харилцааг зохицуулах бүлэг, зүйл тусгахгүй бол хамгаалалтын байгууллагаас явуулж байгаа зарим ажиллагаа хууль бус болж аль ч хуулиар зохицуулагдахгүй хэвээр үлдэх болно.

ОХУ-н хувийн мөрдөлт, хамгаалалтын тухай хуулийн 1-р бүлгийн 3-р зүйлд зааснаар мөрдөн сурвалжлах (сыск) ажиллагааг доорхи чиглэлээр явуулж байна. Үүнд:

1. Гэрээний үндсэн дээр иргэний харъяаллын хэргийн талаар мэдээлэл цуглуулах;

2. Ажил хэргийн хүрээнд мэдээлэл цуглуулах, зах зээлийг судлах, ажил хэргийн холбоотой төлбөрийн чадваргүй болсон болон найдваргүй түншийг илрүүлэх.

3. Бизнесийн байгууллагын бэлэг тэмдэг, нэр, худалдааны шошгыг хууль бусаар ашиглаж байгаа эсэх, шударга бус өрсөлдөөн, худалдааны, бизнесийн нууцлалыг задруулсан этгээдийг тогтоох.

4. Иргэдтэй хөдөлмөрийн болон бусад гэрээ, хэлцлийг байгуулж байх үедээ тэдний бичгээр гаргасан зөвшөөрлийг үндэслэн намтар болон бусад тэр хүнтэй хобоотой түүхчлэсэн мэдээллийг олж өгөх, туслах

5. Ор сураггүй алга бологсодыг эрэн сурвалжлах, олж тогтоох

6. Ажахуй нэгж, албан байгууллага, иргэний алдагдсан эд зүйлсийг эрэн сурвалжлах.

7. Эрүүгийн хэргийн оролцогч нарт гэрээний үндсэн дээр нотлох баримт, мэдээ, мэдээлэл цуглуулж өгөх[6]

Монгол улсад дээрх 7 чиглэлээр Хувийн мөрдөлтийн (мөрдөн сурвалжлах) үйл ажиллагаа явуулах эрх зүйн боломжийг хуулийн хүрээнд боловсруулан баталгаажуулах боломжтой цаг үе нь нэгэнт болсон гэж үзэж байна.

Тагнуул, цагдаа, цэрэг, хүчний бусад байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан зарим иргэд, санхүүгийн хувьд хүчирхэг болсон корпораци, компанид ажиллаж тэдний захиалгаар бизнесийн өрсөлдөгч иргэн, байгууллагын талаар мэргэжлийн зохих түвшинд мэдээ, баримт цуглуулан өгч байгаа нь илэрхий болж байна.

Нийгэм улс төр, эдийн засаг, зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүмүүсийн амьжиргаа, бизнесийн өрсөлдөөн, эрүүгийн нөхцөл байдал эрчимтэй өөрчлөгдөж байгаатай уялдан хүмүүсийн сэтгэлгээ, оюун санаа, тэдгээрийн

6 *Частная детективная и охранная деятельность. Третье издание. М., РИОР 2006*

хоорондох харилцаа байнга өөрчлөгдөж байна. Иймд хувийн мөрдөлтийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг хуулиар зохицуулж өгөх нь зүйтэй санагдана.

Галт зэвсэг, тусгай хэрэгслийн талаар "МУ-ын Гэрээт харуул хамгаалалт"-ын тухай хуулийн 18-зүйл, Галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журмын тухай тус хуулийн 19- зүйл, Нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх нөхцлийн тухай 20-зүйл, Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12-зүйлд нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тухай тус тус хуульчилсан байдаг ч цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай.

Галт зэвсэг, тусгай хэрэгслийн талаархи ойлголтыг илүү тодорхой болгож, тусгай хэрэгслийг дотор нь нэг бүрийн тусгай хэрэгсэл, хамгаалалтын тусгай хэрэгсэл, радио холбооны тусгай хэрэгсэл гэж ангилж хуулийн нэр томьёог илүү оновчтой болгож хуульчлах шаардлага байгаа юм.

Галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, албаны нохой, зэвсэггүй бие хамгаалах мэх хэрэглэх, ашиглах үндэслэл, журмын тухайд илүү нягт хандаж, нэмэлт өөрчлөлт хийх нь зүйтэй байна.

Хувийн хамгаалалтын үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа этгээдийн нийгмийн баталгаа, эрх зүйн хамгаалалт, хариуцлагын тухай асуудлыг хуульд оруулах нь зүйтэй юм. Ялангуяа эрүүл мэнд, нийгмийн даатгалын харилцаанаас гадна хамгаалалтын ажилтан албан үүргээ гүйцэтгэж байх үедээ амь бие, эрүүл мэндээрээ хохирч болзошгүй тул түүнтэй холбоотой даатгалын хураамжийг хувийн хамгаалалтын компаний захиргаа хариуцдаг талаар ОХУ-н хувийн мөрдөлт, хамгаалалтын тухай хуулийн 19-зүйлд тодорхой заасан байгааг ул суурьтай судлаж үзэх нь зүйтэй юм. Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа хууль тогтоомжинд нийцэж байгаа эсэхэд Цагдаагийн байгуулага, түүний аймаг, нийслэлийн газар, хэлтэс хяналт тавина. Нэг ёсондоо шалгалт, хяналт гэсэн хуулийн нэр томьёог ялгаж хуульчлах шаардлагатай.

Ер нь АНУ, Англи, Герман болон ОХУ-н хувийн мөрдөлт, хамгаалалтын тухай хуулийн чухал үзэл баримтлал, зарчим, хуулийн нэр, томьёог өөрийн орны уламжлал, зан заншил, хууль, тогтоомжтой нийцүүлэн нутагшуулж, хэрэглэх нь илүү оновчтой мэт санагдана.

ОХУ-д үйлчилж байгаа хамгаалалтын эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хуулиудыг судлан үзэхэд доорхи төрлийн хууль, эрх зүйн бичиг баримт үйлчилж байна. Үүнд:

- Аюулгүй байдлын тухай хууль, (Закон РФ "О безопасности" от 5 марта 1992г)
- Төрийн захиргааны байгууллагын хамгаалалтын тухай хууль, (Федеральный закон РФ "О ведомственной охране" от 14 апреля 1999г)
- Төрийн хамгаалалтын тухай хууль, (Федеральный закон РФ "О государственной охране" от 27 мая 1996г)
- Хувийн мөрдөлт, хамгаалалтын тухай хууль, ("О частной детективной и охранной деятельности в Российской Федераций" Закон РФ от 11 марта 1992г)

ОХУлсын Засгийн газрын 1992 оны 8-р сарын 14-ны өдрийн тогтоолоор батлагдсан ОХУлсын ДЯЯамны дэргэдэх Цэрэгжүүлсэн хамгаалалтын дүрэм (Положение о вневедомственной охране при – ОВД РФ)

Мөн хувийн мөрдөлт, хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой хуулийн заалтыг үндэслэн зохих хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 203. зүйл (статья.203. УК РФ)[7]

Хувийн мөрдөлт болон хамгаалалтын албад эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах

2. Захиргааны хариулцлагын тухай хууль (Кодекс об Административных нарушениях) 20.16. зүйл Хууль бус хувийн мөрдөлт болон хамгаалалтын үйл ажиллагаа явуулах, 20.24.зүйл Хувийн мөрдөлт болон хамгаалалтын үйл ажиллагаанд мэдээлэл олж авах зорилгоор зөвшөөрөгдөөгүй, хууль бус аргаар тусгай хэрэгслийг ашиглах

3. Галт зэвсгийн тухай хуулийн 4.зүйл Иргэний амь бие, эрүүл мэнд, өмч хөрөнгө, үнэт зүйлс, тэднийг тээвэрлэх үед ашиглах албаны зэвсгийн тухай заалт

4. Хувийн мөрдөлт болон хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам

5. Төрийн хамгаалалтанд байх обьектын жагсаалт

6. Хувийн мөрдөлт болон хамгаалалтын үйл ажиллагаанд хэрэглэх тусгай хэрэгслийн жагсаалт

7. Хамгаалалтын ажилтны ашиглах галт зэвсгийн төрөл, жагсаалт

8. Тусгай хэрэгслийг ашиглах, галт зэвсэг, сумтай харьцах, аюулгүйн ажиллагааны заавар гэх мэт маш олон хууль, дүрэм, журам, зааврыг боловсруулан, нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Дүгнэлт:

Иймд хувийн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуулийн зохицуулалтыг нэгдсэн цогц нэг хуулийн хүрээнд боловсруулан шийдвэрлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт хийж байна.

Санал:

1. Манай орны хувьд, хувийн хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг улам бүр төгөлдөржүүлэн боловсруулж, хуулийн нэр, томьёо, хамгаалалт үйлчилгээний чиглэл, хэлбэр, төрөл, ашиглах техник, хэрэгсэл, зорилго, зориулалт, үйл ажиллагаанд оролцогч этгээдийн эрх, үүрэг, хариуцлага, хамтын ажиллагаа болон бусад чухал харилцааны зохицуулалтыг тодорхойлж хуульд өөрчлөлт, нэмэлт оруулах, шинэчлэн найруулах шаардлагатай байна.

2. Өнөөдөр МУ-н "Гэрээт харуул хамгаалалтын тухай" хууль, "хувийн хамгаалалтын тухай" хуулийг нэгтгэн нэг хууль болгон боловсруулж, Монгол улсын гадаад болон дотоод нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүй боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлоготой уялдуулан Үндсэн хуулийн хүрээнд үндэсний аюулгүй байдлын тухай хууль, төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Цагдаагийн байгууллага, Тагнуулын байгууллага, Гүйцэтгэх ажлын тухай хууль болон бусад хуулийн хүрээнд холыг харсан хамтын ухаанаар боловсруулж шинэчлэх шаардлага байна.

3. Улс үндэстний гадаад, дотоод аюулгүй байдал, нийгэм, төр, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн аюулгүй байдал, халдашгүй дархан байдлыг найдвартай хамгаалах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, энэ талаархи хуулийн хэм хэмжээг хэрэгжүүлэхэд нийгэм, төр, иргэдийн хамтын ажиллагааг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

4. Хил дамнасан гадаад бодлогын хувьд ч хүн төрлөхтний бүтээсэн хууль зүй, хэл соёл, ШУ-ны ололтыг бүрэн ашиглаж, дэлхийн улс орнуудын туршлагаар хүн төрлөхтөний аюулгүй байдал хамгаалалтын ажилагааг бүрэн хангаж, хамтран ажиллах шинэ тогтолцоог бий болгох нь бид бүхний ирээдүйн зорилт юм.

5. Иймд аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагаатай

7 Частная детективная и охранная деятельность. Третье издание. М., РИОР 2006

холбоотой эрх зүйн зохицуулалтыг бие даасан салбар эрх зүйн хэмжээнд авч үзэх, улмаар бие даасан шинжлэх ухаан талаас нь судлан үзэж, ач холбогдлыг нь зөв тодорхойлон хөгжүүлэх, улмаар түүнийг хэрэгжүүлэх нь зүйтэй байна

Ном зүй:

Монгол хэлээр

1. *Монгол улсын үндсэн хууль, УБ, 1992*
2. *Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, 2000*
3. *Хувийн хамгаалалтын тухай хууль, 2001*
4. *Монгол улсын Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль*
5. *Үндэсний аюулгүй байдлын тухай хууль*

Орос хэлээр

6. *Кудрявцев.В.В Овчаров. А.В. Настольная книга частного охранника. М., 2005*
7. *Солянов.В.М. Черняев. В.В Частная охранная деятельность М., 2001*
8. *Заверняева.О.В Частная охранная деятельность. Сборник нормативных актов. М., 2005*
9. *Частная детективная и охранная деятельность. М., РИОР, 2006*
10. *Вэл.А.А. Справочник по частному сыску. М., 2007*



ДХИС-ийн ЭЭЗ тэнхимийн багш цагдаагийн ахлах дэслэгч Лувсангийн Бат-Очир

Л.Бат-Очир нь 1976 онд төрсөн, 1995 онд ТИС-ийн МИС-ийг автомашины цахилгаанчин, 2002 онд МҮДС-ийг эрх зүйч мэргэжлээр, тус тус төгсч, 2004 онд МУИС-ийн ХЗС-д Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан . 2002-2007 онд "Билиг" Дээд сургуулийн эрх зүйн тэнхимд багшаар ажиллаж байгаад 2008 оны 4-р сараас одоог хүртэл ДХИС-ийн Эрүүгийн эрх зүйн тэнхимд багшаар ажиллаж байна. Л.Бат-Очир нь 9 дэх жилдээ багшилж байгаа бөгөөд энэ хугацаанд эрүүгийн эрх зүй, криминологийн чиглэлээр 6 эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл дангаараа болон бусадтай хамтран сурах бичиг, нэг сэдэвт бүтээл 2 бичиж нийтийн хүртээл болгосон байна.

ХУУЛЬ БУСААР МОНГОЛ УЛСЫН ХИЛ НЭВТРЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖ

Монгол Улсын улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, улс орны хилийн халдашгүй дархан байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, гадаад, дотоод аюулгүй байдлыг хангахад эрүүгийн хууль чухал үүрэг гүйцэтгэдэг ба үүний нэг хэлбэр бол Эрүүгийн хуульд хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх, хилийн дэглэм зөрчих үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан явдал юм. Монгол Улсын Үндсэн Хууль[1] болон Улсын хилийн тухай хуульд[2] Монгол Улсын хил халдашгүй дархан байна гэж заасан нь тус улсын бүрэн эрхт байдлын баталгаа байталгаа байдаг учраас хэнд ч гэсэн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, зохих баримт бичиггүй хилээр нэвтрэх эрх байдаггүй.

Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийн бүрэлдэхүүн, тайлбар, зүйлчлэл

/Эрүүгийн хуулийн 89-р зүйл/

Объект нь: Монгол Улсын хил хязгаарын халдашгүй дархан байдал, Монгол Улсын хилээр орох, гарах, дамжин өнгөрөх талаар хуулиар тогтоосон журам байна.

Халдлагын зүйл нь: Монгол Улсын хил юм.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу,

1 .Монгол Улсын Үндсэн Хууль. 4.1-р зүйл. 1992 он.

2 .Монгол Улсын Хилийн тухай хууль.3-р зүйл.1993 он.

усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ.[3] Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна. Хилийн ус гэдэг нь улсын хилийн шугам дайран өнгөрч байгаа нуур, гол мөрөн, горхи, болон гадаргын бусад усыг хэлнэ. Улсын хилийн шугмын дотогш орших хилийн ус нь монгол улсын усны сангийн бүрдэл хэсэг болно[4].

Объектив тал нь :Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн идэвхитэй үйлдэл байна. Хор уршиг, шалтгаант холбоо нь энэ гэмт хэргийн заавал байх шинж биш юм.

Хууль бусаар хил нэвтрэх гэдэг нь:зохих паспортгүй, визгүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, эсхүл бусдын буюу хуурамч бичиг баримт ашиглах, мөн түүнчлэн хилийн шалган нэвтрүүлэх, байцаан өнгөрүүлэх боомтгүй газраар нууцаар Монгол Улсын хилээр орж ирсэн, гарч явсан, дамжин өнгөрсөн идэвхитэй үйлдэл байна. Хууль бусаар хил нэвтрэхдээ ямар арга, хэлбэрээр тээврийн хэрэгслээр эсхүл явганаар, уналга, хөсгөөр, нуугдаж гарсан, орсон, дамжин өнгөрсөн нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй юм. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрснээр төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, хэргийн ангиллын хувьд хүндэвтэр гэмт хэрэг юм.

Субъектив тал нь: шууд санаатай, ахуйн сэдэлтэй байна. Хил зөрчихдөө субъект тус улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдалд халдаж дайсагнасан үйлдэл хийх зорилгогүйгээр зөвхөн оршин суух, ажиллаж амьдрах ах дүү амраг садантайгаа уулзах гэсэн ахуйн сэдэлттэй байвал энэ гэмт хэрэг болно. Субъект нь ойд зүг чигээ алдах, техникийн сүйрэлд автсан, малын эрэлд явж байгаад төөрсөн, байгалийн давагдашгүй хүчинд автагдан хил зөрчсөн бол гэмт хэрэг болохгүй.

Мөнүзэлбодол,улстөрийнболон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсөн гадаадын иргэн, харъяалалгүй хүн орогнох эрх олж авах зорилгоор хууль бусаар манай улсын хил нэвтэрсэн нь үндэслэлтэй тогтоогдвол энэ зүйлд заасан гэмт хэрэг болохгүй.

Субъект нь :16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвар бүхий хэн ч байж болно.

Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт энэ хэргийг давтан болон урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн бол ял хүндрүүлэх нөхцөл байдал болно.

Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийн зүйлчлэл, анхаарах асуудал

Субъектын хүсэл зоригоос үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас хилээр нэвтэрч чадаагүй бол Эрүүгийн хуулийн 32-р зүйлийн холбогдох хэсгийг

3 Монгол Улсын Хилийн тухай хууль.3-р зүйл.1993 он.
4 Монгол Улсын Хилийн тухай хууль.4-р зүйл.1993 он.

журамлан 89-р зүйлээр зүйлчилэх ба хууль бусаар хил нэвтрэхэд шаардлагатай нөхцлийг санаатай бүрдүүлсэн бол Эрүүгийн хуулийн 31-р зүйлийн 1 дэх хэсгийг журамлан 89-р зүйлээр зүйлчилнэ. Хууль бусаар хил зөрчихдөө бусад хүмүүст хүч хэрэглэж хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулбал энэ зүйлийг 96, 96[1], 98, 99-р зүйлүүдийн аль тохирохоор, хилийн албаны албаа хаагчийг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн 91-р зүйлийн 2 дахь хэсгийн 12, 17-д болгоомжгүй алсан бол, 94-р зүйлд зааснаар давхар зүйлчилж хариуцлага хүлээлгэнэ.

Хууль бусаар хил зөрчиж эхэлсэн боловч субъектын хүсэл зоригоос үл шалтгаалах нөхцөл, байдлын улмаас төгсгөлд нь хүргэж чадаагүй, баригдсан бол Эрүүгийн хуулийн 32.1-ийг журамлан 89-р зүйлээр хариуцлага хүлээлгэнэ. Хууль бусаар хил зөрчих үйлдлийг таслан зогсоох гэсэн цагдаа, хил, тагнуул, гаалийн албаны ажилтнуудыг эсэргүүцэж, хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан бол Эрүүгийн хуулийн 89-р зүйлийг мөн хуулийн 230-р зүйлийн холбогдох хэсэгтэй давхар зүйлчилнэ.

Хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол эрүүгийн хуулийн 175-р зүйлээр зүйлчилнэ. Энэ гэмт хэрэг хил дээр үйлдэгддэг онцлогтой боловч 89-р зүйлд заасан гэмт хэргээс обьект, халдлагын зүйлээрээр ялгаатай байна. Гэхдээ субьект нь хилээр нэвтрэх зохих зөвшөөрөлтэй байдгийг анхаарах нь зүйтэй. Хэрэв субьект галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодис буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хил нэвтрүүлсэн бол эрүүгийн хуулийн 188-р зүйлийн холбогдох хэсгээр зүйлчилнэ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 240-р зүйлд заасан гэмт хэргээс төрлийн болон шууд обьект, обьектив тал, субьектив талаараа сэдэлт зорилгоороо ялгагдана. Эрүүгийн хуулийн 240-д заасан гэмт хэрэг нь гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих талаар тогтоосон журам байхаас гадна гэм буруугийн санаатай болгоомжгүй хэлбэрийн аль алинаар нь үйлдэгдэж болно.

Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийн хувьд захиргааны зөрчил яригдахгүй ба шууд гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй учир ЭБШХ-д зааснаар[5] тагнуулын байгууллагын мөрдөн байцаагч мөрдөн байцаалтын ажиллагаа явуулна. Харин захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар[6] хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах дараах зөрчлүүдийг хянан шийдвэрлэнэ. Үүнд:

-Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх талаар тогтоосон журам зөрчсөн

-Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр

---

5 .Эрүүгийн байцаан шийтгэх хууль.2002 он.27.1-р зүйл.

6 .захиргааны хариуцлагын тухай хууль.1993 он.5-р зүйл.

зорчих, түүнчлэн шилжин суурьших болон бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн

-Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын визийн талаар хууль тогтоомжид заасан журмыг зөрчсөн

-Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад зөвшөөрөл авах журмыг зөрчсөн буюу хуурамч баримт бичиг бүрдүүлж зөвшөөрөл авсан

-Улсын хилийн дэглэм зөрчсөн

-Улсын хил арчлан хамгаалах, хилийн ус болон шугам огтлон гарсан зам, холбооны байгууламж ашиглах,хил орчмын нутагт ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах журам зөрчсөн

-Улсын хилийн бүс,зурваст болон хилийн гарц, боомтод тогтоосон журам зөрчсөн зөрчлүүд хамаарна.

Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс

Сүүлийн үед хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэрэг жилээс жилд байнга өсч, гэмт этгээдүүдийн арга ажиллагаа улам нарийсах боллоо. Төрийн эсрэг бусад гэмт хэргийн бүтцэд энэ гэмт хэрэг бараг 80 орчим хувийг эзэлж байна. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалд [7] "Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлсэд хууль бусаар хил нэвтрэх, хилийн зөрчил гаргах явдлыг хамааруулан, үүнээс урьдчилан сэргийлэх арга замд улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах чадвартай үндэсний зэвсэгт хүчин, бусад цэрэгтэй байна гэж заасан хэдий ч төрийн зүгээс энэ талаар явуулж байгаа бодлого, авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа боловсронгуй бус, хууль бусаар хил нэвтрэх гэмт хэрэг гарахад хил хамгаалах чиг үүрэгтэй төрийн тусгай байгууллага, төрийн зарим эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд бодитойгоор оршин буй хоцрогдол, доголдол, дутагдлууд, манай улсын нээлттэй бодлогын үр дүнд гадаадын иргэд, ялангуяа хойд, өмнөд хөрш Хятад, ОХУ-ын талаас хил зөрчих явдал шууд нөлөөлж байна. Энд хилийн хамгаалалтын үйл ажиллагаанд хэрэглэж буй буу зэвсэг, хяналтын төхөөрөмж, бусад техник хэрэгсэл хоцрогдсон, нөхөн хангалт дутмаг, хил хамгаалах байгууллагын ажилтаны ёс зүй, боловсрол мэдлэг, амин хувийн үзэл, иргэдийн эх оронч бус үзэл, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хил хамгаалалтын өнөөгийн тогтолцоо боловсронгуй бус зэрэг бодит нөхцөл байдлуудыг дурьдаж болох юм.

Энэ тохиолдолд төр, засгийн холбогдох байгууллага шат шатандаа залуу үеийг эх оронч, цэвэр ариун ёс суртахуунтай, өнөөгийн нийгэмд бүх талын өрсөлдөх, амьдрах чадвар, арга дүйтэй, түүх, соёл үндэснийхээ зан заншил, дэвшилтэт уламжлалаа нандигнан өвөлж үйл ажиллагаандаа мөрддөг болгон хүмүүжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. Монгол Улсын баатар Н.Жамбаа гуай "Эх орны


7 .Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал.20, 21-р зүйл. 2011 он.

минь газар шороо руу харийнхан дайрч, хүн ардыг минь эзэгнэнэ гэж бодохоор өөрийн эрхгүй тэмцэх сэтгэл төрдөг юм билээ. ...Бидний газар нутаг биднийх л байх ёстой, бид ард түмнээ аварч, хамгаалах ёстой гэдэг бодол нөхдийн минь зүрхэнд хадаатай, бидний зүрх эх орныхоо төлөө үргэлж цохилж байсан болохоор л бид ялсан"[8] гэж дурсан ярьж байсныг энд дурдах нь хэтрүүлсэн явдал болохгүй бизээ. Иргэдийг эх орон, ард түмэн, төрж өссөн газар нутагтаа хязгааргүй хайртай, эх орныхоо тусгаар тогтнол, хил хязгаарын халдашгүй дархан байдал, сөөм газрынхаа төлөө халуун амь, бүлээн цусаа хайрлахгүй баатарлагаар тэмцэж ирсэн ахмад үеийн үлгэр жишээгээр хүмүүжүүлэх нь өргөн агуулгаараа улс орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэг чухал баталгаа болох юм.

Монгол Улсын хил халдашгүй дархан байг.

8 Ардрийн сонин №148

ХИЛИЙН ЗӨРЧИЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ



СОНСОГЧ Т.ДАВААДОРЖИЙН ИЛРҮҮЛСЭН ХИЛИЙН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ.

Төмөрбаатар овогтой Дааадорж нь 1993 оны 02-р сарын 14-нд Хэнтий аймгийн Дадал суманд төрсөн. 2000-2008 онд Хэнтий аймгийн Дадал сумын дунд сургуульд 8-р анги, 2008-2010 онд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Улсын Тэргүүний 81-р дунд сургуулийн 10-р ангийг тус тус төгсч 2011 оны 08-р сард Дотоод Хэргийн Их Сургуулийн Хилийн Албаны Сургуульд элсэн орсон.

Цагийн байдал:

Отрядын хариуцсан хэсгээр манай улсаар дамжин гуравдагч оронд гарах зорилгоор БНХАУ-ийн Зүүн өмнөд мужийн харъяат иргэд ганц нэгээрээ болон хэсэг бүлгээрээ тэнүүчлэх, төөрөх хэлбэрээр баримт бичгийн зөрчилтэй болон хуурмаглалтай хүмүүс боомтоор, боомт бус газраар улсын хил нэвтрэхийг оролдох зэргээр хилийн зөрчил байнга гаргадаг тул отрядын хариуцсан хэсэг бүхэлдээ хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлд ордог.

Хил хамгаалалтын зохион байгуулалт:

Энэ хугацаанд улсын хилийг ердийн байдлаар хамгаалж, цэргийн хяналтыг Эрээний чиглэлд төвлөрүүлж, холбоо, харилцан ажиллагааг утсан болон радио холбоогоор зохион байгуулж, томилогдсон манаанаы үүрэг гүйцэтгэлтийг шалгаж, үүрэг даалгавраар хангаж байв.

Хилийн зөрчлийн тухай мэдээ:

Хилийн албаны сургуулийн 1-р дамжааны сонсогч Т. Дааадорж нь ДХИС-ийн сургалтын төлөвлөгөөний дагуу Замын-ҮҮд дэх Хилийн 0108 дугаар тусгай ангийн Шалгалт Хамгаалалтын заставт танилцах дадлага хийх хугацаанд 2011 оны 10-р сарын 30-ны өдөр заставын цагийн манаанд үүрэг гүйцэтгэж байхдаа хилийн 816 дугаар тэмдэгтийн чиглэлээр гадаадаас дотоод руу чиглэсэн 1 хятад иргэний хил зөрчсөн үйлдлийг илрүүлэн заставтаа мэдэгдсэнээр, заставаас шуурхай бүлэг, хаалт манаа гарч хил зөрчигчийг саатуулсан байна.

Хил зөрчигчийг албаны сонор сэрэмж гарган илрүүлсэн сонсогч Т.Дааадоржийг урамшуулан Хилийн 0108-р тусгай ангийн захирагчийн тушаалаар дурсгалын зүйл, мөнгөн шагнал, албаны бэлэн байдлыг ханган ажиллаж, ДХИС-ийнхаа нэр хүндийг өндөрт өргөн, амжилт гаргасныг нь үнэлэн ДХИС-ийн захирлын тушаалаар тус тус шагнагджээ.

Заставын ажиллагааны үр дүн:

1.Заставын дарга цагийн байдлыг бодит үнэлнэсэн нь Улсын хил хамгаалах шийдвэр үндэслэлтэй гарах нөхцөл болсон.

2.Заставын жижүүр заставын цагийн манааний бүрэлдэхүүнийг тодорхой үүргээр хангаж, үүрэг гүйцэтгэлтийг байнга шалгаж байсан.

3.Заставын цагийн манаа үүргээ сонор сэрэмжтэй гүйцэтгэж, хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлд хяналтыг төвлөрүүлж, дуран харааны хэрэгсэл ашиглан, хяналтыг зөв явуулснаар хил зөрчигчийг цаг алдалгүй илрүүлж, заставын жижүүрт шуурхай мэдээлснээр хил зөрчигчийг саатуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

4.Заставын дарга, заставын жижүүр холбоо, мэдээлэл,харилцан ажиллагааг сайн зохион байгуулсан.

5.Шуурхай бүлэг, хаалт манаанууд урьдчилсан төлөвлөгөөний дагуу түргэн шуурхай ажилласан.

6.Заставын цагийн манаа сонор сэрэмжтэй үүргээ гүйцэтгэснээр хил зөрчигчөөс урьтах нөхцлийг бүрдүүлж, төв суурин газар орж хүндрэл учруулах нөхцөлийг хаасан зэрэг ололттой талуудтай байна.

ЗӨВЛӨМЖ

АЛХМАА БҮҮ ГОЛЦГООЁ, АЛХМАА ХАРИН ТООЛЦГООЁ.

Хэрэглээгүй авъяас зэвэрдэг, ашиглаагүй булчин агшдаг, тогтоол ус өмхийрдөг, салхигүй агаар мууддаг, түлхээгүй цаг зогсдог, ордоггүй хаалга гаждаг, зөөдөггүй бурхан суудаг гэнээ, айхтар ажээ. Алхахгүйгээр явж сурдаггүй, явахгүйгээр гүйж сурдаггүй, гүйхгүйгээр гүйцэж сурдаггүй, хөдлөхгүйгээр хөгжилд хүрдэггүй гэнэм, айхтар хэлжээ. Тэгэхээр ажлаа сайжруулахад, амжилтанд хүрэхэд алхам хийх хэрэгтэй байх нь, алхан алхсаар алдрын оргилд хүрдэг байх нь гэсэн багахан оршил хэлээд үүнийг үл өгүүлэн цааш өгүүлэх нь.

Өнгөрсөн жил, Хилийн цэргийн 78, Хилийн цэргийн дээд сургуулийн 77 жилийн түүхэнд тэмдэглэгдэх томоохон үйл явдал тохиосон нь, "Хил судлал"-ыг шинжлэх ухааны улсын бүртгэлд оруулж, Хил судлалаар мэргэшсэн бакалавр, магистр, докторуудыг бэлтгэх эрхийг, БСШУ-ны сайдын 2010 оны 5 дугаар сарын 20-ны 235 тоот тушаалаар Хилийн цэргийн дээд сургуульд баталгаажуулж өгсөн явдал юм. Ийнхүү Хил судлалын шинжлэх ухааныг Монгол оронд хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдлээ.

Одоо ажиллах л үлдлээ. Шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар юу ч хийхгүй байх нь технологижин даяаршиж буй өнөөгийн ертөнцөд ухралт төдийгүй мөхөл гэдгийг бүх шатандаа ойлгож ажиллах шаардлага тулгараад байна. Судалгаатай ажиллах хэрэгтэй байна. "Асуудлыг олно (олж харахыг судалгааны үр дүнгээр илрүүлэхийг хэлж байна) гэдэг түүнийг шийдвэрлэхтэй адил чухал, гэхдээ олох нь шийдвэрлэхээс төвөгтэй учир олох гэж (судалгаа шинжилгээ хийх гэж) хичээдэггүй" гэж Блез Паскал хэлсэн . Шинжлэх ухааныг "Бодит байдлын тухай үнэн зөв мэдлэг буй болгож, онолын хувьд цэгцлэх хүний үйл ажиллагаа" гэж тодорхойлдог .

Маш товчоор хэлбэл шинжлэх ухаан гэдэг судалгаа шинжилгээ, шинжлэх ухааны хандлага гэдэг хил хамгаалах албандаа, хариуцсан ажилдаа судалгаатай хандахыг л хэлээд байна .

Гэвч энэ ажлыг хаана хаанаа анхаарч, дооросоо санаачилж, дээрээсээ дэмжиж хамтдаа урагшлахгүй бол дан ганц эрдэмтэн судлаачдын идэвхи зүтгэл санал санаачилгаас шалтгаалахгүй нь ойлгомжтой.

Улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах гэвэл шинжлэх ухааны мэдлэгт суурилсан хамгаалалтад шилжих хэрэгтэйг, мэдлэгт суурилсан зохион байгуулалтын цоо шинэ менежмент шаардлагатайг, энэ зорилтыг хэрэгжүүлж байж хил хамгаалалтад чанарын өөрчлөлт гарахыг удирдлагын бүх шатандаа ойлгож мэдэрсэн цагт, өөрөөр хэлбэл хил хамгаалалтад шинжлэх ухааны хандлага төлөвшсөн тэр үед хил хамгаалах албаны үйл ажиллагаа шинэ шатанд гарах учиртай. Тэгээд ч шинжлэх ухаан технологийн дэвшил, хөгжлийн түлхүүр болсноор хүн төрөлхтөн энэ замаар эргэлт буцалтгүй урагшлах нь нэгэнт тодорхой болоод байна. Өөрөөр хэлбэл хэн нэгэн юм уу, хэсэг бүлэг хүмүүсээс үл хамаарах хөгжлийн зүй тогтол болчихлоо шүү дээ. Яг л хавар болж цөн түрэх шиг үзэгдэл явагдаж байна . Цөн түрлээ гэхэд голын эрэг дээр хэн хаана зогссоноос, хэн юу гэж хэлснээс үл хамаарч цөн түрнэ. "Түр, түр" гэж хашгирсан ч түрнэ, "бүү түр" гэж бахирсан ч түрнэ. Шинжлэх ухааны хөгжлийн эрч хүчийг үлгэрлэвэл иймэрхүү л байна . Манай хил хамгаалах байгууллагын ажилтан болгон судлаач болж, алба бүхэнд судалгаа шинжилгээ нэвтэрч байж, байгаа байдлаа бодитойгоор ойлгож цаашдаа яахаа урьдчилан харах чадвартай болно. Аливаа асуудалд

судалгаа шинжилгээгүй сохор таамгаар ханддаг хүн ирээдүйгээ урьдчилан харах нь битгий хэл одоогийн байдлаа ойлгохгүй бэдчин явсаар бүдчин унах нь энүүхэнд. Чухам ийм учраас хил хамгаалалтад хамааралтай нэгж, хэлтэс, алба, тасаг ажилтан бүхэн судалгаа шинжилгээтэй ажиллаж түүнийг албаа таних, алсаа харах, ажлаа сайжруулах хөшүүрэг болгон хэрэглэх хэрэгцээ гарч ирнэ. Эрдэм шинжилгээ судалгааг, энэ ажлын арга зүйд сургагдаж бэлтгэгдсэн хүмүүс хийх ёстой. Ийм хүмүүсээр удирдах бүрэлдэхүүнийг бэхжүүлэх талаар Хил хамгаалах байгууллагын удирдлагаас ч ихээхэн анхаарч, Хүний нөөцийн дүрмэндээ энэ талын заалт оруулж, албан тушаал ахиж дэвших шалгуур үзүүлэлт болгож байгаа нь сайн эхлэл, сайшаах санаачилга. Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2007 оны 6 дугаар сарын11-ний "Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн шалгуур үзүүлэлт батлах тухай" 201 тоот тушаалд зааснаар:

Шинжлэх ухааны доктор – эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

Доктор (PhD) - эрдэм шижилгээний ахлах ажилтан

Магистр – эрдэм шинжилгээний дэд ажилтан

Бакалавр – эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан байна гэжээ.

Манай төв штаб, хил хязгаарт хангалттай тооны доктор, магистр, бакалаврууд байгаа ба тэдний эгнээ жилээс жилд өргөжсөөр байна. Одоо л гэхэд ийм хүмүүс төв штабын бие бүрэлдэхүүний 82, хилийн отряд, ангиудын 30-40 хувийг эзэлж байгаа ба тэд өөрсдөө гардаж хийнэ, бусдыгаа судалгааны арга зүйд сургана, хүч нөөц хангалттай, цаашдаа ч нэмэгдэнэ. Батлан хамгаалах салбар, цэргийн шинжлэх ухаанаа хөгжүүлэхийн тулд, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнг, их сургуулиа түшиглэн байгуулж үйл ажиллагаа нь жигдрээд, хэдэн арваар биш хэдэн зуугаар тоологдох эрдэмтэн судлаачтай болжээ. Манайх ч гэсэн ингэж, 2002 оны 5 дугаар сарын 3-нд батлагдсан, Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн, гурав дугаар бүлгийн, 4 дүгээр зүйлийн 4.2-т зааснаар Хилийн цэргийн дээд сургуулиа, "шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулдаг, сургалт эрдэм шинжилгээний байгууллага болгож..." эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтдийнхээ хүчийг нэгтгэн зангидаж нэгдсэн удирдлагад оруулах хэрэгтэй санагдана. Тэгвэл яамаар байна, ямар алхам хиймээр байна гэж уншигч та асуух байх, тэгвэл:

- Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх бодлого боловсруулах;

- ХХЕГ-ын Эрдэм шинжилгээний байгууллагуудын хүчийг төвлөрүүлж, нарийн мэргэжлийн судалгаа хийх чадварлаг эрдэмтдээр бэхжүүлэх;

- Нэгэн дор төвлөрч, мэргэжлийн нэгдсэн удирдлагад орсон ЭШБ, эрдэмтдийн хүчийг ашиглан Хил судлалын шинжлэх ухааны үндсэн онол Улсын хил хамгаалалтын онол болон түүний бүрэлдэхүүн хэсэг болох Улсын хил хамгаалалтын ерөнхий онол, Хил хамгаалах урлагийн онол, Хилийн цэргийн байгуулалтын онол, Хилийн цэргийн удирдлагын онол, Хилийн цэргийн сургалт, хүмүүжлийн онол, Хилийн цэргийн ар тал хангалтын онол, Хилийн болон хил хамгаалалтын түүх зэрэг онолуудыг судлан боловсруулах ажлыг эхлүүлэх;

Хил судлал хичээлийг ХХЕГ-ын штаб, төвийн болон хилийн отряд, ангиудын сургалтын хөтөлбөрт үндсэн хичээл болгон оруулах, үүний тулд эхний ээлжинд:

БСШУ-ны сайдын тушаалыг хэрэгжүүлж, хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх зорилгоор ХХЕГ-ын ХЦДС, эрдэм шинжилгээний байгууллагууд, холбогдох хэлтэс, албад, отряд, ангиуд юу юу хийхийг тодорхой заасан ХХЕГ-ын даргын тушаал гаргаж энэ ажлын эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй байна. Алхмаа бүү голцгооё, алхам л харин хийцгээе.

Доктор, профессор Д.Нямдорж.

ХИЛЭЭС ТӨРСӨН УРАН БҮТЭЭЛ

Яруу найрагч Ш.Дулмаа

Торгон хилийн манаанд

Уул уулсын бараа алсын алсаас сүндэрлэн
Уужим хээрийн хөндийд өвлийн жавар сэнгэнэж
Унаган багын бодолд цэнгэл баяр бялхаж
Уугуул нутгийн үзэсгэлэн хилчний сэтгэл татна

Шүүдрийн мөнгөн дусал өвсний толгойд бөндийж
Шөнийн саран дээрээс өнгийн ширтэн байхад
Шүхэрлэн бөмбийх тэнгэрийн түмэн оддын доор
Шүлэг найраг бичмээр намуун сайхан цагаар

Ирмэх нүдээ цавчилгүй энхийн харуулд зогсч
Эх орныхоо төлөө шөнийн манаанд гарч
Эргэх дөрвөн цагт алсын бараа ажиж
Эгэл цэрэг би торгон хил дээр зогсоно

Эх орон чинь дуудаж байна.


Эх орон чинь дуудаж байна
залуусаа
Хөлд ороход чинь тулсан
газар дэлхий
Хүн болоход чинь
амьсгалуулсан агаар
Хүүхэд байхдаа цэцгэн дунд
нь өссөн тал

Хүслээ шивнэхэд чинь
хөөмийлж угтсан салхи нь
Нарны туяанаас нь татаж
боссон
Сарны гэрлээр нь нүүрээ
угаасан
Оддынх нь доор дуулж
өссөн

Модных нь дунд дурлаж
хайрласан
Эх орон чинь дуудаж байна.
Эргэж ирцгээ залуусаа...

ШИНЭ НОМ

МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ БА УЛСЫН ХИЛ




"Монгол улсын тусгаар тогтнол ба улсын хил" гэсэн нэртэй шинэ ном уншигчдын гар дээр очихоор хэвлэлтээс гарч байна. Энэ номыг эрдэмтэн Ш.Арвай туурвижээ.

Зургаан бүлгээс бүрдсэн энэхүү томоохон бүтээлд зохиогч төрт улс үүсэн байгуулагдснаас эдүгээ хүртэл хорин хоёр зууны хугацаанд төрөөс улсын хилийн талаар баримталсан бодлого, үйл ажиллагааны онцлог, үр нөлөө сургамжийг хил хамгаалах урлагын түүхийн хэлбэрт оруулан баялаг мэдээлэлд тулгуурлан бичсэнээр онцлогтой юм байна.

Бүтээлийн өмнөх үгийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн Газрын гишүүн, Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдорж бичжээ. Сайд " ... энэ бүтээл нь Монголд төрт улс байгуулагдсаны 2220 жил, Үндэсний эрх чөлөөний хувьсгал мандсаны 100 жил, Ардын хувьсгал ялсны 90 жилийн ойн хүрээнд Монгол Улсад Хууль зүйн дотоод хэргийн алба байгуулагдсаны 100 жилийн ойг угтан зохион байгуулж хэрэгжүүлэх олон арван бүтээлч ажлын нэг нь болж байгааг онцлон тэмдэглэжээ.

Сайд өмнөх үгийнхээ төгсгөлд "Монгол улсын хилчид улсын хилийг манаж, үндэсний аюулгүй байдлыг хил, хязгаарт хангах үүргийг нэр төртэй гүйцэтгэж байна. Үүнийг улам чанаржуулж XXI зууны онцлог, олон улсын шаардлагад нийцүүлэн тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэстэй, өөрийн улсын уламжлалт сургамж, туршлагатай хослуулан шийдвэрлэн хэрэгжүүлэхэд доктор (Sc.D) Арвайгийн энэхүү бүтээл, дахин хувь нэмрийг оруулах болно" гэж өндөр үнэлжээ.

Бүтээлд орсон зарим зураг, түүхэн эх баримтыг толилуулая !



Их монгол улсын зураг

ХИЛ СУДЛАЛ

ДХИС-ийн Хилийн Албаны Сургууль, Монголын Хил Судлалын Үндэсний нийгэмлэгийн онол- мэдээллийн сэтгүүл

Сэтгүүлийн зөвлөл:
Дарга: master (US),
профессор, хурандаа Д.Дашдаваа.

Хариуцлагатай эрхлэгч:
ОУМА-н академич, доктор, тэргүүлэх профессор Г.Давгажамц

Нарийн бичгийн дарга:
ОУМА-н академич, доктор,
профессор, хурандаа Ц.Ганболд.

Гишүүд:
Доктор, профессор А.Муратхан
Доктор, профессор Д.Нямдорж
Магистр С.Лхагвасүрэн
Магистр Х.Гөлгөө

Эхийг бэлтгэсэн:
дэслэгч Б.Пүрэвсүрэн
дэд ахлагч С.Гаваасүрэн

Хэвлэлийн хуудас 11.0
Хэвлэсэн тоо 300 ш

Үүсгэн байгуулагч:
ОУМА-н академич, доктор,
тэргүүлэх профессор Г.Давгажамц

Нийтлэлийн хариуцлагыг зохиогч өөрөө хүлээнэ.
Нийтлэлээс иш татахдаа сэтгүүлийн нэрийг заана.
Сэтгүүлийг хувилан олшруулахыг хориглоно.
Сэтгүүлд ирүүлсэн болон нийтлүүлсэн зүйлийн эхийг буцаахгүй

Манай хаяг
Баянзүрх дүүрэг Хилчний гудамж,
ДХИС-ийн Хилийн Албаны Сургууль
Утас 70155010, 99145087, 99061374
Факс 976-70155010.
И- мэйл: Ganbold_bti@yahoo.com

Улсын бүртгэлийн дугаар 921
Индекс 14921
Дансны дугаар
ХААН БАНК 502951673-5

ТЭМДЭГЛЭЛ